



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН



ННА 67.408

ДАА 345

Ш-978

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

Мониторингийн тайлан

Судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн:

С.Болормаа	Х.Адилмаа	А.Гүндэгмаа
З.Сүхбаатар	Ц.Гончиг	Б.Үржинсүрэн
С.Сүхбаатар	Б.Энхтүвшин	О.Ууганцэцэг
О.Одончимэг	М.Батчимэг	В.Отгонжаргал
Б.Халиун	Б.Аюуш	

© Нээлттэй Нийгэм Форум, 2024

Хаяг: Жамьян гүний гудамж

Сүхбаатар дүүрэг

Улаанбаатар 14240

Утас: 976-76113207

Веб: <http://www.forum.mn>

И-мэйл: osf@forum.mn

Энэхүү судалгааны дүгнэлт, санал нь хийж гүйцэтгэсэн судлаачдын байр суурь бөгөөд Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ISBN 978-9919-9083-7-9

ГАРЧГИЙН ЖАГСААЛТ

ӨМНӨХ ҮГ	4
УДИРТГАЛ.....	6
НЭГ. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНДСЭН АСУУДАЛ ...99	
1.1. Шүүхийн шийдвэрийн ил тод байдал, түүний ач холбогдол.....	11
1.2. Шүүхийн шийдвэрийн ил тод байдлын эрх зүйн орчин.....	14
1.3. Шүүхийн шийдвэрийг нийтэлж буй практик	22
ХОЁР. ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ИЛ ТОД БОЛГОЖ БАЙГАА ӨНӨӨГИЙН БАЙДАЛ25	
2.1. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн ил тод байдлын тоон судалгаа	28
2.2. Шүүхийн шийдвэрийг ил тод байдлын чанарын судалгаа	29
Дүгнэлт, зөвлөмж	35
Хавсралт 1. Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхээр үйлчлүүлж буй иргэдийн дунд шүүхийн цахим сангийн ил тод байдлын талаар явуулсан асуулгын дүн.....	38
Хавсралт 2. Шүүхийн шийдвэрийн цахим сангийн талаар ярилцлагын аргаар хийсэн судалгаа	44
ГУРАВ. ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ИЛ ТОД БОЛГОЖ БУЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	50
3.1 Шүүхийн шийдвэрийн тоон судалгаа	53
3.2 Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулахдаа нууцлалыг хангасан байдал.....	55
3.3. Шүүхийн шийдвэрийн цахим сан хөтлөгчдийн судалгаа.....	66
Дүгнэлт, зөвлөмж	70
ДӨРӨВ. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ИЛ ТОД БОЛГОЖ БУЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	74
4.1. Шүүхийн шийдвэрийн тоон мэдээлэл.....	77
4.2. Асуулгын судалгааны үр дүн	82
Дүгнэлт, зөвлөмж	87
ТАВ. ГАДААД УЛСЫН ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	90
5.1. Шүүхийн шийдвэрийг нийтэлж буй практик.....	91
5.2. Шүүхийн шийдвэрийг цахимаар нийтлэх бодлого.....	93
5.3. Шүүхийн шийдвэрт дурдагдсан мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгох (anonymization).....	98
НЭГДСЭН ДҮГНЭЛТ	105
САНАЛ, ЗӨВЛӨМЖ	108

ӨМНӨХ ҮГ

Нээлттэй Нийгэм Форумын Эрх зүйн хөтөлбөр нь шударга ёсны салбарт нээлттэй, ил тод байдал, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр холбогдох байгууллагуудад олон талын дэмжлэг үзүүлж ирлээ. Шүүхийн шийдвэрийн цахим сангийн эхлэл тавигдаж, нийтэд мэдээлэл түгээдэг болоод 10 жилийн нүүр үзсэн хэдий ч шүүхийн шийдвэрүүд цаг хугацаандаа нийтийн хүртээл болж тэр бүр чадахгүй байна. Монгол Улсын нийт шүүхийн хэмжээнд хэрэг хянан шийдвэрлэсэн шийдвэрийн тал нь тухайн жилдээ багтаж мэдээллийн санд орохгүй байгаа нь мэдээллийн ил тод байдал бүрэн хангагдаагүйг илтгэнэ.

Нээлттэй Нийгэм Форумын Эрх зүйн хөтөлбөр нь шударга ёсны салбарт нээлттэй, ил тод байдал, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр холбогдох байгууллагуудад олон талын дэмжлэг үзүүлж ирлээ. 2023 онд энэхүү чухал мэдээллийн сангийн мэдээллийн бүрэн бүтэн болон нээлттэй байдалд мониторинг хийх төслийг санаачлан, орон нутгийн төрийн бус байгууллагууд, бие даасан судлаачид, хууль зүйн сургуулийн багш эрдэмтэд зэрэг олон талын туршлага, чадавхтай багуудыг дэмжин, харилцан мэдээлэл, туршлага солилцох, хамтран суралцах боломж, нөхцөл бүрдүүлэхийг хичээж ажиллалаа.

Эрүүгийн шүүхийн шийдвэрүүдэд мониторинг хийсэн төвийн бүсийн төрийн бус байгууллагуудын түншлэл, иргэний шүүхийн шийдвэр дээр ажилласан орон нутгийн залуу судлаачдын баг, захиргааны шүүхийн шийдвэрүүдийг авч үзсэн МУИС-ийн ХЗС-ийн эрдэмтэн багш нарын баг тус бүр өөрийн тодорхойлсон хүрээнд мэдээлэл цуглуулж мониторингийн тайлан боловсрууллаа. Энэхүү тайлан нь салбар эрх зүйн хүрээнд шүүхийн шийдвэрийн ил тод байдлыг хангахтай холбоотой тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх арга замын талаарх санал зөвлөмжийг нэгтгэн толилуулж буйгаараа онцлог юм.

Мониторингийн судалгааг хариуцаж гүйцэтгэсэн “Иргэний нийгмийн байгууллагуудын хамтын хүч” ТББ-ын Б.Аюуш ахлагчтай баг, МУИС-ийн ХЗС-ийн Практик сургалтын төвийн эрхлэгч С.Болормаа ахлагчтай баг, Хөвсгөл аймгийн залуу хуульч, судлаач Х.Адилмаа ахлагчтай багийнханд талархал илэрхийлж, цаашдын судалгаа шинжилгээний үйлсэд амжилт хүсье.

Бидний энэхүү хамтын бүтээл Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхийн захиргааны ажилтнуудад ач холбогдолтой эх сурвалж болно гэж найдаж байна.

*Нээлттэй Нийгэм Форумын
Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал*

УДИРТГАЛ

Шүүхийн шийдвэрийн нээлттэй сан үүсгэж, иргэд судлаачдад чөлөөтэй танилцах боломж олгосон нь 2012 оны шүүхийн тухай багц хуулиар бий болсон чухал дэвшил юм. Мэдээллийн ил тод байдлыг хангахад түүнийг хэрэглэх, шаардах соёл, дадал бий болох нь чухал. Нээлттэй Нийгэм Форумын Эрх зүйн хөтөлбөрийн хүрээнд 2018 оноос шүүхийн шийдвэрийн судалгаа, 2021 онд анх хэрэгжүүлсэн шүүхийн шийдвэрийн цахим сангийн мониторингийн төсөл нь шүүхийн шийдвэрийг судалгааны эргэлтэд оруулах, цахим сангийн мэдээллийн ил тод, бүрэн дүүрэн байдлыг шалгах, шаардах гол хөшүүрэг болж ирснийг дурдах нь зүйтэй.

Энэ удаагийн мониторингийн төсөл нь шүүхийн шийдвэрийн цахим сангийн мониторинг хийх арга зүйг судлаач, иргэний нийгэмд эзэмшүүлэх зорилгоор эрдэмтэн судлаач, иргэний нийгмийн төлөөлөл, нийслэл хот, орон нутгийн шүүхийн төлөөлөл, эрүү, иргэн, захиргааны шүүхийн шийдвэр тус бүрийг хамруулан илүү өргөн хүрээнд шүүхийн шийдвэрийн цахим сангийн мэдээлэлд, түүнийг бүрдүүлэх үйл явцад дүн шинжилгээ хийж, сайжруулах чиглэлээр санал зөвлөмж боловсрууллаа.

ННФ-аас 2021 онд хэрэгжүүлж, 2022 онд танилцуулсан Монгол Улсын Шүүхийн индекс судалгааны үндсэн зургаан хэмжигдэхүүний нэг нь “Шүүхийн нээлттэй, ил тод байдал” бөгөөд 2021 оны байдлаар тус хэмжигдэхүүн 62,3 оноогоор хамгийн өндөр үнэлгээтэй хэмжигдэхүүн болсон бөгөөд шүүхийн шийдвэрийн ил тод байдал дэд хэмжигдэхүүн 72,35 оноо авсан нь нийт 42 дэд хэмжигдэхүүн дотроос 4-т орох эерэг дүн хэдий ч 2013 оноос хойш хэрэгжсэн шүүхийн шийдвэрийн цахим сан, шийдвэр нийтлэлийн хувьд харьцангуй муу үзүүлэлт юм.¹

¹ Монгол Улсын Шүүхийн Индекс 2021, ННФ, 2022.
<https://judindex.forum.mn/general-point>

2021 онд Хөгжлийн эрх зүйн төв судалгааны байгууллага ННФ-ын дэмжлэгтэйгээр шүүхийн шийдвэрийн цахим сангийн үйл ажиллагаанд судалгаа хийсэн нь шүүхийн шийдвэрийн ил тод байдлыг хөндлөнгөөс үнэлэх анхны оролдлого байлаа. Тус судалгаагаар 2020 оны хувьд эрүүгийн хэргийн 84.2, иргэний хэргийн 14.7, захиргааны хэргийн 56,7 хувийг тус тус цахим санд байршуулсан байдалтай байгаа бөгөөд шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах зохион байгуулалт, үйл ажиллагааг боловсронгуй болгох, шүүхийн шийдвэрийг хууль тогтоомжид заасан шаардлагад нийцүүлэн, хугацаанд нь бүрэн байршуулах, цахим санг хэрэглэгчид ээлтэй болгох болон эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр хэд хэдэн зөвлөмж санал болгосон юм.²

2023 оны 5 сараас эхлэн гурван баг тус тусдаа мониторингийн үйл ажиллагааг сонгон авсан шүүх, хэрэг маргааны хүрээнд хийж, статистик мэдээ, ярилцлага, ажиглалтын аргыг ашиглан мэдээлэл цуглуулж тус бүр тайлан боловсруулж ирүүлснийг эмхэтгэн нэгдсэн тайлан байдлаар танилцуулж байна.

Мониторингийн судалгааг МУИС-ийн ХЗС-ийн Практик сургалтын төвийн багш нарын баг, Хөвсгөл аймгийн залуу судлаачдын баг, Орхон аймгийн иргэний нийгмийн байгууллагуудын “Хамтын хүч” түншлэл өөр өөрийн сонгон авсан фокус, цар хүрээгээр цахим сангийн үйл ажиллагааг судлан бие даасан тайлан боловсруулж ажиллалаа. Энэхүү нэгдсэн тайлангийн Нэг, Хоёр, Тавдугаар бүлгийг МУИС-ийн ХЗС-ийн Практик сургалтын төвийн багш нар боловсруулсан бол Гуравдугаар бүлэгт Х.Адилмаа ахлагчтай орон нутгийн судлаачдын баг, Дөрөвдүгээр бүлэгт “Хамтын хүч” ИНБ-ын түншлэлийн хэрэгжүүлсэн мониторингийн тайланг багтаасан болно.

2023 оны 6-10 сард буюу нийт дөрвөн сарын хугацаанд 2021, 2022 оны цахим сангийн мэдээлэлд нэгдсэн арга зүйн дагуу мэдээлэл цуглуулж ажилласан бөгөөд уншигчдад шүүхийн ил тод байдал, түүнийг бусад

² Шүүхийн шийдвэрийн ил тод байдал, Шүүхийн шийдвэрийн цахим санд хийсэн судалгааны тайлан, ННФ, 2022.


https://cdn.greensoft.mn/uploads/users/3092/files/Report%20on%20shuukh_mn_web.pdf

улсад хэрхэн хангаж байгаа талаар харьцуулсан судалгаа зэргээр баяжуулан нэгдсэн тайлан хэлбэрээр уншигчдад хүргэж байна.

Багууд мониторингийн судалгааны хүрээнд тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийхийн зэрэгцээ практикт тулгамдаж байгаа асуудал, түүнийг даван туулах шийдлийг эрэлхийлсэн ярилцлага, асуумжийн аргыг ашиглан чанарын мэдээлэл цуглуулж нөхцөл байдалд дүн шинжилгээ хийлээ.

Эрүү, иргэн захиргааны шүүхийн хувьд хэрэг маргааны тоо, ачааллаас шалтгаалан тоон мэдээллийн хувьд нэлээн зөрүү гарч байгаа ч ажлын зохион байгуулалтын хувьд нийтлэг бэрхшээл тулгарч байгааг дурдах нь зүйтэй.

График 1: Мониторингд хамаарах шүүхийн шийдвэрийн нийтлэл³



³ Энэ нь мониторингийн хүрээнд сонгон авсан шийдвэрийн төрөл болон шүүхийн хүрээнд авагдсан тоон мэдээлэл бөгөөд нийт шүүхийн статистик биш болно. Дэлгэрэнгүй тайлбарыг холбогдох бүлгээс харна уу.

НЭГ. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНДСЭН АСУУДАЛ

Шүүх бол “Монгол Улсын Үндсэн хууль болон энэ хуульд заасны дагуу байгуулагдан хэрэг, маргааныг хянан шийдвэрлэж, заавал биелүүлэх шийдвэр гаргадаг шүүгч, шүүх бүрэлдэхүүн”⁴ юм. Шүүх нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах эрхэм зорилготой тодруулбал, “шүүхийг хүмүүс засаг төрийн эрх баригчдын төлөө биш харин өөрсдийн эрх, ашиг сонирхлыг хангаж, аж амьдралынхаа хэвийн нөхцөлийг сахин хангуулахын төлөө л байгуулдаг”⁵ болно. Шүүх процессын хуульд заасан журмыг баримталж материаллаг хуулийг хэрэглэх замаар хэрэг, маргааныг эцэслэн шийдвэрлэж, түүний үр дүнд захирамжилсан шинжтэй нэг бүрчилсэн эрх зүйн акт буюу шийдвэрийг Монгол Улсын нэрийн өмнөөс гаргадаг. Шүүхийн шийдвэр нь “материаллаг хуулийг хэрэглэх үндсэн дээр гарсан, тухайн харилцаанд оролцож буй субъектүүдэд хэрэглэж буй хуулиа тайл барлан өгч буй акт, өөрөөр хэлбэл, казуаль (тухайн казуст буюу маргаанд оролцогчдод өгч буй) тайлбар мөн”⁶ бөгөөд “...зөрчигдсөн буюу маргаантай эрхийг сэргээх, түүнийг зохих ёсоор хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхээс гадна хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч болон нийт иргэдэд хүмүүжлийн үр нөлөө үзүүлэх зорилготой”⁷ болно.

⁴ Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалт.

⁵ Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал: хүний эрх, шүүх эрх мэдэл. Хоёрдугаар дэвтэр. УБ.2004., 120 дахь тал.

⁶ Ц.Сарантуяа. Үндсэн хуулийн шүүх ба захиргааны хэргийн шүүх: уялдаа холбоо, харьцуулалт. Захиргааны хэргийн шүүх: Монгол дахь шинэтгэл, дэлхийн улсуудын жишиг. УБ.2004., 63 дахь тал.

⁷ Монгол Улсын Дээд шүүхийн тогтоол. Шүүхийн шийдвэрийн тухай (2006 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр дугаар 21), (Ж.Амарсанаа нар). Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхэтгэл (1959-2010). УБ.2013., 710 дахь тал.

Түүнчлэн шүүхийн шийдвэр нь “шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч эрх бүхий төрийн байгууллагаас гаргадаг, эрх зүйн харилцааг тодорхойлох, түүнийг зохицуулсан хэм хэмжээг хэрэглэх хэлбэрээр тухайн хэрэг маргаанд хамааралтай этгээдэд хуулиар тодорхойлогдсон төрийн хүсэл зоригийг илэрхийлдэг акт”⁸ заавал биелэгдэх ёстой шийдвэр байдаг.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд зааснаар шүүх захиргааны зөрчил, хэрэг, маргааныг хянан хэлэлцээд (1) анхан шатны шүүх шийтгэх ба цагаатгах тогтоол, шүүхийн шийдвэр, шүүгч шийтгэвэр, (2) давж заалдах шатны шүүх магадлал, (3) хяналтын шатны шүүх тогтоол гаргана.

Шүүхийн шийдвэр нь хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагыг хангасан байна. “Хэрэг, маргааны талаар материаллаг болон процессын эрх зүйн хэм хэмжээг тэдгээрийн агуулга, зорилгод нийцүүлэн, шүүхээс оновчтой, зөв хэрэглэсэн тохиолдолд шүүхийн шийдвэрийн хууль ёсны байх шаардлага хангагдах”⁹ бол, “хэрэгт хамааралтай бөгөөд хуульд заасан арга хэрэгслээр олж авсан, хэрэгт авагдсан ба шүүх хуралдаанаар хэлэлцэгдэж, шүүхээр судлан шинжлэгдсэн нотлох баримтаар хэрэгт ач холбогдол бүхий бүх нөхцөл байдал тогтоогдсон хийгээд эдгээр нөхцөл байдлын талаар шүүхийн бүрэн, бодитой дүгнэлтийг агуулсан шийдвэр үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг хангана”¹⁰ гэж үздэг.

⁸ Мөн тэнд.

⁹ Мөн тэнд.

¹⁰ Мөн тэнд. 711 дэх тал.

1.1. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТҮҮНИЙ АЧ ХОЛБОГДОЛ

Шүүхийн шийдвэрийн ил тод байдлын талаар тухайлан авч үзэхийн өмнө “ил тод” гэдэг хоршоо үгийн хэл зүйн болон хууль зүйн утгыг тодруулах хэрэгтэй. Монгол хэлний хоршоо үгийн тольд “ил тод”-ыг “илэрхий, нүдэнд харагдахаар”¹¹ гэсэн утгатай гэж хэл зүйн үүднээс тайлбарласан бол Академич С.Нарангэрэл Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичигтээ “ил тод байдал” гэдгийг “нийгэмд ач холбогдолтой процедур ба үйл явцыг (төлөөлөгчдийн ба гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, шүүх, нутгийн өөрийн удирдлагын байгууллага, холбогдох байгууллагыг сонгох буюу бүрдүүлэх журам, хуулийн төслийг хэлэлцүүлэх, янз бүрийн маргааныг хянан шийдвэрлэх, төрийн бус байгууллагын үйл ажиллагаа зэрэг) дээд зэргээр нээлттэй байлгах ба тэдгээрийн талаар хүн амд өргөн мэдээлэхийг тэмдэглэсэн эрх зүйн ерөнхий нэр томъёо”¹² гэж тайлбарласан байна. Үүнээс үзвэл ил тод байдал нь (1) ил буюу нээлттэй байлгах, (2) үүнийгээ нийтэд мэдээлж байх агуулгыг илтгэж байна.

Шүүхийн шийдвэрийн ил тод байдал нь шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлын гол чухал хэсэг нь тул шүүхийн шийдвэрийг уншиж сонгох, хэргийн оролцогч, бусад оролцогчдод гардуулах, цахим хуудсанд байршуулах зэргээр ил тод байдлыг хангаж байна. Үүнээс гадна шүүхийн шийдвэрийн агуулгыг тоймлон нийтэд танилцуулах, сонгож хэвлэн нийтлэх, дүн шинжилгээ хийх байдлаар ил тод байдлыг хангах болжээ.

Шүүхийн шийдвэр нь шүүх эрх мэдлийн үйл ажиллагааны үр дүнг илэрхийлэх тул ил тод байх ёстой бөгөөд энэ нь олон талын чухал ач холбогдолтой юм. Тухайлбал:

1. Захиргааны үйл ажиллагаа хуульд нийцэж, шударга хэрэгжиж байгаа эсэхэд хяналт тавих боломжийг бүрдүүлэх;

¹¹ Э.Уранбилэг. Монгол хэлний хоршоо үгийн толь (Монсудар), УБ.2013., 169-170 дахь тал.

¹² С.Нарангэрэл. Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг. Анхны хэвлэл. УБ. 2021., 176 дахь тал.

2. Хэргийг хуульд заасан журмын дагуу шударгаар хянан шийдвэрлэж байгаа эсэхэд тавих хөндлөнгийн хяналтыг бодитой болгох;
3. Иргэн, хуулийн этгээд, захиргааны байгууллага шүүхэд мэдүүлэх эрхээ эдлэхдээ хууль хэрэглээний талаар ойлголт, баримжаа авах гарын авлага болох;
4. Хэргийн оролцогч, бусад оролцогчийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх боломжийг бүрдүүлэх;
5. Хууль хэрэглээний нэгдсэн практикийг тогтооход харгалзан үзэх эх сурвалж болох;
6. Эрдэм шинжилгээ, судалгааны үнэ цэнтэй эх сурвалж болох;
7. Тухайн хэрэг, маргааныг шүүхээс хэрхэн шийдвэрлэж болох талаарх урьдчилсан төсөөллийг өгөх;
8. Эрх зүйн ухамсар, соёлын төлөвшилд эергээр нөлөөлөх;
9. Эрх зүйн тогтолцоог хөгжүүлэхэд хувь нэмэр болох зэрэг болно.

Үзэл баримтлал (*лат. conceptio*) гэж аливаа үзэгдэл, үйл явцыг тодорхойлж ойлгох, боловсруулж шийдвэрлэхдээ удирдлага болгосон тодорхойлогч, нэгдмэл үзэл бодлын тогтолцоо¹³-г хэлэх бөгөөд дэлхийн улс орнууд шүүхийн шийдвэрийг ил тод болгож ирсэн үзэл бодол, түүнийг хэрэгжүүлсэн үйл явцад шинжилгээ хийвэл дараах дөрвөн үзэл баримтлал бий болж, давамгайлж ирсэн байна.

Нэгдүгээрт, Шүүхийн шийдвэр бүрэн эхээрээ (бүхэлдээ) ил тод байна. Шүүхийн шийдвэрт дурдагдсан аливаа мэдээлэлд ямар нэгэн өөрчлөлт, нууцлал хийлгүйгээр бүрэн эхээр нь нийтэлж ил тод болгоно. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэр бүхэлдээ ил тод байдаг бөгөөд төрийн мэдээлэл эмхэтгэлд хэвлэн нийтлэгдэхийн зэрэгцээ, эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем www.legalinfo.mn болон Үндсэн хуулийн цэцийн www.conscourt.gov.mn цахим хуудаст бүрэн эхээрээ ямар нэгэн засвар, өөрчлөлтгүйгээр нийтэлдэг.

¹³ С.Нарангэрэл. Монголын эрх зүйн англи, орос, латин хадмал эх толь бичиг. дөрөв дэх хэвлэлт. УБ. 2015., 462 дахь тал.

Хоёрдугаарт, Нууц, аюулгүй байдалд хамаарахаас бусад шүүхийн шийдвэр ил тод байна. Шүүхээр хянан шийдвэрлэгдэж байгаа хэргийн нотлох баримт ба үйл явдал нь төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хувь хүний эмзэг мэдээллийг агуулсан, түүнчлэн аюулгүй байдалд хамаарах бол тухайн шүүхийн шийдвэрийг ил тод болгохгүй болно.

Гуравдугаарт, Шүүхийн шийдвэрт дурдагдсан хүн, хуулийн этгээд болон тэдгээрийн өмч, хөрөнгийг тодорхойлох мэдээллээс бусад мэдээлэл ил тод байна. Шүүхийн шийдвэр нь ямагт хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолтой холбоотой мэдээллийг агуулж байдаг тул тус шийдвэрт дурдагдсан мэдээллийн эзнийг тодорхойлох нэр, регистрийн дугаар, хаяг болон өмч тэдгээрийн талаар мэдэх боломжтой мэдээллийг нууцлах ба бусад мэдээлэлд ямар нэгэн өөрчлөлт оруулахгүй болно.

Дөрөвдүгээрт, Шүүхийн шийдвэр хэргийн оролцогчдоос бусад этгээдэд хаалттай байна. Шүүхийн шийдвэр нь нууцад хамаарах мэдээллийг агуулахын зэрэгцээ хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, байр суурийн талаарх мэдээллийг агуулж байдаг тул хэргийн оролцогч болон бусад оролцогчдын хувьд нээлттэй байж болно, харин нийтэд ил тод болгох нь зохистой биш байдаг.

Улс орнууд засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх нийтлэг зарчмыг хүлээн зөвшөөрч, төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн гурван эрх мэдэлд хуваадаг. Хууль тогтоох эрх мэдлийн үйл ажиллагаа хуулийн төслийг санаачлах, боловсруулах, хэлэлцэх, батлах, хэвлэн нийтлэх, дагаж мөрдүүлэх бүх үе шатандаа нээлттэй ил тод байдаг бол гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагаа хууль тогтоомжийн гүйцэтгэл, хэрэгжилтийг хангах хүрээнд мөн ил тод, нээлттэй байдаг. Үүний жишгээр шүүх эрх мэдлийн үйл ажиллагаа (процесс)-г ил тод, нээлттэй болгох хүрээнд шүүх хэргийг ил таслан шийдвэрлэх зарчим хэдийнээ төлөвшсөн болно.

1.2. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Эдүгээ шүүх эрх мэдлийн үйл ажиллагааны үр дүн болох шийдвэр ил тод байх талаар олон улсын гэрээ, дотоодын хууль тогтоомжоор зохицуулах болсон байна. Тухайлбал, Европын Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай конвенц (1950)-ийн 6 дугаар зүйлийн 1-д “Хүн бүр иргэний эрх, үүргээ тодорхойлуулах, эсхүл өөрийнх нь эсрэг үүсгэсэн аливаа эрүүгийн хэргийг шийдвэрлүүлэхдээ хуульд заасан хараат бус, шударга шүүхээр боломжит хугацаанд нь шударга, нээлттэй шүүлгэх эрхтэй. Шүүхийн шийдвэрийг нийтэд ил тод зарлан мэдээлэх боловч ардчилсан нийгэм дэх ёс суртахуун, нийтийн хэв журам, үндэсний аюулгүй байдлын үүднээс насанд хүрээгүй хүүхдийн эрх, ашиг сонирхол болон тухайн харилцаанд оролцогчдын хувийн амьдралыг хамгаалах үүднээс, эсхүл олон нийтийн зүгээс шүүх хэргийг шийдвэрлэхэд нөлөөлөх үндэслэлтэй хэмээн шүүхийн зүгээс хязгаарлах нь зүйтэй гэж үзсэн онцгой тохиолдолд шүүх хуралдаанд хэвлэл мэдээлэл, олон нийтийг бүхэлд нь буюу заримыг нь оролцуулахгүй байж болно” гэж заасан бол ХБНГУ, ОХУ, Монгол, Эстони зэрэг улс орнуудад шүүхийн шийдвэрт тусгагдсан мэдээлэл хүний эрх, хууль ёсны ашиг сонирхол, шударга ёсны шаардлага, нийгмийн ёс суртахуун, аюулгүй байдал, нууцад хамаарах бол нийтэлж болохгүй талаар нийтлэг хэм хэмжээг тогтоосон байна.

Монгол Улсад шүүхийн шийдвэрийн ил тод байдлыг хангах, хэвлэн нийтлэхтэй холбоотой харилцааны эрх зүйн үндсийг 2013 оны Шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1-д “*Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг тодорхой хэрэг, маргааныг шийдвэрлэх замаар гаргах бөгөөд тайлбарыг тогтмол нийтлэх*” гэж зааснаар харьцангуй тодорхой болгосон. Хуулийн энэхүү заалт болон хэрэгжүүлж ирсэн практикт дүн шинжилгээ хийвэл өмнөх бүлэгт авч үзсэн **сонгож нийтлэх** (*positive selection*) аргыг нэвтрүүлсэн гэж үзэхээр байна.

Харин 2021 оны Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.8-д шүүхийн шийдвэрийг нийтлэх талаар “*Хуульд өөрөөр заагаагүй бол бүх шатны шүүх шийдвэрээ шүүхийн шийдвэрийн*

нэгдсэн цахим санд байршуулна. Шүүхийн шийдвэрийг эмхэтгэн хэвлэж болно”, 22.9-д “Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар гаргасан албан ёсны тайлбар, Улсын дээд шүүхээс хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад ач холбогдолтой гэж үзсэн шийдвэрийг “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтэлнэ” гэж заасан бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 39 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах журам”-аар тус харилцааг илүү дэлгэрүүлэн зохицуулж байна.

Түүнчлэн Монгол Улсын Шүүхийн тухай хууль болон процессын хуулиудад 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр орсон “хуулийг Улсын дээд шүүхийн тогтоолоос өөрөөр хэрэглэсэн” гэсэн нэмэлт, өөрчлөлт нь шүүхийн практикийн гүйцэтгэх үүргийг өсгөн нэмэгдүүлсний зэрэгцээ тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд урьд өмнө адил төстэй маргааныг хянан шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн тогтоолыг харгалзан үзэх шаардлагыг практикт бий болгосон байна.

Эдүгээ хүчин төгөлдөр үйлчилж байгаа дээрх хууль тогтоомж болон журмын холбогдох зохицуулалтад дүн шинжилгээ хийвэл шүүхийн шийдвэрийг ил тод болгох нь зайлшгүй бөгөөд хориглосноос бусдыг нийтлэх (*negative selection*) аргыг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бий болгож улмаар хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна.

Тус улсад захиргааны шүүхийн шийдвэрийг ил тод болгож ирсэн үйл явцыг иж бүрэн авч үзэж, дүн шинжилгээ хийвэл дараах гурван үе шатанд хуваагдаж байна.

Нэгдүгээрт, Шүүхийн шийдвэр хэргийн оролцогчид болон бусад оролцогчдод ил тод байсан үе (2004-2014). Энэ үед шүүхийн шийдвэрийг олон нийтэд ил тод болгохтой холбоотой эрх зүйн орчин бүрдээгүй байсан тул хэргийн оролцогч болон бусад оролцогчдод шүүхийн шийдвэрийг гардуулах замаар ил тод болгодог байсан. Гэхдээ эрдэм шинжилгээ судалгааны ажилд шүүхийн шийдвэрт дурдагдсан үйл баримт, хууль хэрэглээний авч үзэх, үнэлэлт, дүгнэлт өгөх явдал зөвшөөрөгддөг байсан.

Хоёрдугаарт, Шүүхийн шийдвэр бүрэн эхээрээ, ямар нэгэн засваргүй нийтэд ил тод байсан үе (2014-2022). Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2014 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн “Шүүхийн шийдвэрийг нийтлэх” журам батлагдсанаар шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь “хуулбар хувь” гэсэн тэмдэглэгээтэйгээр www.shuukh.mn цахим хуудсанд хэвлэн нийтэлж ирсэн.

Гуравдугаарт, Шүүхийн шийдвэрт дурдагдсан хүн, хуулийн этгээдийн талаарх мэдээллийг өөрчилж, үүнээс бусад мэдээллийг ил тод болгосон үе (2022-04 сараас өнөөг хүртэл). 2022 оны “Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах” журам батлагдсанаар шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь www.shuukh.mn цахим хуудсанд хэвлэн нийтлэхдээ тухайн шийдвэрт дурдагдсан хүн, хуулийн этгээд, тэдгээрийн хөрөнгийн талаарх мэдээллийг “тэмдэгт болон үсгээр” өөрчилж хэвлэн нийтлэх болсон.

Дээр дурдсан үе шатуудын, тэр дундаа (2) болон (3) дахь үе шатуудын мөн чанарыг илүү тодорхой болгохын тулд өмнө үйлчилж байсан Шүүхийн шийдвэрийг нийтлэх журам (2014) болон одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах журам (2022)-ын холбогдох зохицуулалтыг харьцуулан авч үзэх шаардлага үүсэж байна.

Хүснэгт. 1. Журмуудын харьцуулалт

№	Шалгуур	2014 оны Шүүхийн шийдвэрийг нийтлэх журам	2022 оны Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах журам
1	Журмын зохицуулах харилцаа	Шүүхийн шийдвэр нийтлэх арга ажиллагааг энэ журмаар зохицуулна.	Анхан шатны шүүхийн шийтгэх, ба цагаатгах тогтоол, шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлал, хяналтын шатны шүүхийн тогтоолыг шүүхийн шийдвэрийн цахим хуудаст байршуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

№	Шалгуур	2014 оны Шүүхийн шийдвэрийг нийтлэх журам	2022 оны Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах журам
2	Зорилго	Шүүхийн шийдвэр нийтлэх арга ажиллагааг энэ журмаар зохицуулна.	Шүүхийн шийдвэрийн цахим сан /цаашид “цахим сан” гэх/ шүүхийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод байлгах, шүүхийн шийдвэрийг судалгаа, шинжилгээний эргэлтэд оруулж шүүхийн практикийг хөгжүүлэх, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад мэдээлэл солилцох, иргэд шүүхэд мэдүүлэх эрхээ хэрэгжүүлэхэд шүүхийн практикийг таниулах, мэдээлэх зориулалттай байна.
3	Цахим хуудаст байршуулах шүүхийн шийдвэр	Хэрэг, маргааныг эцэслэн шийдвэрлэсэн анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шийдвэр.	Журамд байршуулахгүй байхаар зааснаас бусад шийдвэр
4	Цахим санд байршуулахгүй шүүхийн шийдвэр	Шүүхийн шийдвэрийг нийтлэхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үл нөлөөлөх, байгууллага болон хувь хүний нууцыг хамгаалах зарчмыг баримтална.	<p>4.2.Цахим хуудаст дараах шүүхийн шийдвэрийг байршуулахгүй:</p> <p>4.2.1.хуульд тухайлан заасан хэрэг, маргааны шүүхийн шийдвэр;</p> <p>4.2.2.хэрэг, маргааныг хаалттай шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр;</p> <p>4.2.3.гэр бүлийн маргаан, асран хамгаалагч тогтоох, хүүхэд үрчлэн авах, насанд хүрээгүй хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн бусад хэрэгтэй холбоотой шүүхийн шийдвэр;</p> <p>4.2.4.бэлгийн халдашгүй байдал, бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэгтэй холбоотой шүүхийн шийдвэр;</p> <p>4.2.5.иргэний эрх зүйн чадамжийг хязгаарлах, эсхүл түүнийг чадваргүйд тооцох тухай шүүхийн шийдвэр;</p> <p>4.2.6.иргэнийг сэтгэцийн эмчийн албадан үзлэг, эмчилгээ хийх, сэтгэцийн эмнэлэгт албадан хэвтүүлэхтэй холбоотой шүүхийн шийдвэр;</p>

№	Шалгуур	2014 оны Шүүхийн шийдвэрийг нийтлэх журам	2022 оны Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах журам
			<p>4.2.7.иргэний болон эд хөрөнгийн бүртгэлд залруулга, өөрчлөлт оруулахтай холбоотой шүүхийн шийдвэр;</p> <p>4.2.8.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн, онцгой ажиллагааны журмаар гарсан болон хэргийг хэрэгсэхгүй болгосон шүүхийн шийдвэр.</p>
5	Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах хугацаа	Шүүгчийн туслах шүүхийн шийдвэрийг хэргийн бүх оролцогчдод гардуулж өгснөөс хойш 24 цагийн дотор	Системийн бүрдүүлэгч шүүхийн шийдвэрийг шүүгч гарын үсэг зурж албажуулснаас хойш ажлын арван өдрийн дотор цахим хуудаст байршуулна.
6	Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулахад тавигдах техникийн шаардлага	Шүүгчийн туслах шүүхийн шийдвэрийг хэргийн бүх оролцогчдод гардуулж өгснөөс хойш 24 цагийн дотор PDF эсвэл зурган файл хэлбэрээр дагалдах хуудасны хамт дэд зохицуулагчид хүлээлгэн өгнө. Шүүх тухайн хэрэг, маргааны онцлогоос шалтгаалж шүүх хуралдааныг хаалттай явуулсан бол шүүгчийн туслах шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг дагалдах хуудасны хамт дэд зохицуулагчид хүлээлгэн өгнө.	5.2.Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулахад дараах техникийн шаардлагыг хангана: 5.2.1.шүүхийн шийдвэрт дурдсан хүн, хуулийн этгээдийн нэр, регистрийн болон улсын бүртгэлийн дугаар, оршин суугаа болон үйл ажиллагаа явуулж байгаа газрын хаяг, эд хөрөнгийн бүртгэлийн дугаар зэрэг мэдээллийг тодорхойлох боломжгүй болгон нууцлах; 5.2.2.шүүхийн шийдвэрт дурдсан хүн, хуулийн этгээдийг тодорхойлох боломжтой бусад мэдээллийг нууцлах; 5.2.3.шүүхийн шийдвэрт бичигдсэн бусад мэдээлэл үнэн зөв, бүрэн байх.

Үүнээс үзэхэд өмнө үйлчилж байсан буюу 2014 оны Шүүхийн шийдвэрийг нийтлэх журмаас одоо үйлчилж байгаа 2022 оны Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах журам нь агуулгын хувьд илүү тодорхой болж, зарим нэг харилцаанд тухайлбал, хувийн мэдээллийн хамгаалах, нууцлах шаардлагын үүднээс цахим санд нийтлэхгүй байх шүүхийн шийдвэрийн төрлийг тодорхойлохын зэрэгцээ цахим сан (www.shuukh.mn)-д байршуулах техникийн шаардлагыг нарийвчлан зохицуулсан байна.

Системийн бүрдүүлэгч буюу цахим санд шүүхийн шийдвэр оруулах үүрэг бүхий шүүгчийн туслах шийдвэрийг шүүгч гарын үсэг зурж албажуулснаас хойш ажлын арван өдрийн дотор цахим хуудаст байршуулахдаа дараах техникийн шаардлагыг хангасан байх ёстой. *(Журмын 5 дугаар зүйлд)*

- шүүхийн шийдвэрт дурдсан хүн, хуулийн этгээдийн нэр, регистрийн болон улсын бүртгэлийн дугаар, оршин суугаа болон үйл ажиллагаа явуулж байгаа газрын хаяг, эд хөрөнгийн бүртгэлийн дугаар зэрэг мэдээллийг тодорхойлох боломжгүй болгон нууцлах;
- шүүхийн шийдвэрт дурдсан хүн, хуулийн этгээдийг тодорхойлох боломжтой бусад мэдээллийг нууцлах;
- шүүхийн шийдвэрт бичигдсэн бусад мэдээлэл үнэн зөв, бүрэн байх шаардлагатай.

Цахим санд байршуулбал зохих шүүхийн шийдвэрийг орхигдуулаагүй бүрэн байршуулсан эсэхэд админ шүүхийн шийдвэрийн дугаарын дарааллыг нягталж хяналт тавих бөгөөд энэ хяналтыг хэрэгжүүлэх тохиргоог цахим санд тусгана.

Журмын 7 дугаар зүйлд шүүхийн Тамгын газрын дарга нь цахим санд дараах байдлаар хяналт тавихаар зохицуулжээ. Үүнд:

7.1. Цахим санд байршуулбал зохих шүүхийн шийдвэрийг орхигдуулаагүй бүрэн байршуулсан эсэхэд админ шүүхийн шийдвэрийн дугаарын дарааллыг нягталж хяналт тавих бөгөөд энэ хяналтыг хэрэгжүүлэх тохиргоог цахим санд тусгана.

- 7.2.1. системийн бүрдүүлэгч энэ журмын 5.1, 5.2-т заасан хугацаа, техникийн шаардлагыг ханган шүүхийн шийдвэрийг цахим хуудаст орхигдуулахгүй бүрэн байршуулж байгаа эсэхийг долоо хоног бүр шалгах;
 - 7.2.2. цахим сангийн ашиглалт, шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулсантай холбогдуулан гаргасан санал, хүсэлт, гомдлыг тухай бүр шийдвэрлэх;
 - 7.2.3. цахим сангийн мэдээллийг энэ журамд нийцүүлэн засах, зөвтгөх, өөрчлөх даалгаврыг системийн бүрдүүлэгчид өгч, биелэлтийг тухай бүр хангуулах.
- 7.3. Энэ журмын 7.2.1-д заасны дагуу шалгах ажлыг хариуцах ажилтныг тодорхойлж, цахим сантай холбоотой хийгдсэн шалгах ажлын мэдээллийг долоо хоног тутам гаргуулан, холбогдох арга хэмжээг авна.
- 7.4. Шүүхийн Тамгын газар энэ журмын хэрэгжилтийг хангах хүрээнд энэ журмын 7.2-т заасны дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг админд сар бүр цахимаар хүргүүлнэ.
- 7.5. Админ энэ журмын 7.4-т заасны дагуу хүлээн авсан мэдээллийг нэгтгэн боловсруулж энэ журмын хэрэгжилтийг хангах, сайжруулах талаар нийтлэг зөвлөмжийг өгч ажиллана.
- 7.6. Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах болон шүүхийн нээлттэй, ил тод байдлын талаар судалгаа, шинжилгээ, мониторинг хийх замаар хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж болно.

Цахим хуудаст дараах шүүхийн шийдвэрийг байршуулахгүй:

- 4.2.1. хуульд тухайлан заасан хэрэг, маргааны шүүхийн шийдвэр;
- 4.2.2. хэрэг, маргааныг хаалттай шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр;
- 4.2.3. гэр бүлийн маргаан, асран хамгаалагч тогтоох, хүүхэд үрчлэн авах, насанд хүрээгүй хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн бусад хэрэгтэй холбоотой шүүхийн шийдвэр;
- 4.2.4. бэлгийн халдашгүй байдал, бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэгтэй холбоотой шүүхийн шийдвэр;

- 4.2.5. иргэний эрх зүйн чадамжийг хязгаарлах, эсхүл түүнийг чадваргүйд тооцох тухай шүүхийн шийдвэр;
- 4.2.6. иргэнийг сэтгэцийн эмчийн албадан үзлэг, эмчилгээ хийх, сэтгэцийн эмнэлэгт албадан хэвтүүлэхтэй холбоотой шүүхийн шийдвэр;
- 4.2.7. иргэний болон эд хөрөнгийн бүртгэлд залруулга, өөрчлөлт оруулахтай холбоотой шүүхийн шийдвэр;
- 4.2.8. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн, онцгой ажиллагааны журмаар гарсан болон хэргийг хэрэгсэхгүй болгосон шүүхийн шийдвэр.

Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах журмын зохицуулалтаар хүний эрх, эрх чөлөө, халдашгүй байдлыг хамгаалсан, нууцлалын зохицуулалтыг оруулсан ч судалгааны дүгнэлтээс харахад хэрэгжилт хангалтгүй байгаа нь харагдаж байна. Шүүхийн шийдвэрийг цахим санд нийтлэх, байршуулахтай холбоотой илэрсэн алдаа дутагдал нь ихэвчлэн техникийн шинжтэй буюу шийдвэр байршуулсан ажилтны ажлын байрны тодорхойлолтод чиг үүргийг зааж өгөөгүйгээс хайхрамжгүй хандсан эсхүл холбогдох журмуудыг мэдэхгүйгээс гарсан байх магадлалтай байх тул шийдвэрийг байршуулсан байдалд хяналт тавих үүрэгтэй Тамгын газрын дарга энэ бүхнийг хянаж, цаг тухай бүрт нь залруулах, нөгөө талаар шүүгчийн туслахуудын ажлын байрны тодорхойлолтод цахим санд шийдвэр байршуулах үүргийг тусгайлан оруулж, журамд хариуцлагын зохицуулалтыг нэмж өгөх шаардлагатай.

Нөгөө талаар Улсын Их Хурлаас 2021 онд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль баталж, 2022 оны 5 дугаар сараас мөрдөж эхлээд байна. Дээрх хуулиуд нь хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулах, хуульд заасан үндэслэл, журмын дагуу иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, нийтийн мэдээллийн дэд бүтцийн эрх зүйн үндсийг тогтоох, төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй,

ил тод, шуурхай байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилготой учраас шүүхийн шийдвэрийг нийтэд мэдээлэхдээ хүний хувийн мэдээллийг хамгаалах нь зүй ёсны асуудал юм.

1.3. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ НИЙТЭЛЖ БҮЙ ПРАКТИК

Шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэх зарчим эдүгээ эрх зүйт төр бүхий улс орнуудад нэгэнт төлөвшин тогтсон байх бөгөөд шүүхийн шийдвэрийн ил тод байдлыг хангахдаа **сонгож нийтлэх** (*positive selection*), **хориглосноос бусдыг нийтлэх** (*negative selection*) гэсэн хоёр аргыг удирдлага болгож байна.

Нийт шүүхийн шийдвэрүүдээс сонгож нийтлэхдээ “хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад ач холбогдолтой байх” шалгуурыг гол болгож хуулийг тайлбарласан шийдвэрүүдийг нийтэлнэ.

Хориглосноос бусдыг нийтлэхдээ төр, байгууллага, хувь хүний мэдээллийн аюулгүй байдал, нууцыг хадгалах зорилгоор холбогдох мэдээллийг хасаж, өөрчилж, товчилж байна. Тухайлбал, “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын овог, нэр, төрсөн он, сар, өдөр, төрсөн газар, оршин суугаа газар, утасны дугаар, паспорт болон бусад хувийн үнэмлэхний дэлгэрэнгүй мэдээлэл, татвар төлөгч хувь хүний болон хувиараа арилжаа эрхлэгчийн улсын бүртгэлийн дугаар, мөн хувийн дансны болон даатгалын дугаар, түүнчлэн газар, барилга байгууламж, орон сууцны барилга, орон сууц, тээврийн хэрэгсэл, эд хөрөнгийн талаарх бусад мэдээлэл, мөн шүүх хуралдаанд оролцогчдын банк болон бусад зээлийн байгууллагад байгаа хэрэгт ач холбогдолтой хөрөнгийн талаарх мэдээлэл”-ийг өөрчлөх, эхний үсгээр тэмдэглэх, өөр нэр хэрэглэхийн зэрэгцээ шүүхийн шийдвэрээс хасч нийтэлнэ.

Манай улсын хувьд шүүхийн шийдвэр ил тод болох үйл явц шүүх хуралдааныг товлон зарласан үеэс эхэлж, шийдвэрийг нийтэлснээр хэрэгжилт нь хангагдаж байх бөгөөд цахим сан (www.shuukh.mn)-г ашиглагдаж эхлэхээс өмнө нийт шүүхийн шийдвэрээс сонгож нийтлэх аргыг хэрэгжүүлж байсан бол тус цахим санг ашиглаж эхэлсэн үеэс **хориглосноос бусдыг нийтлэх** аргыг хэрэглэх болсон байна.

Цахим сан (www.shuukh.mn)-д (1) хуульд тухайлан заасан хэрэг, маргааны шүүхийн шийдвэр, (2) хэрэг, маргааныг хаалттай шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, (3) гэр бүлийн маргаан, асран хамгаалагч тогтоох, хүүхэд үрчлэн авах, насанд хүрээгүй хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн бусад хэрэгтэй холбоотой шүүхийн шийдвэр, (4) бэлгийн халдашгүй байдал, бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэгтэй холбоотой шүүхийн шийдвэр, (5) иргэний эрх зүйн чадамжийг хязгаарлах, эсхүл түүнийг чадваргүйд тооцох тухай шүүхийн шийдвэр, (6) иргэнийг сэтгэцийн эмчийн албадан үзлэг, эмчилгээ хийх, сэтгэцийн эмнэлэгт албадан хэвтүүлэхтэй холбоотой шүүхийн шийдвэр, (7) иргэний болон эд хөрөнгийн бүртгэлд залруулга, өөрчлөлт оруулахтай холбоотой шүүхийн шийдвэр, (8) Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн, онцгой ажиллагааны журмаар гарсан болон хэргийг хэрэгсэхгүй болгосон шүүхийн шийдвэрийг¹⁴ нийтэлдэггүй болно.

Эдгээрээс (1), (2), (3), (6), (7) дахь хэсэгт заасан шийдвэрийг захиргааны хэргийн шүүх гаргаж болох боловч (1)-д дурдсан өөрөөр хэлбэл, шүүхийн шийдвэрийг нийтлэхийг тусгайлан хориглосон хууль тогтоомж өнөөдрийн байдлаар хууль тогтоогч хараахан батлагдаагүй байгааг дурдах нь зүйтэй.

Хориглосноос бусад шүүхийн шийдвэрийг практикт цахим сан (www.shuukh.mn)-д нийтлэхээс гадна дараах байдлаар нийтэлж байна. Үүнд:

- Шүүхийн шийдвэрийг тойм байдлаар нийтлэх. Тухайлбал, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 343 дугаар тогтоолын хавсралтаар “Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх журам”-ыг баталсан. Тус журмын зорилго нь шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, бэхжүүлэх, шүүхийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг олон нийтэд ойлгуулах, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, үнэн зөв мэдээллээр хангах

¹⁴ Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах журмын 4.2 дахь хэсэг

бөгөөд тус журмын дагуу хэргийг хянан шийдвэрлэсэн шүүгч, шүүх бүрэлдэхүүн гаргасан шийдвэрээ тоймлон олон нийтэд танилцуулж байна.

- Шүүх хуралдааны шууд дамжуулалт: Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 102 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Шүүх хуралдааны явцыг мэдээлэх цахим систем ашиглах журам”-ын дагуу шүүхийн хэлэлцүүлэг, урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдааны тов, тойм, явцын мэдээллийг цахим сүлжээ (www.live.shuukh.mn)-ээр дамжуулан тухай бүрд хэргийн оролцогч, иргэд, олон нийтэд мэдээлэх замаар шүүх хуралдааны явц болон гарсан шийдвэрийг ил тод болгож байна.
- Шүүхийн шийдвэрийн хураангуй: Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн Захирлын 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/24 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Олон нийтэд зориулсан шүүхийн шийдвэрийн хураангуй бэлтгэх аргачлал”-ын дагуу шүүхийн шийдвэрийн хураангуйг бэлтгэн цахим хуудас (<https://www.jtrii.mn/mn/>)-аар дамжуулан нийтэлж байна.
- Шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл: Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг хэвлэн нийтлэхдээ хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд ач холбогдолтой байх шалгуурыг баримталж шүүхийн шийдвэрүүдээс сонгон авч, хэвлэн нийтэлж байна.

ХОЁР. ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ИЛ ТОД БОЛГОЖ БАЙГАА ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Мониторинг гүйцэтгэгч: Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн Практик сургалтын төв

Хамрах хүрээ: Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн 2022 оны шийдвэрүүд

Захиргааны хэргийн шүүх бол Монгол Улсын Үндсэн хуулийн дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “дагнасан шүүх” мөн. Дагнасан шүүх нь шүүн таслах ажлын төрлөөр мэргэшсэн шүүгчдээс бүрддэг тул тэдний хууль хэрэглэж өгсөн дүгнэлтүүд нь салбар эрх зүйн хөгжилд даацтай хувь нэмэр оруулдаг. Эл хандлагаар авч үзвэл захиргааны хэргийн шүүхээс захиргааны хэргийг хянан хэлэлцээд гаргаж буй акт буюу шийдвэр нь дараах шинжийг агуулдаг гэж үзэж болно: (1) *хууль ёсны байх*. Захиргааны хэргийн шүүхээс хэргийг хянан шийдвэрлэхдээ материаллаг болон процессын эрх зүйн хэм хэмжээг агуулга ба зорилгод нь нийцүүлж, оновчтой, зөв тайлбарлан хэрэглэсэн бол Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн хууль ёсны байх шинж бүрэн хангагдана, (2) *үндэслэл бүхий байх*. Захиргааны хэрэгт хамааралтай бөгөөд хуульд заасан арга хэрэгслээр олж авсан, шүүх хуралдаанаар хэлэлцэгдэж, шинжлэн судлагдсан нотлох баримтаар хэрэгт ач холбогдол бүхий бүх нөхцөл байдал тогтоогдсон хийгээд эдгээр нөхцөл байдлын талаар шүүхийн бүрэн, бодитой дүгнэлтийг агуулсан шийдвэр нь үндэслэл бүхий байх шинжийг хангана, (3) *тодорхой ойлгомжтой байх*. Нэхэмжлэлийн шаардлагыг хэрхэн шийдвэрлэснийг, өөрөөр хэлбэл захиргааны актыг хүчингүй болгосон, илт хууль бус болохыг тогтоосон, акт гаргахыг даалгасан гэх зэрэг үр дагаврыг тодорхой

ойлгомжтой илэрхийлсэн байна, (4) *заавал биелэгдэх*. Хуулийн хүчин төгөлдөр захиргааны хэргийн шүүхийн шийдвэр заавал биелэгдэх үр дагавартай бөгөөд аливаа этгээд өөрчлөх буюу хүчингүй болгох ямар нэгэн боломжгүй байдаг, (5) *хэрэгжүүлж болохуйц байх*. Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг хариуцагч сайн дураараа эсхүл эрх бүхий байгууллагын шаардлагаар албадан биелүүлж, хэрэгжүүлж болохуйц байна.

Захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэж байгаа хэргийн нотлох баримт ба үйл явдал нь төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлд хамаарах бол шүүх хуралдааныг бүрэн, эсхүл хэсэгчлэн хаалттай явуулдаг. Ийнхүү хаалттай хийсэн шүүх хуралдаанаас гаргасан шийдвэрийг хэргийн оролцогчид болон бусад оролцогчид сонсох, танилцах эрхтэй, харин бусад этгээдийн хувьд ийм боломж байдаггүй болно.

Захиргааны хэргийн шүүхийн хаалттай шүүх хуралдаанаар дараах хэргийг хянан шийдвэрлэнэ:

- (1) *Төрийн нууцтай холбоотой захиргааны хэрэг*. “Төрийн нууц” гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, задруулах, үрэгдүүлэх тохиолдолд үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхолд аюул, занал, хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг хэлдэг.
- (2) *Албаны нууцтай холбоотой захиргааны хэрэг*. “Албаны нууц” гэж задруулах, үрэгдүүлэх тохиолдолд салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг хэлнэ.
- (3) *Байгууллагын нууцтай холбоотой захиргааны хэрэг*. Байгууллагын нууцыг тогтоох, хамгаалахтай холбоотой харилцааг “Байгууллагын нууцын тухай хууль”¹⁵-иар зохицуулна. Тус хуульд зааснаар “байгууллага” гэдэг нь тодорхой чиг үүрэг, бүрэн эрх бүхий хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн хуулийн этгээд юм. “Байгууллагын нууц” гэж хүний эрх, нэр төр, алдар хүнд тухайн байгууллагын хууль ёсны

¹⁵ Байгууллагын нууцын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1995 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор холбогдох хуулиар нууц гэж тогтоосон мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хамааруулна.

- (4) *Хүний эмзэг мэдээлэлд хамаарах захиргааны хэрэг.* Урьд өмнө хувь хүний нууцыг тогтоох, хамгаалахтай холбогдсон харилцааг нэн чухалд тооцож үүнийг “Хувь хүний нууцын тухай хууль”¹⁶-иар зохицуулж ирсэн бөгөөд тус хуульд зааснаар “*хувь хүний нууц*” гэж Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн нууцалсан бөгөөд задруулбал тухайн хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг ойлгож байсан.

Харин 2021 оны шинэтгэлээр хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар зохицуулах болсон. Тус хуульд зааснаар “*хүний хувийн мэдээлэл*” гэж хүний эмзэг мэдээлэл болон хүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, төрсөн газар, оршин суугаа газрын хаяг, байршил, иргэний бүртгэлийн дугаар, хөрөнгө, боловсрол, гишүүнчлэл, цахим тодорхойлогч, хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох, эсхүл тодорхойлох боломжтой бусад мэдээллийг ойлгоно.

Шүүгч, шүүх хуралдааны оролцогч нь хүний хувийн мэдээллийн нэг төрөл болох хүний эмзэг мэдээллийг задруулахгүй байх үүргийг хуулиар хүлээсэн болно. “*Хүний эмзэг мэдээлэл*”-д хүний үндэс, угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, эрүүл мэнд, захидал харилцаа, генийн болон биометрийн мэдээлэл, тоон гарын үсгийн хувийн түлхүүр, ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх мэдээлэл хамаарна.

Үүнээс авч үзвэл, төрийн хүсэл зоригийг илэрхийлсэн шүүхийн шийдвэрт төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэл тусгагдсан бол ил тод болгох боломжгүй юм.

¹⁶ Хувь хүний нууцын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1995 оны 7 дугаарт нийтлэгдсэн. Энэ хууль нь 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн Хувь хүний нууцын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулиар хүчингүй болсон болно.

2.1. ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТООН СУДАЛГАА

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг ил тод болгож байгаа өнөөгийн байдлыг илүү тодруулахын тулд Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх (цаашид “анхан шатны шүүх” гэх)-ийн 2022 оны тайлант жил буюу 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 20-ний өдрийг хүртэлх хугацаанд шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг хэрхэн ил тод болгож байгаа үйл явцыг тухайлан судалж үзэхэд, анхан шатны шүүхийн 2022 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны тайланд¹⁷ нийт шийдвэрлэгдсэн хэрэг 1065 байгаа ба үүнээс 925 шийдвэр буюу нийт шийдвэрийн 86,8 хувийг цахим сан (www.shuukh.mn)-д нийтэлж ил тод болгосон байна.

Эдгээр шийдвэрүүдийг маргааны төрлөөр ангилсан байдлаар авч үзвэл:

Хүснэгт 2. Маргааны төрлийн ангилал

№	Маргааны төрөл	Шүүхийн шийдвэрийн тоо
1.	Газар	264
2.	Сонгууль	1
3.	Нийгмийн даатгал	13
4.	Тендер	36
5.	Тусгай зөвшөөрөл	21
6.	Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэл	30
7.	Төрийн албан хаагчаар хөдөлмөр	28
8.	Төрийн хяналт шалгалт	70
9.	Төрийн болон орон нутгийн өмч	1
10.	Хуулийн этгээдийн улсын бүртгэл	17
11.	Төрийн алба	90
12.	Бусад	240
13.	Татвар	57
14.	Ашигт малтмал	63
15.	Орон сууц хувьчлах	2

¹⁷ <https://admindcourt.gov.mn/cat03/504-2022-ony-bten-zhiliyn-shn-taslah-azhillagaany-taylan.html>

2.2. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ИЛ ТОД БАЙДЛЫН ЧАНАРЫН СУДАЛГАА

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг ил тод болгож байгаа өнөөгийн байдал нь “шүүхийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод байлгах, шүүхийн шийдвэрийг судалгаа, шинжилгээний эргэлтэд оруулж шүүхийн практикийг хөгжүүлэх, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад мэдээлэл солилцох, иргэд шүүхэд мэдүүлэх эрхээ хэрэгжүүлэхэд шүүхийн практикийг таниулах, мэдээлэх” зорилгодоо нийцэж байгаа эсэхийг тодруулахын тулд (А) Цахим санд Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг нийтэлсэн байдлын судалгаа, (Б) Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхээр үйлчлүүлж буй иргэдийн дунд цахим сангийн ил тод байдлын талаар асуулга, (В) Цахим сангийн талаар шүүхийн захиргааны ажилтнуудаас ярилцлагыг тус тус хийсэн болно.

А. Цахим санд Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг нийтэлсэн байдлын судалгааны үр дүн

- Нууцад хамаарахаас бусад шүүхийн шийдвэрийг цахим сан (www.shuukh.mn)-д нийтлэх болсон байна.
- Нийт шүүхийн шийдвэрийг цахим сан (www.shuukh.mn)-д шүүхийн харьяаллаар ангилсан байх бөгөөд захиргааны хэргийн хувьд маргааны төрлөөр нь (1) газар, (2) сонгууль, (3) нийгмийн даатгал, (4) тендер, (5) тусгай зөвшөөрөл, (6) эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэл, (7) төрийн албан хаагчийн хөдөлмөр, (8) төрийн хяналт шалгалт, (9) төрийн болон орон нутгийн өмч, (10) хуулийн этгээдийн улсын бүртгэл, (11) төрийн алба, (12) татвар, (13) ашигт малтмал, (14) орон сууц хувьчлах, (15) бусад гэсэн төрлөөр ангилсан байна. Эдгээр ангилал тус бүрт нэвтэрч судлан үзвэл тухайн ангилалд үл хамаарах шүүхийн шийдвэр нэлээдгүй байх ба “бусад” гэсэн ангилалд нийт шүүхийн шийдвэрийн 25.9 хувь буюу 240 шүүхийн шийдвэрийг оруулжээ. Энэ ангилалд (“бусад”) нэвтэрч үзэхэд дээр дурдсан тодорхой нэрлэн заасан ангилалд хамааруулбал зохих шүүхийн шийдвэрүүдийг мөн оруулсан байдал харагдаж байна.
- Захиргааны хэргийг шийдвэрлэсэн шүүгч шийдвэрээ бичихдээ маргааны төрлийг тодорхойлж “төрийн хяналт шалгалт”, “төрийн

болон орон нутгийн өмч”, “хуулийн этгээдийн улсын бүртгэл”, “төрийн алба”, “татвар”, “ашигт малтмал” гэх зэргээр бичиж байгаа нь шүүхийн шийдвэрийн цахим сангийн ангиллыг хөгжүүлэх анхдагч эх сурвалж, нэг гол хүчин зүйл болохоор байна. Өөрөөр хэлбэл, шүүхийн шийдвэрт дурдагдсан ангиллыг баримтлан цахим санд тухайн шийдвэрийг шууд байршуулах, хэрэв тус ангилал цахим санд байхгүй бол ангиллыг баяжуулж боловсронгуй болгох шаардлага үүсэх юм.

- Шүүхийн шийдвэрт дурдагдсан иргэн, хуулийн этгээд, өмч хөрөнгийн талаарх мэдээллийг өөрчилж нууцалсан байдал харилцан адилгүй, тухайлбал, 2014-2022 оныг хүртэлх шүүхийн шийдвэрт дурдагдсан дээрх мэдээлэлд ямар нэгэн нууцлал ба өөрчлөлт байхгүй, 2022 оноос өнөөг хүртэлх шүүхийн шийдвэрүүд од (“*”) болон цэг (“.”) гэсэн тэмдэглэгээгээр мэдээлэлд өөрчлөлт хийж нууцлан нийтэлсэн байна. Ийнхүү нийтлэхдээ цөөн тохиолдолд шүүгч болон шүүх хуралдааны нарийн бичгийн даргын нэрийг од (“*”) тэмдэглэгээ болон овог, нэрийн эхний үсгээр товчилжээ. Харин давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шийдвэрт од (“*”) тэмдэглэгээ бүхий нууцлалыг хэрэглээгүй, зарим тохиолдолд бүрэн эхээрээ, дийлэнхдээ шүүхийн шийдвэрт нэр нь дурдагдсан иргэн, хуулийн этгээдийн овог, нэрийн эхний үсгээр товчилж нийтэлсэн байна.
- Шүүхийн шийдвэрийн “тодорхойлох” хэсэгт шүүхийн шийдвэрт дурдагдсан иргэн, хуулийн этгээдийн нэрийг өөрчилж, нууцалсан хэрнээ үндэслэх болон тогтоох хэсэгт нэрийг өөрчилж нууцлалгүй бичсэн тохиолдлууд цөөнгүй илэрч байна.
- Од (“*”) тэмдэглэгээ бүхий өөрчлөлтийг оруулж нийтэлсэн шүүхийн шийдвэр нь уншиж судлахад төвөгтэй, тухайлбал, овог, нэрийг өөрчилж, нууцлах программ тухайн өгөгдөлд хамаарах бүх үгийг нууцалдгийн улмаас үгийн утга алдагдаж, улмаар шүүхийн дүгнэлтийн хэсэг ойлгомжгүй болсон тохиолдлууд байна.
- Шүүхийн шийдвэрийн цахим сангийн хайлтын хэсэгт “*түлхүүр үг*”-ийн талбар байгаа боловч “*түлхүүр үг*”-ээр хайх тохиргоо хийгдээгүйн улмаас шүүхийн шийдвэрийг хайж олоход үлэмж бэрхшээл учирч байх бөгөөд тухайлсан нэг шүүхийн шийдвэрийг хайж олоход нэлээдгүй хугацаа зарцуулж байна.

- Шүүхийн шийдвэрийн цахим сангийн “*холбоотой шийдвэр*”-ийн талбарт тухайн маргааныг давж заалдах, хяналтын журмаар шийдвэрлэсэн шүүхийн магадлал, тогтоолыг оруулах ёстой боловч зарим тохиолдолд тус шийдвэрт үл хамаарах буюу өөр хэргийг шийдвэрлэсэн магадлал, тогтоолыг оруулсан тохиолдол байна.
- Шүүхийн шийдвэрийн цахим санд анхан шатны шүүхийн шийдвэрүүдийг маргааны төрлөөр ангилж байршуулахдаа ангилал давхцуулсан, өөрөөр хэлбэл нэг шүүхийн шийдвэрийг хэд хэдэн ангилалд нэгэн зэрэг байршуулсан байна. Тухайлбал төрийн хяналт шалгалт гэсэн маргааны төрөлд байх шүүхийн шийдвэрүүдийг төрийн болон орон нутгийн өмч гэсэн төрөлд давхардуулан оруулсан байна.
- Шүүхийн шийдвэрийн цахим сангийн маргааны төрлийн зарим ангиллуудын ялгаа зааг тодорхой бус тухайлбал, “Төрийн алба”, “Төрийн албан хаагчийн хөдөлмөр” гэсэн ангиллын ялгаа тодорхой биш, адил төстэй улмаас нэг төрлийн шүүхийн шийдвэрүүдийг эл хоёр ангилалд хувааж, заримдаа аль алинд нь давхардуулан оруулсан тохиолдол байна.
- Шүүхийн шийдвэрийн цахим санд нийтэлсэн шүүхийн шийдвэрийг татаж авахад “PDF” биш “Microsoft word” хэлбэрээр файл үүсэж байгаагийн улмаас шүүхийн шийдвэрийн “Төрийн сүлд”-ийн болон “эх бичвэр”-ийн хэсэг эвдэрч, гажилт орж байна. Тухайлбал “Төрийн сүлд”-ний хэмжээнд өөрчлөлт орж нэг бүтэн нүүр болох, шийдвэрийн эх бичвэр эхний нүүрэнд хэвлэгдэхгүй байх гэх мэт байдалтай байна.

Б. Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхээр үйлчлүүлж буй иргэдийн дунд явуулсан асуулга:

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхээр үйлчлүүлж буй иргэдээс 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдрөөс 07 дугаар сарын 03-ны өдрүүдэд асуулгын аргаар судалгаа авсан бөгөөд судалгаанд нийт 100 иргэн хамрагдаж дараах үр дүн гарсан.

Судалгаанд оролцогчдын 47 хувь нь шүүхийн шийдвэрийг нээлттэй байлгах ёстой, энэ нь иргэд шүүхийн үйл ажиллагаанд хяналт тавих

нэг боломж, мөн өөрт тохиолдсон хэрэг, маргааны талаар ижил төстэй шүүхийн шийдвэрээс ойлголт, мэдээлэл авах боломж олгодог гэж үзсэн.

Мөн судалгаанд оролцсон иргэдийн олонх нь шүүхийн шийдвэрийг шүүхийн байгууллага болон интернэтээс авах боломжтой талаар хариулж, шүүхийн шийдвэрийн цахим сан (www.shuukh.mn) байдаг талаар мэддэг (76хувь) байна. Судалгаанд оролцсон иргэдийн 41хувь нь шүүхийн шийдвэрийн цахим сангийн талаар мэдээлэл, сурталчилгаа хүлээн авч байсан бол 59 хувь нь тийм мэдээлэл, сурталчилгааг хүлээн авч байгаагүй байна.

Шүүхийн шийдвэрийн цахим сан (www.shuukh.mn)-ийн талаар мэддэг иргэдийн 56 хувь нь уг санг өөрийн хэрэгцээнд нийцүүлэн ашигладаг бол 44 хувь ашигладаггүй байна.

Шүүхийн шийдвэрийн цахим санг ашигладаг иргэдийн 47 хувь нь жилд 1-5 удаа, 12 хувь нь жилд 5-10 удаа, 16 хувь нь жилд 10-аас дээш удаа нэвтэрдэг байна.

Түүнчлэн шүүхийн шийдвэрээс ямар төрлийн мэдээлэл олж авдаг болохыг тодруулах зорилгоор “*та шүүхийн шийдвэрийг уншаад ямар мэдээлэл авна гэж бодож байна вэ?*” гэсэн асуултад иргэдийн 45хувь нь өөрт тохиолдсон асуудалтай адил төсөөтэй тохиолдлыг шүүх хэрхэн шийдвэрлэдэг талаар мэдэж авдаг, 21хувь нь олон нийтийн анхаарал татсан хэргийг шүүх хэрхэн шийдвэрлэснийг мэдэж авдаг, 8хувь нь өөрийн төрөл садан, найз нөхдөд холбогдох хэргийг шүүх хэрхэн шийдвэрлэсэн талаар мэдэж авдаг, 4хувь нь өөрт тохиолдсон асуудлыг шүүх хэрхэн шийдвэрлэдэг талаар болон өөрийн төрөл садан, найз нөхдөд холбогдох хэргийг шүүх хэрхэн шийдвэрлэсэн талаар мэдэж авдаг, 7хувь нь өөрт тохиолдсон асуудлыг шүүх хэрхэн шийдвэрлэдэг талаар мөн олон нийтийн анхаарал татсан хэргийг шүүх хэрхэн шийдвэрлэсэн болон өөрийн төрөл садан, найз нөхдөд холбогдох хэргийг шүүх хэрхэн шийдвэрлэсэн талаар мэдэж авдаг, 10хувь нь өөрт тохиолдсон асуудлыг шүүх хэрхэн шийдвэрлэдэг талаар болон олон нийтийн анхаарал татсан хэргийг шүүх хэрхэн шийдвэрлэснийг мэдэж авдаг, 4хувь нь тус асуултад хариулт өгөөгүй байна.

В. Шүүхийн шүүхийн захиргааны ажилтнуудын дунд явуулсан судалгаа:

Тус судалгааг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын дарга, шүүгчийн туслах, мэдээлэл технологийн мэргэжилтнээс ярилцлагын аргаар авсан болно.

Шүүхийн шийдвэрийн цахим сан (www.shuukh.mn)-д шийдвэрийг нийтлэх явцад тухайн шүүхийн Тамгын газрын дарга хяналт хэрэгжүүлж, тайланг сар бүр Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлдэг бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт тавьж, үр дүнг оноогоор дүгнэдэг байна.

Шүүхийн шийдвэрийн цахим сан (www.shuukh.mn)-д шүүхийн шийдвэрийг байршуулах ажлыг шүүгчийн туслах хариуцан хэрэгжүүлэх бөгөөд шүүхийн мэдээлэл технологийн мэргэжилтэн тухайн шийдвэрийг холбогдох журамд заасан хугацаанд багтаж оруулж байгаа эсэх, мөн шүүхийн шийдвэрт дурдагдсан хүн, хуулийн этгээдийн мэдээлэлд зөв өөрчлөлт оруулсан эсэхэд хяналт тавьж, 7 хоног тутмын Тамгын газрын шуурхай хуралдаанд танилцуулдаг байна.

Шүүхийн шийдвэрийг цахим сан (www.shuukh.mn)-д байршуулах үйл ажиллагааны хяналтыг дараах байдлаар хэрэгжүүлж байна. Үүнд, (1) *Шуурхай хурлын сонсгол*. Даваа гараг бүрийн өглөөний 09:00 цагийн шуурхай хурлаар өмнөх 7 хоногийн ажлын тайланг хэлэлцдэг бөгөөд энэ хурлаас цахим санд байршуулсан шийдвэрийн талаарх тайлан сонсдог, (2) *Дотоод сүлжээний хяналт*. Программын буюу дотоод сүлжээний хяналтыг тухай бүр хэрэгжүүлдэг байна, (3) *Мэргэжилтний хяналт*. Мэдээлэл, технологийн мэргэжилтнүүд өдөр тутам шүүхийн шийдвэрийг цахим сан (www.shuukh.mn)-д байршуулах үйл ажиллагааны хяналт тавьж шаардаж ажилладаг.

Хэрэв тухайн шүүгчийн туслах шүүхийн шийдвэрээ цахим санд байршуулах хугацааг хоцроовол гүйцэтгэлийн үр дүнгийн урамшуулал хасагддаг тул энэ тал дээр ихээхэн анхаарал хандуулдаг ба шийдвэрийг хугацаа хоцроож цахим санд оруулах тохиолдол харьцангуй цөөн байдаг байна.

Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх нь Монгол Улсын хэмжээнд захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгдэж буй хэрэг, маргааны 70 орчим хувийг дангаараа шийдвэрлэдэг, үүнтэй холбоотойгоор шүүгчийн туслахын ажлын ачаалал их боловч, тэд цахим санд шийдвэрээ хугацаанд нь байршуулаагүй тохиолдол цөөн гардаг, шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах ажил нь ажлын ачаалал үүсгэж байгаа талаар гомдол, санал гаргаж байгаагүй ажээ.

Шүүхийн шийдвэрт дурдагдсан хүн, хуулийн этгээд тэдгээрийн өмч хөрөнгөтэй холбоотой мэдээллийг дутуу нууцалсантай холбоотой гомдол, хүсэлт цөөн гардаг бөгөөд үүнийг тухай бүр холбогдох журамд заасны дагуу нууцлалын шаардлагыг хангуулж шийдвэрлэдэг байна.

Шүүхийн шийдвэрийн цахим сан (www.shuukh.mn) шинэчлэгдсэнээр өмнө нь WORD дээр нэг бүрчлэн шийдвэрээ засаж шивдэг байсан техник ажиллагааг өөрчилж программд хориглох үгийн тохиргоогоор хийдэг болсноор тухайн үг нууцлагдаж, шүүхийн шийдвэрийн бүх хэсэгт ижил байдлаар харагддаг болсон байна. Хэрэв шүүхийн шийдвэрийн WORD хэлбэр дээр нууцлахтай холбоотой засварыг оруулж, шүүхийн шийдвэрийн цахим санд оруулсан тохиолдолд од (“*”) тэмдэглэгээгүй зөвхөн овог, нэрийн эхний үсгүүдээр харагддаг байна.

Зарим тохиолдолд од (“*”) тэмдэглэгээг ашиглан нууцлалын тохиргоог хийх явцад тодорхой бэрхшээлүүд үүсдэг байна. Жишээ нь: Ч.Батболд гэдэг нэрийг нууцлахад хориглох үг дээр “атболд” гээд оруулах ба программд Ч.Б***** гэж харагдана. Зарим тохиолдолд Од гэдэг хүний нэрийг нууцлахаар “д” үсгийг дангаар нь нууцалбал шийдвэрт байгаа бүх “д” үсэг нууцлагдана. Тийм тохиолдолд WORD-р нэг бүрчлэн гар аргаар засахаас өөр аргагүй болдог байна.

Үүнээс үзэхэд (1) шүүхийн шийдвэрийг нийтлэх эрх зүйн орчин бий болсон байх бөгөөд, эдүгээ хориглосноос бусад шүүхийн шийдвэрийг нийтэлж, ийнхүү нийтлэхдээ шүүхийн шийдвэрийг бүхэлд нь болон тойм байдлаар нийтлэх аргыг түгээмэл хэрэглэж байна, (2) шүүхийн шийдвэрийг дээрх аргаар нийтлэхдээ шүүх хуралдааны оролцогчдын аюулгүй байдал, төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах үүднээс зарим мэдээллийг өөрчилж, товчилж, хасч байна, (3) түүнчлэн

шүүхийн шийдвэрийг нийтлэхдээ цахим хуудас (www.shuukh.mn)-ийг түгээмэл ашиглахын зэрэгцээ цаасан хэлбэрийг заримдаа ашиглаж байна.

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

1. Шүүхийн шийдвэрийн ач холбогдол, үнэ цэнийг хүлээн зөвшөөрөх болсон өнөө үед шүүхийн шийдвэрийг ил тод болгох нь эрдэм шинжилгээ судалгааны ажил төдийгүй, хууль тогтоомжийг боловсронгуй болгох улмаар эрх зүйн тогтолцоог хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлэхээр байна.
2. Шүүхийн шийдвэрийг ил тод болгох буюу нийтлэхэд хориглосноос бусдыг нийтлэх (negative selection), сонгож нийтлэх (positive selection) гэсэн хоёр арга хэрэглэгддэг бөгөөд Монгол Улсын хувьд шүүхийн шийдвэрийн цахим сан (shuukh.mn) ашиглалтад орох хүртэл сонгож нийтлэх аргыг, тус цахим сан ашиглалтад орсноор хориглосноос бусдыг нийтлэх арга хэрэглэгдэж байна.
3. Шүүхийн шийдвэрийг интернэт орчинд ил тод болгох буюу нийтлэхдээ шүүхийн шийдвэрийн цахим санг нийтлэг ашиглах болсон байх ба шүүх хуралдааны оролцогчдын аюулгүй байдал, төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах үүднээс зарим мэдээллийг хасаж, өөрчилж, товчлох болсон байна. Монгол Улсын хувьд мөн шүүхийн шийдвэрийн цахим сан (shuukh.mn)-г түгээмэл ашиглаж байгаагийн зэрэгцээ тойм байдлаар нийтлэх аргыг хэрэглэж байна.
4. Монгол Улсын хувьд шүүхийн шийдвэрийн цахим сан (shuukh.mn)-д хориглосноос бусдыг нийтлэх (negative selection) зарчмын дагуу шүүхийн шийдвэрүүдийг нийтэлсэн боловч мэдээлэл олж авахад чухал үүрэг гүйцэтгэдэг метадата буюу хайлт хийж хүссэн мэдээллээ тодорхойлох, илэрц дотроос дахин нарийвчилж хайх, тухайн шийдвэрийн утга, агуулгыг ойлгох, түүнтэй холбоотой бусад мэдээллийг тодруулах зэрэгт зайлшгүй хэрэгтэй байдаг талбар цөөн, мөн тухайн шүүхийн шийдвэрийг хайж олох түлхүүр үгийн талбар ажиллахгүй байгаатай холбоотой бэрхшээл үүсч, энэ нь шүүхийн шийдвэрийг ил тод болгох зорилгыг гажуудуулахад хүргэж байна.


5. Шүүхийн шийдвэрийн хураангуй хувилбар буюу тоймийг хэвлэн нийтлэх нь олон нийтэд хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны ойлгомжтой байдлыг бүрдүүлэх улмаар шүүхийн шийдвэрийн ил тод байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэхээр байна.
6. Шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдал, төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах үүднээс зарим мэдээллийг өөрчилж танигдахгүй болгохтой холбогдон үүсэх харилцааг хууль тогтоомжоор зохицуулаагүй харин журамд зарим “мэдээллийг тодорхойлох боломжгүй болгон нууцлах” талаар тусгасан ба практикт “од” (“*”) тэмдэглээг хэрэглэж журмын заалтын хэрэгжилтийг хангаж байгаа нь шүүхийн шийдвэрийг хэрэглэгчдэд ойлгомжгүй, ашиглахад бэрхшээлтэй болгож байна.
7. Монгол Улсын хувьд шүүхийн шийдвэрийн цахим сан (www.shuukh.mn) нийтэлсэн шүүхийн шийдвэрүүдийг шүүхийн харьяаллаар ангилахын зэрэгцээ захиргааны хэргийн хувьд маргааны төрлийг баримжаа болгож ангилсан нь нийтлэг жишигт нийцэж байх боловч хэт ерөнхий, маргааны цөм төрлийг илэрхийлж чадахгүй байна.
8. Гадаад улс орнуудын туршлагаас үзэхэд шүүхийн шийдвэрүүдийг ил тод болгохтой холбоотойгоор (1) шүүхийн шийдвэрийн цахим санд байршуулсан шийдвэрийг ашиглахад ямар нэгэн хязгаарлалт байхгүй, (2) шүүхийн шийдвэрийн цахим санд байршуулсан шийдвэрийг ашиглахад тодорхой хязгаарлалттай, өөрөөр хэлбэл лиценз буюу зөвшөөрөл авахыг шаарддаг, (3) шүүхийн шийдвэрийн цахим санд байршуулсан шийдвэрийг арилжааны зорилгоор ашиглахыг хориглож байна. Монгол Улсын хувьд шүүхийн шийдвэрийн цахим сан (shuukh.mn)-д нийтэлсэн шүүхийн шийдвэрийг ашиглахад ямар нэгэн хязгаарлалт байхгүй байна.

Судалгааны дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:


1. Шүүхийн шийдвэрийг ил тод болгохтой холбогдон үүсэх харилцаа нь аюулгүй байдал, төр, байгууллага, хувь хүний нууцтай шууд холбоотой тул эл харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай бөгөөд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуульд нийцүүлэх шаардлагатай байна;
2. Шүүхийн шийдвэрийн ил тод байдал нь түүний ил тод байдлыг хангаж буй цахим хуудастай салшгүй холбоотой тул шүүхийн шийдвэрээс мэдээлэл олж авахад чухал үүрэг гүйцэтгэдэг метадатаг боловсронгуй болгох, мөн тухайн шүүхийн шийдвэрийг хайж олох түлхүүр үгийн тохиргоог бий болгож хэрэглээнд оруулах шаардлагатай;
3. Шүүхийн шийдвэрийн цахим сан (shuukh.mn)-д нийтэлж байгаа шийдвэрүүдийн хураангуй хувилбар буюу тоймыг нийтлэх;
4. Шүүхийн шийдвэрийг шүүгч албажуулснаас хойш 14 хоногийн дотор цахим санд нийтэлдэг журмын зохицуулалтыг 3 хоногийн дотор нийтэлдэг байхаар өөрчлөх, тодруулбал шүүхийн практикийг харгалзан үзэх тухай хуулийн заалт үйлчилж эхэлсэн тул шүүхийн практиктай даруй танилцах боломжийг иргэн, хуулийн этгээдэд олгох ёстой;
5. Шүүхийн шийдвэрийг хэрэглэж, ашиглахад ойлгомжтой хялбар болохын тулд цахим санд нийтлэхдээ хэргийн оролцогч болон бусад оролцогчийн овог, нэрийн эхний үсгээр товчилсон байдлаар нийтлэх;
6. Монгол Улсын хувьд шүүхийн шийдвэрийн цахим сан (www.shuukh.mn) нийтэлсэн шүүхийн шийдвэрүүдийг маргааны төрлөөр ангилахын зэрэгцээ илүү нарийвчлах зорилгоор дэд төрөл үүсгэх (тухайлбал, маргааны төрөл: газар. Дэд төрөл: газрын төлбөр, газар эзэмших эрхийн хугацаа гэх зэрэг).

ХАВСРАЛТ 1. НИЙСЛЭЛ ДЭХ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХЭЭР ҮЙЛЧЛҮҮЛЖ БҮЙ ИРГЭДИЙН ДУНД ШҮҮХИЙН ЦАХИМ САНГИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТАЛААР ЯВУУЛСАН АСУУЛГЫН ДҮН


1. Захиргааны хэргийн шүүхэд хандаж байсан уу?




2. Та шүүхийн шийдвэрийг ил тод болгох хэрэгтэй гэж үзэж байна уу? Яагаад?




3. Та шүүхийн шийдвэрийн талаарх мэдээллийг хаанаас авах боломжтой гэж бодож байна вэ?




4. Та шүүхийн шийдвэрийн цахим сан www.shuikh.mn цахим хуудсын талаар мэдэх үү?




5. Та шүүхийн шийдвэрийн цахим сан www.shuikh.mn-г ашигладаг уу?




6. Та шүүхийн шийдвэрийн цахим сан www.shuikh.mn-г ямар давтамжтай ашигладаг вэ?



7. Та шүүхийн шийдвэрийн цахим сан www.shuikh.mn-ын талаар мэдээлэл, сурталчилгаа авч байсан уу?



8. Та шүүхийн шийдвэрийг уншаад ямар мэдээлэл авна гэж бодож байна вэ?



- Өөрт тохиолдсон асуудлыг шүүх хэрхэн шийдвэрлэдэг талаар мэдэж авах
- Өөрийн төрөл садан, найз нөхдөд холбогдох хэргийг шүүх хэрхэн шийдвэрлэсэн талаар мэдэж авах
- Олон нийтийн анхаарал татсан хэргийг шүүх хэрхэн шийдвэрлэснийг мэдэж авах
- Өөрт тохиолдсон асуудал болон өөрийн төрөл садан, найз нөхдөд холбогдох хэргийг шүүх хэрхэн шийдвэрлэсэн талаар мэдэж авах
- Өөрт болон өөрийн төрөл садан, найз нөхдөд холбогдох хэрэг, олон нийтийн анхаарал татсан хэргийг шүүх хэрхэн шийдвэрлэсэн талаар мэдэж авах
- Өөрт тохиолдсон асуудал болон олон нийтийн анхаарал татсан хэргийг шүүх хэрхэн шийдвэрлэсэн талаар мэдэж авах
- Өөрийн төрөл садан, найз нөхдөд холбогдох хэрэг болон олон нийтийн анхаарал татсан хэргийг шүүх хэрхэн шийдвэрлэсэн талаар мэдэж авах
- Хариулаагүй

ХАВСРАЛТ 2. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ЦАХИМ САНГИЙН ТАЛААР ЯРИЛЦЛАГЫН АРГААР ХИЙСЭН СУДАЛГАА

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх нийт 19 шүүгчийн туслахтай. Бид 9 шүүгчийн туслахтай уулзан асуумж ярилцлага хийлээ.

Асуулт 1. Та шүүгчийн туслахаар хэд дэх жилдээ ажиллаж байгаа вэ?

№	Шүүгч	Шүүгчийн туслах	Ажилласан хугацаа
1.	Ц.Одмаа	Б.Цэрэнханд	6 сар
2.	С.Ганбат	Б.Баярдулам	4 жил
3.	Д.Чанцалням	Б.Төгөлдөр	2,5 жил
4.	Ө.Болорчимэг	Г.Хан-Уул	
5.	Т.Мөнх-Эрдэнэ	Т.Батсүмбэр-Уул	2 жил
6.	У.Бадамсүрэн	Ц.Оюун-Эрдэнэ	Иргэний шүүхэд 6 жил, захиргааны шүүхэд 6 сар
7.	Д.Халиунаа	О.Энхзол	1 жил
8.	Л.Батбаатар	М.Ренчинмядаг	1 жил
9.	Д.Эрдэнэчимэг	Б.Оюунтунгалаг	3 сар

Асуулт 2. Шүүгчийн туслахын ажил цэрэгт юу юу хамаарахыг хэлж өгнө үү? Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах ажлыг нийт ажлын ачааллын хувиар тооцвол ямар дүр зураг гарах вэ?

Хариулт 1: Нийт ажлын 5 хувь орчим хувийг эзэлнэ. Шийдвэрээ дор дор нь оруулдаг ба хувь хүний ажлын хуваарилалт, зохион байгуулалтаас хамаарна. Зарим нь 4,5-аар нь шийдвэрүүдээ бөөгнүүлж байгаад нэг дор оруулдаг бол зарим туслахууд тухай бүртээ оруулдаг гээд янз бүр. Шийдвэр оруулахад нээх айхтар ачаалал байдаггүй. Нууцтай шийдвэрийг ч оруулна. Гэхдээ сонголтээр нууц гэдгээ сонгоод нэхэмжлэгч, хариуцагч, 106-ын хэдээр шийдвэрлэсэн

гэдгээ л оруулна. Зөвхөн тогтоох хэсгээ л гэсэн үг. Хэргийн оролцогчид өөрсдийнхөө шийдвэрийг нууцлуулъя гэж хүсэлт, албан бичгээ өгсөн ч Тамгын газраас оруулахгүй байх зохицуулалтад хамаарахгүй учир шийдвэрүүдээ оруулдаг, бүх шийдвэр орно, зөвхөн хаалттай хурлын шийдвэр л орохгүй.

Хариулт 2: 3-5 хувь. Олон хуудастай хэрэг нууцлахад цаг ажиллагаа заримдаа их. Бүхэлдээ нууц хэрэг бол хэргийн огноо дугаарыг л оруулаад өөр мэдээлэл оруулахгүй.

Асуулт 3. “Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах журам” 2022 оны 4 сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж байна. Энэ шинэ журам гарснаар ямар эерэг өөрчлөлт гарсан бэ? Өмнө үйлчилж байсан журмаас юугаараа ялгаатай вэ?

Хариулт 1: Айхтар ялгаа байхгүй. Хийж байгаа процессын хувьд өөрчлөгдөөгүй. “Хориглох үгс” гэсэн тохиргоогоор нууцлах үгээ автоматаар оруулчихаар тэр үг тухайн шүүхийн шийдвэртээ бүгдээрээ нууцлагддаг. Хүний нэрийн үсгээр од автоматаар солигддог. Шинэ журмаар хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн хэргийнхийг оруулдаг болсон. Өмнө нь хийдэггүй байсан. 109.2-оор Шүүгчийн захирамж хэвээр үлдсэн бол шийдсэн хэрэгтээ ордог. Хэргийн оролцогчдоос бичгээр саналыг нь авдаг ч бид хуулийн дагуу оруулдаг гэдгээ тайлбарлаж хэлдэг.

Хариулт 2: Өмгөөлөгч нар өмнөх нь амар байсан гэдэг ч бидний хувьд ялгаа нээх айхтар байхгүй. Систем нь сайжирсан. Өмнө нь WORD дээр нэг бүрчлэн шийдвэрээ шивж засдаг байсан бол одоо программаар хориглох үгээ нэг тохиргоо өгчихвөл нийтээрээ нууцлагддаг амар болсон.

Асуулт 4. Шүцхийн шийдвэр шүцх хуралдаанаас хойш дунджаар ямар хугацаанд албажиж бэлэн болдог вэ?

Хариулт 1: 14 хоног дотроо. Ачааллаасаа хамаарна. Хугацаа хэтрэх асуудал шүүгч бүрт янз бүр байдаг. Хугацаа хэтэрвэл шүүгчийн ажлын үзүүлэлт гүйцэтгэлд нөлөөлдөг. Хяналтыг ИТ хийдэг.

Хариулт 2: Шүүгч бүрийн ачааллаас харилцан адилгүй гэхдээ 14 хоног.

Асуулт 5. Бэлэн болсон шийдвэрийг дунджаар ямар хугацааны дотор цахим хуудаст байршуулдаг вэ? Байршуулахын өмнө шийдвэрийн эх бичвэрт ямар нэг өөрчлөлт хийдэг үү?

Хариулт 1: Гарснаараа л орно. Өөрчлөлт оруулдаггүй. Олон хуудастай шийдвэрээсээ хамааран нууцлах ажиллагаа их байдаг. Ямар ч хүний нэр тэр тэр байтугай өмгөөлөгчийн нэр, өмгөөлөгчийн үнэмлэхийн дугаар, үл хөдлөх гэрчилгээний дугаар, хаяг гэх мэт мэдээлэл оруулахгүй.

Хариулт 2: Захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн систем гэж байдаг. Бид албажуулсан шийдвэрээ тэр чигээр нь хөрвүүлдэг. Тэр систем өөрөө хөрвүүлэнгүүт бид нууцлах үгээ тохиргоо хийж засдаг. Эх бичвэрт өөрчлөлт хийхгүй.

Асуулт 6. Шийдвэрийг байршуулахад эх бичвэрийн файлыг upload хийхээс гадна систем дээр өөр ямар үйлдэл хийдэг вэ? Системд шийдвэр байршуулахад ашигладаг цонх нь ямар бүтэцтэй байдаг вэ?

Хариулт: Огноо, шийдвэрийн дугаар, хэргийн индексийг гараар шивж оруулна. Нууцлал, нэр регистр хувийн мэдээллийг нууцална.

Асуулт 7. Шүцхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулахад ямар нэг техникийн саатал, өөр хүндрэл, бэрхшээл гардаг уу?

Хариулт: Системд шийдвэр оруулахаар алдаа заагаад орохгүй тохиолдол байдаг. Энэ тохиолдолд IT-д хандаад өөрөөр нь засуулдаг. Бичвэрийн хэмжээ хэтрэхээр алдаа заадаг.

Асуулт 8. ШЕЗ болон тус байгууллагын ажилтнуудтай холбоотой ажилладаг уу?

Хариулт 1: Дотоодынхоо мэдээллийн технологийн мэргэжилтэнтэйгээ харьцаад хянуулаад явдаг. Манай IT бол шийдвэр рүү нь ороод маш нарийн хянадаг. Нэр нь нууцлаагүй байна шүү гээд сануулдаг.

Хариулт 2: Дотоодынхоо IT-д л ханддаг.

Асуулт 8. Шүцхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах талаар Тамгын даргатай ямар ажил хэргийн холбоотой ажилладаг вэ?

Хариулт 1: Тамгын дарга бидний ажлыг программаар хянадаг. Хугацаандаа оруулаагүй байна, оруулаарай гээд 7 хоног бүр шуурхай дээр биднийг шахаад сануулаад явдаг учраас хугацаа хэтрэх асуудал тийм их гардаггүй.

Хариулт 2: Өөр мэдээ тайлан гаргах асуудлаар Тамгын даргад танилцуулна, гэхдээ л мэдээлэл технологийн мэргэжилтэн бидний цахим сангийн асуудлыг хянаад явдаг.

Мэдээллийн технологийн мэргэжилтэн Б.Батболд:

Би shuukh.mn -д тулгалт хийгээд 7 хоног бүр хэн шүүгчийн хэчнээн шийдвэр баталгаажсан байна гэдгийг харна. Баталгаажсанаас хойш хуулийн хугацаандаа буюу 14 хоногтоо орсон эсэхийг хянана. Нийт 28 хоногийн дотор цахим санд байршсан байх ёстой. Түүнээс хэтэрвэл хугацаа хэтэрсэнд тооцно. Албажих хүртэл 14 хоног, албажсанаас хойш 14 хоног. Би шийдвэрээ заримдаа бүхэлд нь хянах тохиолдол байна. Шийдвэрүүдийн дугаар авахаа мартсан байвал хүсэлтээ надад өгөхөөр би огноо сольж өгдөг. Харин төлөв янзлуулах болон нэхэмжлэл засуулах, устгах бол ШЕЗ рүү албан бичиг явуулдаг.

Би 4 сарын 3-нд анх ажил хүлээж авснаасаа хойш өнөөдрийг хүртэл тулгалт сайн хийж байна. Зарим хэргүүд ороогүй үлдсэн ч тохиолдол байна. Ажлын ачааллаас болдог юм уу шүүгчийн туслахууд их солигдож ажил хүлээлцэж байна. Хэдэн хэрэг албажсан, хэдийг хүлээлгэж өгөөгүй байна гээд тэгж тулгахгүй болохоор үлдэж зөрүү гараад байгаа байх гэж бодож байна. Тэгэхээр 2022 оны тайлан мэдээ болон shuukh.mn дотор зөрүүтэй мэдээлэл нь нэг бол ороогүй үлдсэн шийдвэр нөгөө нь нууцын зэрэглэлтэй хэргүүд байх боломжтой. Нууцын эрхлэгч нууцтай мэдээг хариуцдаг. Нууцын эрхлэгч тайлан мэдээгээ ТЕГ руу хүргүүлнэ. Гэхдээ тийм олон нууцтай хэрэг байна гэж байхгүй. Би өмнө нь Эрүүгийн шүүхэд ажиллаж байхад жилдээ 7 хэрэг байдаг байсан. Тэгэхээр олон нууцтай хэрэг байна гэж байхгүй.

Зарим нь WORD дээр засчхаад хөрвүүлэхээр одгүй шууд дан эхний үсгүүд нь орж байгаа. Зарим нь программаараа хориглох үгээрээ тохиргоо хийчихээр нэр нь бүхэлдээ болон сүүлийн үсгүүд нууцлагдаад байгаа. Нэр нь ил биш нууц байх л чухал болохоос одтой, одгүй байх эсэх нь ач холбогдолтой биш ээ. Нууцлах нь нэр нь мэдэгдэхгүй байхад л болоо гэж үзэж байна. Шинээр ажилд орж байхад нь анх яаж оруулах тухай зааж чиглүүлдэг. Өөрсдөө мэдэхгүй юмаа орж ирээд асуухад би зөвлөөд заагаад өгдөг.

Нийт 19 шүүгчийн шийдвэрүүд хоцордог тоо нь 7 хоногт дунджаар 30-аад байдаг. Уг нь хугацаа хоцрох нь хариуцлага тооцох ёстой асуудал. Гэвч бид боловсон хүчний тогтвортой байдлыг хангах үүднээс буруу зөрүүд нь хариуцлага хүлээлгэхээс илүү зааж зөвлөөд явдаг.

Маргааны төрлийн сонголтыг ШЕЗ оруулж өгдөг. Шийдвэрээ оруулахдаа туслахууд аль маргаан байгааг өөрсдөө сонгоно.

Жишээгээр харсан тохиолдлын хувьд магадлалд нууцлаагүй байгаа нь шүүгчийн туслахын хариуцлагагүй байдлын асуудал байна. Уг нь бол адилхан нууцлал хийх ёстой. ШЕЗ нэгдсэн байдлаар бүх шийдвэрийг хянаж нэг бүрчлэн хянах ямар ч боломжгүй. Тийм учраас шүүх бүрийн мэдээлэл технологийн мэргэжилтэн л дор бүрд хяналт тавих ёстой.

Жишээ нь: Ч.Батболд гэж нэрийг нууцлахад хориглох үг дээр “атболд” гээд оруулахад программд Ч.Б***** гэж харагдана. Зарим тохиолдолд Од гэж хүний нэрийг нууцлахаар “д” үсгийн дангаар нь нууцалбал шийдвэрт байгаа бүх “д” үсэг нууцлагдана. Тийм тохиолдолд WORD-р нэг бүрчлэн гар аргаар засахаас өөр арга байхгүй. Зарим шийдвэрт нэрийн эхний үсгүүд эсхүл нэр бүтнээрээ од тэмдэг болсон байгаа нь шүүгчийн туслахууд янз бүр оруулж байгаа. Зорилго нь нууцлах нь л чухал болохоос яаж нууцлах нь тийм чухал бишээ. Заримдаа огт од тэмдэг байхгүй бол WORD дээр өөрөө засаад оруулж байгаа гэсэн үг. Шинэ систем од тэмдэгтэй нууцалж өгдөг.

ГУРАВ. ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ИЛ ТОД БОЛГОЖ БУЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Төсөл хэрэгжүүлэгч: Х.Адилмаа ахлагчтай судалгааны баг

Хамрагдах хүрээ: Төвийн бүсийн Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүх

Шүүхийн цахим санд оруулж байгаа шийдвэрүүд нь ашиглагчдын хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэх, шийдвэрт тусгагдсан оролцогчдын зохих нэр төр, нууцлалыг хангаж байгаа эсэх болон цахим санд байршуулахад гарч буй хүндрэл бэрхшээлийг тодруулан гаргаж холбогдох журмыг боловсронгуй болгоход чиглэсэн санал, дүгнэлт боловсруулах нь энэхүү мониторингийн үндсэн зорилго нь юм.

Энэхүү судалгааг Архангай, Баянхонгор, Булган, Хөвсгөл, Орхон, Өвөрхангай аймгуудын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 01 дүгээр сарын 01-ээс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд шийдвэрлэж, шүүхийн цахим санд нийтэлсэн хэргүүдийг эх сурвалж болгон хийж гүйцэтгэлээ.

Монгол Улсын хэмжээнд 2022 оны байдлаар иргэний хэргийн анхан шатны шүүх 57,663, давж заалдах шатны 3,048, хяналтын шатны шүүх 1291 хэрэг нийт 62,002 хянан шийдвэрлэсэн байна.¹⁸ Үүнээс судалгаанд хамрагдах шүүхийг бүсчилсэн байдлаар сонгож, Хөвсгөл, Булган, Орхон, Архангай, Өвөрхангай, Баянхонгор зургаан иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг бүхэлд нь судаллаа.

¹⁸ МУ-ын Шүүхийн 2022 оны тайлан

Хангайн бүс нь Монгол Улсын хамгийн олон хүн амтай бүс нутаг бөгөөд, 2022 онд улсын хэмжээнд 57,663 хэргийг иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэсний 23,580 нь аймаг, сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд харьяалагдаж байна. Аймаг, сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн 23,580 хэрэгтэй харьцуулбал Хангайн бүсийн 6-н аймагт 6,317 хэрэг шийдвэрлэсэн буюу нийт хэргийн 26.7 хувийг эзэлж байх тул иргэний хэргийн анхан шатны нийт шүүхийн шийдвэрийг төлөөлүүлэх боломжтой хэмээн үзэж болохоор байна.

Судалгаанд сонгогдсон шүүхүүдийн 2022 онд хянан шийдвэрлэсэн хэргийн тоо², цахим санд байршуулсан хэргийн тоог хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3. Төвийн бүсийн аймгуудын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 онд шийдвэрлэсэн хэргийн статистик

№	Анхан шатны шүүхийн нэр: (аймгаар)	Шийдвэрлэсэн хэргийн тоо	Shuukh.mn сайтад нийтэлсэн хэргийн тоо	Хувиар хувь
1	Хөвсгөл	1258	63	5,0хувь
2	Архангай	944	99	10,4хувь
3	Өвөрхангай	342	31	9,06хувь
4	Баянхонгор	939	79	8,41хувь
5	Булган	728	68	9,34хувь
6	Орхон	2106	297	14,10хувь
7	Нийт	6317	637	0,10хувь

Дээрх зургаан аймгийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн ил тод байдалд судалгаа хийхдээ, давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шийдвэрийг журамд заасны дагуу цахим санд байршуулсан эсэхэд давхар хяналт тавьсан болно.

Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн цахим санд байршсан байдлыг судлахад түүврийн аргаар, анхан шатны шүүхийн

шийдвэрээс сонгогдсон 2022 оны **603** шийдвэрт судалгаа хийнэ гэж төлөвлөсөн боловч судалгаа хийх явцад шийдвэрийн тоо нэмэгдсээр байсан тул нийт **637** шийдвэрийг судалж, дүн шинжилгээ хийсэн. Үүнээс үзвэл 2022 оны шийдвэрийг 2023 онд ч цахим сайтад нөхөн оруулж болдог нь харагдаж байлаа. Мөн сонгосон аймгуудын иргэний хэргийн анхан шатны шүүх 2022 онд 6,317 хэрэг шийдвэрлэснээс 637 шийдвэрийг цахим санд байршуулсан ч, байршуулах ёстой хэдэн шийдвэрийг цахим санд оруулаагүйг тодорхойлох боломжгүй байв.

Мөн Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 39 дүгээр тогтоолоор “Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах журам батлах тухай” Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн даргын 2017 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн А/44 дүгээр тушаалыг хүчингүй болгосонтой холбоотой 2022 оны шүүхийн шийдвэрийн цахим санд судалгаа хийхэд хуучин болон шинэ журмыг хоёуланг нь ашиглах шаардлагатай болсон. Тодруулбал сонгогдсон аймгуудын 2022 иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн цахим санд судалгаа хийхдээ 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнөх журамд хамаарах **203**, тухайн өдрөөс хойш үйлчилж буй журмын хүрээнд хамаарах **434** шийдвэрийг хамааруулав.

Судалгаанд тоон болон чанарын судалгааны аргуудыг хослуулан мэдээлэл цуглуулж, ангилан дүгнэж ажиллалаа.

Зургаан аймгийн нийт 637 шүүхийн шийдвэрийн мэдээллийг Excel MS программд оруулан ангилж, IBM SPSS Statistics 24.0 программаар боловсруулсан. Шүүхийн шийдвэрийг цахим санд оруулсан байдлыг тухайлсан асуулгын дагуу ангилан мэдээллийг боловсруулав.

Мөн шүүхийн шийдвэрийн цахим сангийн үйл ажиллагаа, түүнийг хэрхэн хөгжүүлэх, тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг тодруулах зорилгоор цахим санд шийдвэр байршуулдаг **16** албан хаагчидтай бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын аргаар мэдээлэл цуглууллаа.

Судалгаатай холбоотой журам болон цахим санд нийтлэхтэй холбоотой журмын биелэлтийг ханган ажиллаж албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө тайлан зэрэг албан бичиг баримтад дүн шинжилгээ хийж ажилласан болно.

Бид 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдрөөс тухайн оны 9 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэл “Хангайн бүсийн аймгуудын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны шийдвэрийн ил тод байдалд мониторинг хийх” ажлыг 18 долоо хоногийн хугацаанд 4-н гишүүний бүрэлдэхүүнтэйгээр хийж гүйцэтгэлээ.

3.1 ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ТООН СУДАЛГАА

Судалгаанд хамрагдсан 6-н аймгийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 637 шийдвэрийг маргааны төрлөөр ангилан харуулбал:

Хүснэгт 4. Хэрэг маргааны төрөл

Маргааны төрөл	Тоо	Хувь
Ажил гүйцэтгэх	16	2.5
Ажилласан жил тогтоолгох	3	5
Ажлаас буруу шилжүүлсэн	1	2
Ажлаас үндэслэлгүй халагдсан	11	1.7
Банкны зээл	72	11.3
Барьцаалан зээлдүүлэх байгууллагын зээл	7	1.1
Бусад зээл	115	18.1
Бусад хуулиар	59	9.3
Бусдын эзэмшил ашиглалтад байгаа газрын талаарх маргаан	7	1.1
Бэлэглэл	1	.2
Газартай холбогдсон хууль бус шийдвэрийг хүчингүй болгуулах	2	.3
Гүйцэтгэгчийн эд хөрөнгө үнэлсэн маргаан	1	2
Гэм хор учруулснаас гаргуулсан эд хөрөнгийн хохирол	34	5.3
Гэм хор учруулснаас гаргуулсан эрүүл мэндийн хохирол	12	1.9
Гэрлэлт цуцалсан	75	11.8
Даатгал	2	3
Нийгмийн даатгалын шимтгэлийн маргаан	1	2
Өвлөх	2	3
Санхүүгийн түрээс /лизинг/	10	1.6
Төлбөр төлөгчийн цалин хөлс, түүнтэй адилтгах бусад орлогоос төлбөр гаргуулсан маргаан	2	3
Төрийн албаны тухай хуулиар бусад	2	3
Төрийн болон орон нутгийн өмчийн бусад	1	2
Түрээсийн гэрээ	7	1.1
Тээвэрлэлт	2	3

Маргааны төрөл	Тоо	Хувь
Үндэслэлгүйгээр хөрөнгөжих	8	1.3
Хамтран ажиллах гэрээ	1	2
Хамтын амьдралтай байсныг тогтоолгох	2	3
Хөдөлмөрийн гэрээ	10	1.6
Хөдөлмөрийн хуулиар бусад	13	2.0
Хөлсөөр ажиллах	2	3
Худалдах-худалдан авах болон арилжааны гэрээ-	76	11.9
Хүүхдийн тэтгэлэг гаргуулах	31	4.9
Хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох	4	6
Хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцох	3	5
Цалин хөлсний маргаан	13	2.0
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар бусад	9	1.4
Эд хөрөнгө үнэ төлбөргүй ашиглах	1	2
Эдийн бус гэм хорын арилгах (нэр, төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан/	5	8
Эрх олгосон бичиг баримтыг үрэгдүүлснээс алдагдсан эрхийг сэргээх	1	2
Эцэг тогтоосон	8	1.3
Эцэг эх байх эрх хассан	5	8
Total	637	100.0

Цахим санд байршуулсан 637 шийдвэрийн 194 буюу 30,4 хувь нь зээлийн маргаан, 106 буюу 16,6 хувь нь гэр бүл цуцлалт, хүүхдийн тэтгэлэг гаргуулах тухай маргаан эзэлж байгаа нь хамгийн өндөр дүнтэй байна. Цаашид шүүхийн ачааллыг бууруулахад дээрх хэрэг маргааныг бууруулах талаар урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах нь үр дүнтэй.

Судалгааны явцад “бусад хуулиар” гэх сонголттой 59 шийдвэр цахим санд байршуулсан байх ба тухайн шийдвэрийг судалж үзэхэд зээлийн маргаан, хөдөлмөрийн эрх зүйн харилцаанаас үүдэлтэй маргаан, газрын маргаан зэрэг байсан тул шийдвэр байршуулахдаа маргааны төрлийг оновчтой сонгоогүй нь харагдаж байв. Иймд шийдвэр байршуулах ажилтнууд маргааны төрлийг оновчтой сонгож буй эсэхэд хяналт тавих эрх бүхий албан тушаалтан анхаарах нь зүйтэй.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн

39 дүгээр тогтоол батлагдаж тухайн оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс шинээр батлагдсан журмын дагуу shuukh.mn сайтад шийдвэрийг байршуулж байгаа бөгөөд бидний судалгааны ажил 2022 оныг хамаарч байсан тул “Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах журам батлах тухай” Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн даргын 2017 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн А/44 дүгээр тушаалд заасан журмын дагуу shuukh.mn сайтад шийдвэр байршуулсан эсэхийг мөн судалсан юм.

Өөрөөр хэлбэл 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнөх журмын үйлчлэлд хамаарах 203 шийдвэр, тухайн өдрөөс хойш шинэ журмын үйлчлэлд хамаарах 434 шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулсан байдлыг судаллаа.

3.2 ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ЦАХИМ САНД БАЙРШУУЛАХДАА НУУЦЛАЛЫГ ХАНГАСАН БАЙДАЛ

Монгол Улсад 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль мөрдөгдөж, тус хуулийн 4 дүгээр хэсгийн 1.11 дүгээр хэсэгт зааснаар "хүний хувийн мэдээлэл" гэж хүний эмзэг мэдээлэл болон хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, төрсөн газар, оршин суугаа газрын хаяг, байршил, иргэний бүртгэлийн дугаар, хөрөнгө, боловсрол, гишүүнчлэл, цахим тодорхойлогч, хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох, эсхүл тодорхойлох боломжтой бусад мэдээллийг хамруулахаар зохицуулж, төрийн байгууллага хүнийг тодорхойлох боломжгүй болгож мэдээллийн эзний мэдээллийг нээлттэй өгөгдөл болгохдоо Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан журмыг баримтлахаар заасан. Цахим харилцаа холбоо, мэдээллийн технологийн янз бүрийн шийдлүүд хүмүүсийн харилцаа холбоо, амьдралын өдөр тутмын хэв маягийг илэрхийлэх бүрэн боломжтой болсон тул үүнийг дагаад урьдаас төлөвлөсөн гэмт хэрэг, зөрчил, бусад олон эрсдэлийг дагуулдаг.

Иймд хувь хүн мэдээллээ өөрөө хамгаалахаас гадна мэдээллийг олж авсан аливаа этгээдэд энэ үүрэг давхар ногдох болов. Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулахдаа зөвхөн журмаар зохицуулахаас

гадна Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийг хамгаалах тухай хуулийг давхар мөрдөх нь систем бүрдүүлэгч, түүнд хяналт тавигчдын зайлшгүй мөрдөх үүрэг юм. Цаашид шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулахдаа дээрх хуулиудыг баримтлах, журмыг шинэчлэн батлах хэрэгцээ шаардлага Шүүхийн ерөнхий зөвлөлд ногджээ.

Цахим санд шүүхийн шийдвэрийг байршуулахдаа журамд заасны дагуу хөтөлсөн эсэхийг судлахын тулд үндсэн шалгуур үзүүлэлтийг гарган энэ хүрээнд нийт 637 шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийсэн.


- Аймгийн нэр, огноо, шийдвэрийн дугаар, шүүгчийн нэр
- Маргааны төрөл (маргааны төрлийг кодчилон оруулав)
- Нэхэмжлэгч, хариуцагч, гэрч, бусад оролцогчийн нэр, регистрийн дугаар нууцалсан эсэх
- Хаяг, эд хөрөнгийн бүртгэлийн дугаар, ажил эрхлэлтийг нууцалсан эсэх
- Тодорхойлох боломжтой бусад мэдээлэл нууцалсан эсэх (Машины номер, банкны дансны дугаар гэх мэт)
- Шийдвэрийн төрөл (маргааныг шийдэхдээ бүхэлд нь хангасан, зарим хэсгийг хангасан, хэрэгсэхгүй болгосон гэх мэт)
- Формат алдаатай эсэх (шийдвэрийг уншихад алдаатай, үсгийн фонд танигдахгүй гэх мэт)
- Шийдвэрийг хугацаандаа оруулсан эсэх (шүүхийн шийдвэрт шүүгч гарын үсэг зурж албажуулснаас хойш ажлын 10 хоногийн дотор цахим санд байршуулах журамтай)
- Шийдвэрийн дугаар байршуулсан дугаартай тохирч буй эсэх
- Холбоотой шийдвэр мөн эсэх (цахим санд байршуулсан анхан шатны шийдвэрийн хажууд байршуулсан холбоос давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шийдвэр мөн эсэх)
- Шийдвэрт өөрчлөлт орсон эсэх (анхан шатны шүүхийн шийдвэрт дээд шатны шүүхээс өөрчлөлт оруулсан эсэх)
- Кейс болох шийдвэр мөн эсэх гэсэн бүлэг асуулт боловсруулсан. Мөн шүүхийг сонгохдоо хамгийн олон хэрэг хянан шийдвэрлэсэн, хамгийн олон хүн амтай аймаг гэх шалгуурыг тавьсан болно.

А. Нэхэмжлэгч хариуцагчийн нэрийг нууцалсан байдал

Цахим санд байршуулсан шүүхийн шийдвэрт дурдагдсан нэхэмжлэгчийн нэр нууцлаагүй хувь Архангай аймагт хамгийн өндөр буюу 49,5, хамгийн бага нь Булган аймаг 27,3 хувьтай байна. Зургаан аймгийн цахим санд байршуулсан шүүхийн шийдвэрт нэхэмжлэгчийн нэр нууцлаагүй дундаж хувь 30,1, хариуцагчийн нэр нууцлаагүй дундаж хувь 23,5 байгаа нь өндөр үзүүлэлт юм. Тодруулбал дээрх зургаан аймгийн иргэний хэргийн анхан шатны шүүх 2022 онд нийт 637 шийдвэр цахим санд байршуулсны нэхэмжлэгчийн нэр нууцлаагүй 192 шийдвэр, хариуцагчийн нэр нууцлаагүй 150 шийдвэр байршуулжээ.

Зарим тохиолдолд анхан шатны шүүхийн шийдвэрийн нууцлалыг журмын дагуу хангаж цахим санд оруулсан ч давж заалдах шатны шүүхийн шийдвэрт нууцлалыг хангаагүй тохиолдол цөөнгүй байв. Иймээс давж заалдах болон хяналтын шатны шүүх журмыг сайтар баримтлах нь зүйтэй.

График 2. Хэргийн зохигчдын хувийн мэдээллийг нууцлаагүй тохиолдол (хувиар)




Нэхэмжлэгч, хариуцагчийн нэр нууцлаагүй хувь Архангай аймагт хамгийн өндөр байгаа нь тус аймаг 2022 онд 99 иргэний хэргийн шийдвэр цахим санд байршуулснаас Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн нэхэмжлэлтэй 32 шийдвэр байршуулж, тухайн шийдвэрүүдэд нэхэмжлэгч байгууллагын нэрийг огт нууцлаагүй нь хувийг өсгөж харагдуулж байна.

Б. Шүүхийн шийдвэрт регистрийн дугаар болон гэрийн хаяг нууцалсан байдал

Судалгаанд хамрагдсан зургаан аймгийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн цахим санд байршуулсан 637 шийдвэрээс регистрийн дугаар, хаяг нууцлаагүй байдлыг судалж үзэхэд регистрийн дугаар нууцлаагүй хамгийн өндөр буюу 33,3 хувьтай нь Хөвсгөл, хамгийн бага нь Баянхонгор аймаг нийт оруулсан шийдвэрийнхээ 2,5 хувьд хэргийн оролцогчийн регистрийн дугаар нууцлаагүй байв. Харин хаягийн нууцлалыг хийгээгүй аймгуудаас хамгийн өндөр хувьтай нь мөн л Хөвсгөл аймаг байх бөгөөд шүүхийн шийдвэрийн үндэслэл хэсэгт хаягаа нууцалсан ч тодорхойлох бусад хэсгүүдэд хаягийг нууцлаагүй тохиолдол их байв.


График 3. Регистрийн дугаар нууцлаагүй байдал (хувиар)



В. Шүүхийн шийдвэрт гэрч, болон бусад оролцогчийг нууцалсан байдал

Иргэний хэргийн анхан шатны шүүхээс гарсан шийдвэрийг цахим санд оруулахдаа журамд зааснаар гэрч болон хэргийн бусад оролцогчийн нэрийг мөн нууцлах шаардлагатай бөгөөд судалгаанд хамрагдсан зургаан аймгийн 637 шийдвэрийн 3,6 хувь нь гэрчийн нэр нэр нууцлаагүй, 17,5хувь нь хэргийн бусад оролцогчийн нэрийг нууцлаагүй байв. Нийт шийдвэрийн 87хувь нь гэрчийн нэр, 30,3хувь нь бусад оролцогчийн нэр байхгүй буюу тухайн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрч, бусад оролцогч оролцоогүй байна. Үүнээс үзвэл гэрч болон хэргийн бусад оролцогчийн нэрийг нууцлал хангагдсан байдал харьцангуй өндөр үзүүлэлттэй байгаа нь сайшаалтай.

График 4. Бусад оролцогчдын нэрсийг нууцлаагүй байдал (хувиар)




Г. Шүүхийн шийдвэрт эд хөрөнгийн бүртгэл, ажил эрхлэлтийг нууцалсан байдал

Эд хөрөнгийн бүртгэлийн дугаараар болон ажил эрхлэлтийн тодорхойлолтоор тухайн хэргийн оролцогчийг хэн гэдгийг тодорхойлох бүрэн боломжтой. Ялангуяа эд хөрөнгийн бүртгэлийн дугаараар opendatalab.mn гэх мэт албан ёсны сайтаас хайлт хийхэд эзэмшигчийн мэдээлэл гарч ирдэг. Тийм ч учраас эд хөрөнгийн бүртгэлийн дугаарыг нууцлах ёстойг журамд тусгайлан заасан. Судалгаанд хамрагдсан зургаан аймаг цахим санд шийдвэрээ байршуулахдаа эд хөрөнгийн бүртгэлийн дугаарыг нууцлаагүй 63 шийдвэр оруулсан буюу 9.9 хувь нь нууцлал хангаагүй, эд хөрөнгийн бүртгэлийн дугаар шийдвэрт ороогүй (тухайн хэрэгт бүртгэлийн дугаарын талаар яригдаагүй) буюу огт бичигдээгүй шийдвэр 68,9 хувь байх тул цахим санд байршуулсан шийдвэрийн 50 орчим хувьд нь эд хөрөнгийн бүртгэлийн дугаарыг нууцлаагүй гэж үзэх боломжтой. Иймд хэргийн оролцогчийн зөвхөн хаяг, нэр нууцлаад зогсохгүй эд хөрөнгийн бүртгэлийн дугаарыг маш сайн нууцлах шаардлагатай. Хэргийн оролцогчийн хаяг, нэрийг бүрэн нууцалсан ч эд хөрөнгийн бүртгэлийн дугаар нууцлаагүй бол тухай шийдвэр нууцлалын шаардлага хангасан гэж үзэх боломжгүй.

Хэргийн зохигч, оролцогчийн ажил эрхлэлтийг нууцлаагүй хувийг судалж үзэхэд Хөвсгөл аймгийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн цахим санд байршуулсан шийдвэрийн нууцлал хангаагүй байдал 17,5 хувь, Булган аймгийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн хувьд 11,8 хувь байгаа нь хамгийн өндөр дүн болов. Судалгаанаас үзэхэд төрийн байгууллагын хаягийг нууцлалгүй оруулж байгаа нь түгээмэл байлаа. Жишээ нь: Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 3 дугаар сарын 21-ны өдрийн 428 дугаар шүүхийн шийдвэрт нэхэмжлэгчийн хаягийн нууцлал огт хийгээгүй байв. Энэ мэтчилэн цахим санд хэргийн оролцогчийн ажил эрхлэлтийн нууцлал огт хийгээгүй 62 шийдвэр байршуулжээ. Энэ нь судалгаанд хамрагдсан нийт шийдвэрийн 9,7 хувьд нь хэргийн оролцогчийн ажил эрхлэлтийн байдлыг нууцлаагүй нь харагдаж байна.

Цахим санд шийдвэр байршуулах журамд “хэргийн оролцогчийг тодорхойлох боломжтой бусад мэдээллийг нууцлах” талаар зохицуулсан. Бид тодорхойлох боломжтой бусад мэдээлэлд хэргийн оролцогчийн банкны дансны дугаар, хүүхдийнх нь сурдаг сургууль, хаяг, байршил, маргааны зүйл болсон газрын нэр зэргийг тооцож шалгалаа.

График 5. Эд хөрөнгийн бүртгэлийн дугаар, ажил эрхлэлтийн мэдээллийг нууцлаагүй хувь



Д. Шүүхийн шийдвэрт тодорхойлох боломжтой бусад мэдээллийг нууцалсан байдал

Судалгаанд хамрагдсан 637 шийдвэрээс 205 шийдвэрт хэргийн оролцогчийг тодорхойлох боломжтой бусад мэдээллийг нууцлаагүй нь өндөр үзүүлэлт бөгөөд ихэнх шийдвэрт банкны дансны дугаарыг бүтэн бичсэн, хүүхдийн овог, нэр, сурдаг сургуулийг бүрэн оруулсан, маргааны зүйл болсон газрын байршлыг бүрэн оруулсан зэрэг алдаа дутагдал байв. Судалгааны явцад хэргийн оролцогчийн нэр, хаяг

нууцалсан ч бусад тодорхойлох боломжтой мэдээллийг нууцлахдаа хайнга, болгоомжгүй ханддаг нь анзаарагдсан.

Бусад асуудлаар буюу хэргийн шийдвэрийг байршуулахдаа форматын алдаатай оруулсан эсэх, хугацаандаа оруулсан эсэх, тухайн хэргийн шийдвэрийг зөв оруулсан эсэх, шүүгчийн нэрээр нь нууцлал хангаж байршуулсан эсэхийг тодорхойлох, шийдвэрийн дугаар цахим сайтад байршуулсан дугаар тохирч буй эсэх, тухайн хэргийн магадлал, тогтоол мөн эсэх, дээд шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан эсэх, анхаарал татсан кейс болох шийдвэр зэргийг судалсан билээ.

Шүүхийн шийдвэрийн цахим сангаас түүвэрлэн авсан 637 шийдвэрээс формат алдаатай буюу мөр хоорондын зай аваагүй, уншихад ойлгомжгүй 142/ШШ2022/00565, 142/ШШ2022/00221, 142/ШШ2022/00225 дугаартай 3-н шийдвэр, 142/ШШ2022/00169 дугаар шийдвэрийн ихэнх хэсэг нь унших боломжгүй.

Мөн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн давж, заалдах болон хяналтын шатны шүүхээр хэлэлцсэн шийдвэрийн холбоос зөв байршсан эсэхийг судалж үзэхэд алдаа гараагүй нь сайн тал байлаа.

Цахим санд байршуулахдаа анхаарал татахуйц, кейс болох шийдвэрийг тэмдэглэсэн бөгөөд дараах зөрчлүүд илэрч байв. Үүнд:

- 155/ШШ2022/00125 дугаартай Хөвсгөл аймгийн ИХАШШ-ийн шийдвэрийг цахим санд байршуулахдаа анхан шатны шүүхээс мэдээллийн нууцлалыг хангасан боловч Давж заалдах шатны шүүхийн шийдвэрт тодорхойлох боломжтой мэдээллийг нууцлаагүй, маргааны төрлийг буруу сонгосон. Ер нь анхан шатны шүүхийн шийдвэрт хэргийн оролцогчийн нэрийг нууцалсан боловч давж заалдах шатны шүүхийн шийдвэрт хэргийн оролцогчдын мэдээллийг нууцлаагүй тохиолдол хэд хэдэн удаа тохиолдсон.
- Маргааны төрлийг буруу сонгосон шийдвэр цөөнгүй байсан нь цахим санд мэдээлэл оруулагчийн хайхрамжгүй байдалтай холбоотой байж болох ч нөгөө талаар цахим санд мэдээлэл оруулагчтай ярилцлага хийх явцад “маргааны төрөл”-нь цөөн байдгаас “бусад” гэх сонголтыг сонгож, шийдвэр байршуулахаас аргагүйд хүрдэг гэж мэдээлсэн


юм. Харин хөдөлмөрийн эрх зүйн маргааны хувьд “Ажлаас буруу шилжүүлсэн”, “Ажлаас үндэслэлгүй халагдсан”, “Цалин хөлсний маргаан”, “Хөдөлмөрийн хуулиар бусад”, “Хөдөлмөрийн гэрээ” гэсэн сонголтууд байх ба маргааны төрлийг нарийвчлан тодорхойлох боломжтой байхад “Хөдөлмөрийн хуулиар бусад” сонголтыг илүү сонгосон байсан.

- Цахим санд байршуулахдаа нэг шийдвэрийг 2 өөр дугаараар байршуулсан буюу 155/ШШ2022/00840, 155/ШШ2022/00870 гэж мэдээлэл оруулсан байв.
- 155/ШШ2022/00631 шийдвэрийн Давж заалдах шатны шүүхийн шийдвэр уншигдах боломжгүй байв.
- Хөвсгөл аймгийн ИХАШШ-ийн 155/ШШ2022/00352 дугаартай шийдвэрийг цахим санд 12 удаа давхцуулж оруулсан. (142/ШЗ2022/00394, 142/шш2022/01149, 142/ШЗ2022/00144, 142/ШЗ2022/00069 гэх мэт шийдвэрийг цахим санд 2 удаа оруулсан)
- Цахим сайтад тухайн онд хэдэн шийдвэр оруулах ёстойг судлаачид, иргэд харах боломжгүй, программ хариуцсан мэргэжилтэн гараар тоолж оруулдаг тул яг оруулах ёстой хэдэн шийдвэрээс хэдийг нь оруулсныг бид дүгнэх боломжгүй байв.
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн даргын 2017.09.07-ны өдрийн А/44 дүгээр тушаалаар батлагдсан "Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах журам"-ын 3.7, 3.9-д зааснаар хуульд тусгайлан заасан хэрэг маргааныг шүүх хуралдаанаар хаалттай хянан шийдвэрлэсэн эсхүл насанд хүрээгүй хүүхдийн эрх ашгийг хамгаалах, гэр бүлийн маргаан буюу асран хамгаалагч тогтоохтой холбоотой шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр оруулахгүй, зөвхөн тогтоох хэсгийг 3.6-д заасны дагуу товчилж байршуулна гэж заасан. Харин Орхон аймгийн сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 4 дүгээр сарын 1 хүртэлх шийдвэрийг харахад гэр бүлийн маргаан, асран хамгаалагч тогтоох, хүүхдийн тэтгэлэг гаргуулах тухай маргааныг бүрэн эхээр оруулсан байна.
- Нууцлалыг шүүх бүр ялгаатай байдлаар хийж оруулсан байна. Жишээ нь Баянхонгор аймгийн шүүхийн бүх шийдвэрт нууцлах

шаардлагатай мэдээллийг *** тэмдэглэгээ ашиглан оруулсан бол бусад аймгийн шүүхүүд зарим нь *** тэмдэглэгээ ашиглаж, зарим нь хүний нэрийг овог нэрийн эхний үсгээр тэмдэглэсэн (Л.Х нь, А нь гэх мэт), зарим шийдвэрт нууцлах шаардлагатай хэсгийг бүрэн арилгасан (үл хөдлөх эд хөрөнгийн тоот гэрчилгээ, хаан банкны тоот дансны хуулга гэх мэт)

- 131/ШШ2022/00646, 131/ШШ2022/00647, 131/ШШ2022/00648 зэрэг хэд хэдэн шүүхийн шийдвэрүүдэд нууцлах шаардлагагүй хэсгүүд буюу он сар өдөр, мөнгөн дүн, хуулийн зүйл заалт, шүүхийн шийдвэрийн дугаар зэрэг тоон мэдээлэл *** тэмдэглэгээ ашиглаж нууцлал хийсэн нь оновчгүй, уншиж ойлгоход түвэгтэй нөхцөл байдлыг үүсгэж байв.

График 6. Тодорхойлох боломжтой бусад мэдээллийг нууцлаагүй хувь



Хүснэгт 5. ИХАШШ-ийн шийдвэрийг нууцлаагүй тоо, хувь (нэгтгэл хүснэгт)

№	Нууцлах ёстой мэдээлэл	Хөвсгөл аймгийн ИХАШШ		Булган аймгийн ИХАШШ		Орхон аймгийн ИХАШШ		Архангай аймгийн ИХАШШ		Өвөрхангай аймгийн ИХАШШ		Баянхонгор аймгийн ИХАШШ	
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
1	Нэхэмжлэгчийн нэр	20	31,7	14	20,6	81	27,3	49	49,5	11	35,5	17	21,5
2	Хариуцагчийн нэр	20	31,7	11	16,2	71	23,9	25	25,3	8	25,3	15	19,0
3	Регистрийн дугаар	21	33,3	6	8,8	43	14,5	7	7,1	6	19,4	2	2,5
4	Бусад оролцогчдын нэр	31	49,2	9	13,2	42	14,1	7	7,1	7	22,6	14	17,7
5	Гэрчийн нэр	7	11,1	5	7,4	6	2,0	3	3,0	0	0,0	2	2,5
6	Хаяг	41	65,1	9	13,2	36	12,1	22	22,2	6	19,4	9	11,4
7	Эд хөрөнгийн бүртгэлийн дугаар	4	6,3	6	8,8	40	13,5	3	3,0	5	16,1	5	6,3
8	Ажил эрхлэлт	11	17,5	8	11,8	22	7,4	9	9,1	3	9,7	9	11,4
9	Тодорхойлох боломтой бусад мэдээлэл	36	57,1	11	16,2	97	32,7	36	36,4	13	41,9	12	15,2


*Бусад оролцогчид, гэрч, эд хөрөнгийн бүртгэлийн дугаар, ажил эрхлэлийн мэдээлэл нь огт бичигдээгүй шүүхийн шийдвэрүүд байсан тул “нууцалсан” “нууцлаагүй” “байхгүй” гэсэн асуулаар бид судалгаа хийсэн бөгөөд дээрх хүснэгтэд зөвхөн нууцлах ёстой мэдээллийг нууцлаагүй тоо, хувийг оруулсан болно.

3.3. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ЦАХИМ САН ХӨТЛӨГЧДИЙН СУДАЛГАА

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 39 дүгээр тогтоолоор баталсан “Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах журам”-аар шүүхийн шийдвэрийг цахим санд оруулах үүрэгтэй албан хаагч нь “системийн бүрдүүлэгч” буюу шүүгчийн туслах бөгөөд түүний үйл ажиллагаанд тухайн шүүхийн Тамгын газрын мэдээлэл, технологийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа албан хаагч мэргэжилтэн, Тамгын газрын дарга хяналт тавих талаар зохицуулсан.


Бид түүвэрт хамрагдсан аймгуудын shuukh.mn сайтын систем бүрдүүлэгч буюу 16 шүүгчийн туслахтай уулзаж, шийдвэр байршуулахад гардаг хүндрэл бэрхшээл, ололт амжилтыг судлахаар ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийж, дүн шинжилгээ хийлээ.

График 7. Ярилцлагад оролцсон шүүгчийн туслахын ажилласан жил



Судалгаанд хамрагдсан шүүгчийн туслахуудын 56хувь нь 6-10 жил шүүхийн байгууллагад ажиллаж байгаа, бүгд сүүлийн 2 жил гаруй хугацаанд сайтад шийдвэр байршуулах ажлыг хариуцаж байгаа албан хаагчид байв.

График 8. Шүүхийн нэг шийдвэр системд байршуулахад зарцуулж буй хугацаа



Судалгаанд хамрагдсан албан хаагчдын 56хувь нь нэг шийдвэр байршуулахад дунджаар 10-20 минут зарцуулдаг гэжээ. Түүнчлэн зарим анхаарал татахуйц кейсийг жишээ болгон орууллаа.

Кейс №1

“...Shuikh.mn сайтад шийдвэр байршуулаад 2 жил гаруй болж байна, энэ хугацаанд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс чиглүүлэх сургалт зохион байгуулаагүй. Ажлын ачаалал их болохоор илүү цагаар сууж шийдвэрээ нийтэлдэг. Нууцлах ёстой мэдээллийг нэг бүрчлэн уншиж, хориглох үгсийг түүндэг учраас цаг их ордог, алдаа гаргах магадлал их, ийм учраас программыг хялбаршуулмаар байна...”

Кейс №2

“...6-7 хуудас шийдвэр оруулахад сайт гацахгүй бол 10-15 минут зарцуулна. Шийдвэрийн хэмжээнээс шалтгаалж 1 шийдвэр дээр 3 цаг сууж, сайтад оруулж байсан. Заримдаа шийдвэрээ нууцлах хэсгийг нууцлаад программд оруулсан байхад хадгалаагүй тохиолдол гардаг...”

Кейс №3

“...Ажлын ачааллаас шалтгаалаад шийдвэрээ цаг тухайд нь оруулж амжихгүй тохиолдол байдаг. Би жишээ нь 2022 онд оруулаагүй хэдэн шийдвэрийг сая нөхөж оруулсан. Хориглох үгсийг гар ажиллагаа хийж оруулдаг нь хүндрэлтэй. Жишээ нь “Бат” гэж нэрийг нууцлаад бичингүцт “Батын” гэдэг нь нууцлагдахгүй, тиймээс нэг бүрчлэн нууцлах шаардлагатай. Сайтад шийдвэр оруулаад хадгалчхаад байхад ордоггүй тохиолдол бий. Бид өөрсдийн эрхээр ороод хийчихээд байдаг, хардаг сайт дээрээ харагдахгүй тохиолдол байна...”

Кейс №4

“...Гүйцэтгэлийн төлөвлөгөө дээр сайтад шийдвэр байршуулах талаар байгаа, ажлын байрны тодорхойлолтод байхгүй, өмнө нь мэдээлэл технологийн мэргэжилтэн энэ ажлыг хариуцдаг байсан. Цалин урамшуулал байхгүй. Ижил төстэй маргааныг шүүх ийм байдлаар шийддэг юм байна гэж судалгаа шинжилгээний байдлаар ашиглахад хэрэгтэй байх, түүнээс энгийн иргэд бол ийм сайт байдгийг ч мэдэхгүй. Ороогүй шийдвэрээ дараа нь нөхөөд оруулдаг. Саяхан гэхэд л 7 сарын 2 шийдвэрээ би нөхөж оруулсан...”

Кейс №5

“...Олон оролцогч нартай хэргийн хувьд бүх хүмүүсийн мэдээллийг нууцална гэдэг бэрхшээлтэй. Бүх байгууллага, бүх оролцогчийн нэрийг гараар дарж хийдэг. Арай хялбар байдлаар шийдвэр оруулах тал дээр ажилламаар санагддаг. Эсвэл зөвхөн жишиг болохуйц шийдвэрүүдэд оруулах нь зөв байх...”

Кейс №6

“...Сайтад хуулийн сонголт, маргааны төрлөө нарийвчилж оруулах, ямар маргаан шийдсэн тэрийг нь бичиж оруулдаг талбартай байвал зүгээр санагддаг. Гараараа нууцлалын тохиргоо хийж, нэг бүрчлэн шийдвэрээ шүцж уншдаг нь хүндрэлтэй ...”

Кейс №7

“... Хүн бүр shuikh.mn-д сайтад ороод байдаггүй. Судалгаа хийж байгаа хүмүүс, хууль хяналтын байгууллагынхан л орж хардаг байх. Мэдээлэл технологийн ажилтанд энэ ажлыг хариуцуулаад жишиг болох шийдвэрүүдээ л оруулах нь зөв санагддаг...”

Судалгаанд хамрагдсан албан хаагчид бүгд “шүүхийн шийдвэрийг сайтад байршуулах нь зөв, тэгж байж шүүхэд итгэх иргэдийн итгэл нэмэгдэх бөгөөд иргэд ч мэдэх эрхтэй” гэж хариулсан байна.

Ганцаарчилсан ярилцлагаас ажиглахад шүүгчийн туслахуудын ажлын ачаалал их, сайтыг ашиглахад хүндрэлтэй байдаг нь харагдаж байв.

ДУГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Хангайн бүсийн аймгуудын шүүхийн шийдвэрийн ил тод байдалд мониторинг хийх нь” судалгааны үр дүнд тулгуурлан бид дараах дүгнэлтийг хийлээ.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2022 онд баталсан “Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах журам” нь Монгол улсын үндсэн хууль, шүүхийн тухай хуулийн үзэл баримтал, шүүхийн ил тод байдлыг хангах зорилгод нийцэж буй бөгөөд цахим санд шүүхийн шийдвэрийг байршуулах, хяналт тавих гэсэн хоёр гол зохицуулалтыг агуулжээ. Тус журам нь шүүхийн захиргааны ажилтнуудад зориулсан дотогшоо чиглэсэн хэм хэмжээ мэт боловч түүгээр дамжуулан шүүхийн ил тод байдал, хувь хүний нууц, халдашгүй байдал, хүүхдийн эрх ашгийг хамгаалах зэрэг нийтийн эрх зүйн хүрээний зохицуулалтыг агуулсан байна.

Журамд хувь хүний нууц, халдашгүй байдлыг хамгаалах маш нарийн зохицуулалт байгааг 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгээс харж болно. Жишээ нь 4.2.3. гэр бүлийн маргаан, асран хамгаалагч тогтоох, хүүхэд үрчлэн авах, насанд хүрээгүй хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн бусад хэрэгтэй холбоотой шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулахгүй бөгөөд 5.2.1-д зааснаар шүүхийн шийдвэрт дурдсан хүн, хуулийн этгээдийн нэр, регистрийн болон улсын бүртгэлийн дугаар, оршин суугаа болон үйл ажиллагаа явуулж байгаа газрын хаяг, эд хөрөнгийн бүртгэлийн дугаар зэрэг мэдээллийг тодорхойлох боломжгүй болгон нууцлах ёстой байна.

Журмаас үзвэл шүүхийн шийдвэрийг цахим санд оруулах үүрэгтэй албан хаагч нь “системийн бүрдүүлэгч” буюу шүүгчийн туслах бөгөөд түүний үйл ажиллагаанд тухайн шүүхийн Тамгын газрын мэдээлэл, технологийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа албан хаагч мэргэжилтэн, Тамгын газрын дарга хяналт тавих талаар зохицуулжээ.

Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах ёстой шүүгчийн туслахын албан тушаалын тодорхойлолт, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд shuukh.mn сайтад мэдээлэл оруулах талаар тухайлсан зохицуулалтыг

оруулж, нэг мөр болгох, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2020 оны 4 дүгээр сард баталсан шүүгчийн туслахын албан тушаалын тодорхойлолтод shuukh.mn сайтад шүүхийн шийдвэр оруулах зохицуулалт байхгүй байх тул даруй шийдвэрлэх шаардлагатай.

Судалгааны ажил эхлэх үе буюу 2023 оны 4 дүгээр сард түүвэрт сонгогдсон аймгуудын цахим санд байршуулсан шийдвэрийн нийт тоо 603 байсан бол судалгааны ажлын явцад 637 болж нэмэгдэж байсан. Энэ нь журамд зааснаар “шүүхийн шийдвэрийг шүүгч гарын үсэг зурж албажуулснаас хойш ажлын арван өдрийн дотор цахим хуудаст байршуулах” зохицуулалт үйлчлэхгүй байх бөгөөд шүүгчийн туслахуудтай уулзалт хийх явцад шийдвэрээ дараа нөхөж оруулдаг талаар ярьсан юм. Цаашид хугацааны зохицуулалтыг журмаас хасах, эсвэл сайтад шийдвэр оруулах хугацааны тохируулга нэмэх хэрэгтэй.

2011 оноос хойш шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулж, олон нийтэд нээлттэй мэдээлэлдэг болсноос хойш одоогийн байдлаар 162,000 орчим шийдвэр нийтлэгдэж судалгаа шинжилгээний зорилгоор ашиглах бүрэн хэмжээний дата базз бүрэлдэж, шүүхийн шийдвэр нээлттэй ил тод байх, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг бэхжүүлэх гэх мэт олон ач холбогдлыг бий болгосоор байна. Хэдий шүүхийн шийдвэр ил тод байх зорилгодоо хүрч байгаа ч цахим санд шийдвэр байршуулахад техникийн, журмын алдаа гаргаж байгаа нь ач холбогдлыг багасгах, шүүхийн үйл ажиллагааны ачааллыг нэмэх, хэрэгтэй шаардлагатай хэргээ хайж олох зэрэгт хүндрэл гарсаар байгаа. Шүүхийн шийдвэрийг хэдий хугацаанд цахим санд байршуулах талаар зохицуулалт байхгүй, цаашид ч шүүхээр маргаанаа шийдвэрлүүлсэн иргэдийн мэдээлэл нээлттэй байх тул дахин нууцлалыг хангуулж байршуулах хэрэгтэй.

Жишээ нь: Өвөрхангай аймаг дахь сум дундын ИХАШШ-ийн 2017 оны 09 сарын 21 өдрийн 145/2017/00114/И индекстэй хэрэгт “...2009 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр төрсөн хүү Сарантуяагийн Билгүцүний төрсөн эцэг нь хариуцагч Баатар овгийн Нэргүйн Балжиннямьн мөн болохыг тогтоосугай.” гэж ил тод харагдсаар байна. Хэдий “Цахим санд шийдвэр байршуулах журам” боловсронгуй болж, өмнөх шийдвэрүүдийн мэдээлэл энэ мэт харагдсаар байгаа нь илэрхий алдаа

бөгөөд өмнөхөө засаж өөрчлөөгүй байж, шинээр хэдий сайхан журам баталж мөрдөөд ч ач холбогдолгүй.

Журмын хэрэгжилтийг хангах, цахим санд шийдвэр байршуулахын ач холбогдлыг нэмэхийн тулд хариуцлагын зохицуулалтыг шинээр оруулах шаардлагатай. Одоогийн мөрдөгдөж байгаа Цахим санд шийдвэр байршуулах журмын 10.1-д хариуцлагын заалтыг ерөнхий байдлаар оруулсан байна.

Цахим сайтад яг нэг төрлийн маргааныг бүгдийг байршуулж байгаа нь шүүхийн зохиомол ачааллыг нэмэгдүүлэх, хэргийн оролцогчийн нууцлалыг алдагдуулах эрсдэл гарч байгаа тул ижил төрлийн маргааныг зохицуулсан шүүхийн шийдвэрээс зөвхөн жишиг болохуйц нэг шийдвэрийг байршуулах нь зүйтэй байна. *(Жишээ нь: Архангай аймгийн ИХАШШ-ээс Хөдөө аж ахуйг дэмжих сангийн ажлын албаны нэхэмжлэлтэй 32 маргааныг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 115 дугаар зүйлийн 115.2.3-д зааснаар шийдвэрлэсэн бөгөөд бүх шийдвэрээ цахим санд нийтэлжээ.)*

Хэргийн оролцогчийн биеийн байцаалтад дурдсан овог, нэр, ам бүл, хөдөлмөр эрхлэлтийн байдал, нас, хүйс, гэр бүлийн байдал зэргийг хэрхэн нууцлах талаар нэгдсэн загвар гаргаж, бүх шүүхэд нэг стандартаар мөрдүүлж хэвшүүлэх журам гаргах шаардлагатай байх бөгөөд шүүхийн шийдвэрт хэргийн оролцогчийн мэдээллийн нууцлалыг хангасан нь шийдвэрт дурдагдсан гэр бүлийн гишүүдийн мэдээллийг нууцлаагүй тохиолдол их байв.

Цахим сайтад шийдвэр байршуулдаг албан хаагчдыг дараах нөхцөл боломжоор хангах нь зүйтэй.

1. Сургалт зохион байгуулах, нэмэлт урамшуулал олгох, ажлын ачааллыг хөнгөвчлөх, ажлын байрны тодорхойлолтод сайт хариуцах ажлыг тусгах, эсхүл сайтад мэдээлэл байршуулах тусгайлсан орон тоо бий болгох,
2. Систем бүрдүүлж буй албан хаагч үг, үсэг, дүрмийн алдаагүй байх шаардлага, мэдээлэл оруулахад тавигдах хэлбэрийн шаардлага болон агуулгын алдаа гаргах, нууцлалын талаар тавигдах шаардлагыг зөрчихөөс сэргийлсэн санамж, зааварчилгаа гаргаж өгөх,

Цахим систем хөгжүүлэгч программ хангамжийг дараах байдлаар сайжруулах шаардлагатай.

1. Цахим санд маргааны төрлийг нэмэх, олон сонголттой болгох,
2. Сайт гацдаг, шийдвэр байршуулахад хадгалаагүй байдаг хэд хэдэн тохиолдлыг систем бүрдүүлэгчид хэлсэн тул сайтыг шинэчлэх,
3. Нууцлах шаардлагатай мэдээллийг ямар форматаар тэмдэглэх талаар нэгдсэн тэмдэглэгээ бий болгох,
4. Нэг шийдвэрийг олон удаа байршуулах боломжгүй тохиргоо хийх,

Одоо мөрдөн буй журмыг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.8 дахь хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.1.5 дахь заалт, 75 дугаар зүйлийн 75.2.2 дахь заалтыг үндэслэн баталсан бөгөөд хүчин төгөлдөр үйлчилж буй хувь хүний мэдээллийн нууцлалыг хамгаалах арга, хэлбэрийг цогцоор зохицуулсан нарийвчилсан хуулийн зохицуулалтыг үндэслэн батлаагүй нь учир дутагдалтай тул Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцүүлэн шинэчлэн батлах шаардлагатай.

ДӨРӨВ. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ИЛ ТОД БОЛГОЖ БҮЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Төсөл хэрэгжүүлэгч: *Иргэний нийгмийн байгууллагуудын Хамтын хүч түншлэл*

Хамрах хүрээ: *Орхон, Өвөрхангай, Дундговь, Хөвсгөл аймаг дахь Сум дундын эрцүгийн хэргийн анхан шатны шүүх, Эрцүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг шийдвэрлэсэн шийдвэр*

ИНБ-уудын “Хамтын Хүч Түншлэл” ТББ нь жендерт суурилсан хүчирхийлэл, тэр дундаа Гэр бүлийн хүчирхийлэл (ГБХ)-ийн чиглэлээр соён гэгээрүүлэх, сургалт судалгаа, мониторинг хийдэг мэргэжлийн туршлагатай хот, орон нутгийн 60 төрийн бус байгууллагуудыг эгнээндээ нэгтгэсэн дээвэр байгууллага юм.

Энэхүү мониторингийн төсөлд Төр иргэн түншлэл, Өвөрхангай аймгийн Хархорин сумын Орхон сургуулийн эцэг эх, багшийн холбоо, Төгс зохицол-Гэр бүл, Дундговь Хөгжил 21-р зуунд ТББ-ын төлөөллөөс бүрдсэн баг ажиллаж Орхон, Өвөрхангай, Хөвсгөл, Дундговь аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс шүүхийн шийдвэрийн цахим санд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэргийн шүүхийн шийдвэрийг хэрхэн нийтэлж байгаад мониторинг хийлээ.

Мониторингийн мэдээлэл цуглуулах шатанд шүүхийн шийдвэрийн тоон мэдээлэл цуглуулахын зэрэгцээ шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулдаг шүүгчийн туслахуудтай ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлага хийж чанарын мэдээлэл цуглуулсан болно.

Тоон судалгааг урьдчилж бэлтгэсэн мониторингийн шалгах хуудас, хүснэгтийн хүрээнд авсан ба гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой эрүүгийн хуулийн 17 зүйл заалтын хүрээнд 4 аймгийн Шүүхийн Тамгын Газраас мэдээлэл хүсэж, уг заалтын хүрээнд цахим сангаас аймаг тус бүрээр шүүлт хийх замаар гүйцэтгэсэн.

Хүснэгт 6. Шүүхийн шийдвэрийн цахим санд сонгосон хугацаанд (2021-2022) нийтлэгдсэн шийдвэрийн тоо

№	Эрүүгийн хуулийн зүйл, заалт	Дундговь		Орхон		Өвөрхангай		Хөвсгөл	
		АШШ	ДЗШ	АШШ	ДЗШ	АШШ	ДЗШ	АШШ	ДЗШ
1	10.1-р зүйл: Хүнийг алах	5	7					7	3
2	10.1-р зүйлийн 2.8: Хүнийг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж алах								
3	10.4-р зүйл: Хүнийг амиа хорлоход хүргэх								
4	11.1-р зүйл: Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах	7	1	11	6	1	1	27	4
5	11.1-р зүйлийн 2.1: гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах			4	2				
6	11.4-р зүйл: Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах	9	2	25	3			26	3
7	11.4-р зүйлийн 2.1: гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах			7	4			4	
8	11.6-р зүйлийн 1: Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах 11.6-р зүйлийн 2: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах	98	12	322	33	88	9	284	15
9	11.7-р зүйлийн 1.1: Гэр бүлийн хамааралтай хүнийг байнга зодох	1	1	1	1	1		2	
10	11.7-р зүйлийн 1.2: Гэр бүлийн хамааралтай хүнийг байнга харгис хэрцгий харьцах, догшин авирлах, тарчлаах			1					

№	Эрүүгийн хуулийн зүйл, заалт	Дундговь		Орхон		Өвөрхангай		Хөвсгөл	
		АПШ	ДЗШ	АПШ	ДЗШ	АПШ	ДЗШ	АПШ	ДЗШ
11	11.7-р зүйлийн 1.3: Гэр бүлийн хамааралтай хүний хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах					2	2		
12	11.7-р зүйлийн 2.1: Гэр бүлийн хүчирхийллийг хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн;					1	1		
13	11.7-р зүйлийн 2.2: Гэр бүлийн хүчирхийллийг асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтан үйлдсэн					2	2		
14	11.7-р зүйлийн 2.3: Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох гэсэн хүнийг эсэргүүцэж үйлдсэн								
15	12.1-р зүйл: Хүчиндэх		5	6	4	2	2	18	5
16	12.1-р зүйлийн 2.3: Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндэх						1	2	
17	12.2-р зүйл: Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах								
	Нийт	120	28	347	52	97	19	370	30

Чанарын судалгааг судлаачид Шүүхийн Тамгын Газарт очиж шүүгчдийн туслахуудын дунд фокус бүлгийн ярилцлага хийж, түүнийгээ баталгаажуулах үүднээс гүүгл формоор асуумж бөглүүлж авсан. Чанарын судалгааны зорилго нь тоон судалгааг хийх явцад анзаарсан алдаа дутагдлыг баталгаажуулах, шалтгаан нөхцөлийг олж тогтооход оршиж байв.

Мониторингийн багт ИНБ-уудын “Хамтын хүч түншлэл”-ийн 4 аймгийн төлөөлөл болох Б.Аюуш (Орхон аймаг), В.Отгонжаргал (Дундговь), Б.Үржинсүрэн (Өвөрхангай), О.Ууганцэцэг (Хөвсгөл аймаг) болон төслийн зөвлөх, хуульч А.Гүндэгмаа Улаанбаатар хотоос ажиллалаа.

4.1. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

Орхон, Дундговь, Өвөрхангай, Хөвсгөл аймгийн сум дундын эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн www.shuukh.mn цахим санд 2021¹⁹ - 2022²⁰ онд байршуулсан шүүхийн шийдвэр, магадлал, шийтгэх, цагаатгах тогтоолоос түүвэрлэн авч үзлээ. 2021 онд 4 аймгийн анхан шатны шүүхийн тамгын газраас эрүүгийн хуулийн 17-н зүйл заалтын хүрээнд ирүүлсэн тоо нь 562 байсан бол цахим санд Хамтын хүч түншлэлийн судлаачдын багийн шүүлт 377 хэрэг буюу 67хувь нь цахим санд байршсан байна. Энэ хувь нь аймаг тус бүрээр ялгаатай байгаа ба бид шүүхийн тамгын газраас ирүүлсэн дүнг суурь үзүүлэлт болгож судалгаанд ашигласан юм. 2022 онд 4 аймгийн анхан шатны шүүхээс 17 зүйл заалтын хүрээнд ирүүлсэн тоо нь 500 байсан бол цахим санд мониторинг хийсэн багаас ирүүлсэн судалгаанд уг үзүүлэлтийн нийт дүн +111.8хувь буюу 559 хэрэг цахим санд байршсан байна. Орхон аймгийн хувьд шүүхийн тамгын газраас ирүүлсэн тоо нь 36 байсан бол цахим санд байршуулсан хэрэг нь 215 байсныг дурдах нь зүйтэй.

2021 онд 4 аймгийн давж заалдах шатны шүүх дээр 17 зүйл заалтын хүрээнд шүүхийн тамгын газраас албан тоотоор ирүүлсэн тоо нь 79 байсан бол цахим санд судлаачдын багаас хийсэн шүүлт 86хувь буюу 68 хэрэг цахим санд байршсан байна. Энэ хувь нь аймаг тус бүрээр ялгаатай байгаа ба бид шүүхийн тамгын газраас ирүүлсэн дүнг суурь үзүүлэлт болгон авсан. Харин 2022 онд 4 аймгийн давж заалдах шатны шүүх дээр 17 зүйл заалтын хүрээнд Шүүхийн Тамгын газраас албан тоотоор ирүүлсэн тоо нь 75 байсан бол цахим 61 хэрэг цахим санд байршсан нь 81 хувь болж байна. Энэ хувь нь аймаг тус бүрээр ялгаатай байгаа ба бид Шүүхийн Тамгын газраас ирүүлсэн дүнг суурь үзүүлэлт болголоо.

Тоон мэдээллийг аймаг тус бүрээр нарийвчлан авч үзсэнийг доорх задаргаанаас харна уу.

¹⁹ 2020.12.21-2021.12.20

²⁰ 2021.12.21-2022.12.20

Орхон аймаг

Орхон аймгийн сум дундын эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхээс гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой эрүүгийн хуулийн 17-н зүйл заалтаар ирүүлсэн тоо баримтыг суурь тоогоор авч үзэн харьцуулж үзэхэд Орхон аймгийн хувьд 2021онд 196 хэрэг гарснаас 67 хувь буюу 132-н шүүхийн шийдвэр цахим санд байршсан бол 2022 онд шүүхээс 36 хэрэг ирсэн бол цахим санд 215 хэрэг байршсан байсан.

Хүснэгт 7. Орхон аймаг, шүүхийн шийдвэрийн задаргаа

№	Зүйлчлэл шүүх Он	ШТГ-аас		Цахим санд байршсан		ШТГ-аас		Цахим санд байршсан		Зөрүү			
		АППШ				ДЗППШ				АППШ		ДЗППШ	
		2021	2022	2021	2022	2021	2022	2021	2022	2021	2022	2021	2022
1	10.1	3	1			1	1			3	1	1	1
2	10.1-2.8												
3	10.4												
4	11.1	6	3	4	7	4	2	4	2	2	4		
5	11.1-2.1	3	1	1	3	3	1		2	2	2	3	1
6	11.4	21	4	7	18	2	1	3		14	14	1	1
7	11.4-2.1			3	4			1	3	3	4	1	3
8	11.6-1, 11.6-2	148	17	114	178	20	12	15	18	34	161	5	6
9	11.7-1.1				1						1		
10	11.7-1.2	6	2		1	1	2			6	1	1	2
11	11.7-1.3												
12	11.7-2.1												
13	11.7-2.2												
14	11.7-2.3												
15	12.1	9	8	3	3	8	8	3	1	6	5	5	7
16	12.1-2.3												
17	12.2												
Нийт		196	36	132	215	39	27	26	26	70	193	17	21

Дундговь аймаг

Дундговь аймгийн сум дундын эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхээс гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой эрүүгийн хуулийн 17-н зүйл заалтаар ирүүлсэн тоо баримтыг суурь тоогоор авч өөрсдийн цахим сангийн судалгаатай харьцуулж үзэхэд 2021 онд нийт 17-н зүйл заалтын хүрээнд 80 хэрэг гарснаас 73 хувь буюу 59 шүүхийн шийдвэр цахим санд байршсан бол 2022 онд уг үзүүлэлтээр нийт 82 шүүхийн хэрэг шийдвэрлэгдсэн бол цахим санд түүний 76 хувь буюу 63 шүүхийн шийдвэр байршсан байна.

Хүснэгт 8. Дундговь аймаг, шүүхийн шийдвэрийн задаргаа

№	Зүйлчлэл	ШТГ-аас		Цахим санд байршсан		ШТГ-аас		Цахим санд байршсан		Зөрүү			
		Шүүх		АШШ		ДЗШШ				АШШ		ДЗШШ	
		Он	2021	2022	2021	2022	2021	2022	2021	2022	2021	2022	2021
1	10.1	1	5	1	4	1	8	0	7		1	1	1
2	10.1-2.8												
3	10.4												
4	11.1	1	6	0	7		1		1	1	1		
5	11.1-2.1												
6	11.4	6	3	5	4		0		2	1	1		2
7	11.4-2.1												
8	11.6-1, 11.6-2	48 22	48 19	43 9	38 8	5	6	6	6	5 13	10 11	1	
9	11.7-1.1	1		1		1		1					
10	11.7-1.2												
11	11.7-1.3												
12	11.7-2.1					1		1					
13	11.7-2.2												
14	11.7-2.3												
15	12.1	1	1	0		1	2	2	3	1	1	1	1
16	12.1-2.3												
17	12.2												
Нийт		80	82	59	61	9	17	9	19	21	25	3	4

Өвөрхангай аймаг

Өвөрхангай аймгийн сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой эрүүгийн хуулийн 17-н зүйл заалтаар ирүүлсэн тоо баримтыг суурь тоогоор авч өөрсдийн цахим сангийн судалгаатай харьцуулж үзвэл 2021 онд нийт 117 хэрэг гарснаас 23 хувь буюу 27 шүүхийн шийдвэр цахим санд байршжээ. 2022 онд уг үзүүлэлтээр нийт 149 шүүхийн хэрэг шийдвэрлэгдсэн бол цахим санд түүний 46 хувь буюу 70 шүүхийн шийдвэр байршсан байна.

Хүснэгт 9. Өвөрхангай аймаг, шүүхийн шийдвэрийн задаргаа

№	Зүйлчлэл	ШТГ-аас		Цахим санд байршсан		ШТГ-аас		Цахим санд байршсан		Зөрүү				
		ЭХАШШ		ЭХДЗШШ		ЭХАШШ		ЭХДЗШШ		ЭХАШШ		ЭХДЗШШ		
	Шүүх	Он	2021	2022	2021	2022	2021	2022	2021	2022	2021	2022	2021	2022
1	10.1		3				3	1					3	1
2	10.1-2.8							2						2
3	10.4							1						1
4	11.1		9	1	1		1		1		8			
5	11.1-2.1		1	1			5	4			1	1	5	4
6	11.4		7	11			1	3			7	11	1	3
7	11.4-2.1							2						2
8	11.6-1, 11.6-2		76	107	21	67	10		8	1	55	40	2	1
9	11.7-1.1		2	10	1		2		1		1	10	1	
10	11.7-1.2													
11	11.7-1.3				1	1			1	1	1	1		
12	11.7-2.1		2	3	1				1		1			
13	11.7-2.2					2				2		2		2
14	11.7-2.3										17	16	3	1
15	12.1		17	16	2		9	20	2		2		2	
16	12.1-2.3								1					
17	12.2													
	Нийт		117	149	27	70	31	33	15	4	93	81	17	17

Хөвсгөл аймаг

Хөвсгөл аймгийн сум дундын эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхээс гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой эрүүгийн хуулийн 17-н зүйл заалтаар ирүүлсэн тоо баримтыг суурь тоогоор авч өөрсдийн цахим сангийн судалгаатай харьцуулж үзвэл 2021 онд нийт 169 хэрэг гарснаас 94 хувь буюу 159 шүүхийн шийдвэр цахим санд байршжээ. 2022 онд уг үзүүлэлтээр нийт 233 шүүхийн хэрэг шийдвэрлэгдсэн бол цахим санд түүний 90 хувь буюу 211 шүүхийн шийдвэр байршсан байна.

Хүснэгт 10. Хөвсгөл аймаг, шүүхийн шийдвэрийн задаргаа

№	Зүйлчлэл	ШТГ-аас		Цахим санд байршсан		ШТГ-аас		Цахим санд байршсан		Зөрүү			
		Шүүх		АШШ		ДЗШШ				АШШ		ДЗШШ	
		Он	2021	2022	2021	2022	2021	2022	2021	2022	2021	2022	2021
1	10.1	4	3	4	3			2	1				
2	10.1-2.8												
3	10.4												
4	11.1	16	13	15	12			2	2	1	1		
5	11.1-2.1												
6	11.4	14	23	12	14			2	1	2	9		
7	11.4-2.1		4	1	3					1	1		
8	11.6-1, 11.6-2	121	174	115	169			9	6	6	5		
9	11.7-1.1		1	1	1					1			
10	11.7-1.2												
11	11.7-1.3												
12	11.7-2.1												
13	11.7-2.2												
14	11.7-2.3												
15	12.1	14	13	10	8			3	2	4	5		
16	12.1-2.3		2	1	1					1	1		
17	12.2												
Нийт		169	233	159	211	0	0	18	12	16	22	0	0

Орхон, Дундговь, Өвөрхангай, Хөвсгөл аймгийн анхан болон давж заалдах шатны шүүхээс эрүүгийн хуулийн 17-н зүйл заалтаар ирүүлсэн ГБХ-тэй холбоотой гэмт хэргийн тоон мэдээллийг, багийн гишүүдийн цахим санд хийсэн ажиглалтын тоон мэдээлэлтэй харьцуулж үзвэл 2021 онд шүүхийн шийдвэрийг www.shuukh.mn цахим санд дунджаар 64,25 хувь, 2023 онд 78 хувьтай байршуулсан байна. 2021 онтой харьцуулахад 2022 онд www.shuukh.mn цахим санд байршуулсан шүүхийн шийдвэр 13,7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

4.2. АСУУЛГЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

ИНБ-уудын хамтын хүч түншлэлийн судлаачид 4 аймгийн 21 шүүгчийн туслахтай фокус бүлгийн ярилцлага хийлээ. Фокус бүлгийн ярилцлагыг Орхон, Дундговь аймгууд танхимаар, Хөвсгөл, Өвөрхангай цахимаар хийв. Аймгуудын сум дундын эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийн туслахуудын 76,2 хувь нь эмэгтэйчүүд байна.

Ярилцлагын эхэнд шүүгчийн туслахууд цахим санд шүүхийн шийдвэрийг байршуулахтай холбоотой техник ажиллагааны сургалтад хамрагдсан эсэх, олон нийт, хэргийн оролцогчдоос ирдэг санал гомдол, цахим санд шүүхийн шийдвэрүүдийг ил тод, нээлттэй байршуулахад ямар бэрхшээл тулгарч буй, хэрхэн яаж шийдвэрлэх боломжтой талаар мэдээлэл цуглуулахыг зорьсон. Ярилцлагыг баталгаажуулах үүднээс 10 асуултын хүрээнд цахим асуумж авч нэгтгэлээ.

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 39 дүгээр тогтоолын

3.3.4-т заасан “10 хоногийн дотор цахим хуудаст байршуулдаг эсэх” талаар 23 шүүгчийн туслахын 16 нь хэрэгждэг гэсэн бол зарим нэг шалтгаанаар хэрэгждэггүй харин зарим нь ажлын ачааллаас болоод хэрэгждэггүй, хэрэгжүүлэх гэж хичээдэг гэсэн хариулт өгсөн байна.

Шүүхийн цахим санд хамгийн түгээмэл алдаа нь доор дурдсанаар “хүн хуулийн этгээдийн нэр регистр нууцлах тодорхойлох боломжгүй

болгоогүй буюу бүтэн нэрээрээ байсан эсэх” гэсэн асуултад шүүгчийн туслахууд дараах хариултыг өгсөн байна. Үүнд:

- Нэг бүрчлэн хянаж үзээгүйн улмаас уг нөхцөл гардаг, анзааргагүй хайхрамжгүй байдал
- Ачаалал, мөн нууцлах үгийг оруулдаг боловч программын гацалтаас шалтгаалан нууцлагдахгүй байх тохиолдол гардаг,
- Нууцлах хэсэгт нууцлах үгнүүдээ оруулсан боловч зарим нь нууцлагдаагүй,
- “Тийн ялгал”-ын нөхцөлүүд залгасан тохиолдолд орхигдох магадлалтай байдаг,
- Цаг хэмнэхийн тул find and replace-ийг ашигладаг тэр үед алдаа гардаг тэгэхдээ гар механикаар уншиж нууцалж байснаас дээр,
- Shuukh.mn сайтад мэдээлэл оруулахад маш бэрхшээлтэй, нэг бүрчлэн гараар дарах хэрэг гардаг,
- Нууцлах ажиллагааг хялбарчлах, ажлын ачааллыг хөнгөвчлөх техник хэрэгсэл ашиглах шаардлагатай.
- Журмаа сайн уншаагүйгээс гэж хариулжээ.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль батлагдсантай холбоотой хэргийн холбогдогчоос шийдвэрийг цахим санд байршуулах зөвшөөрөл авдаг уу? гэсэн асуултад 23 шүүгчийн туслахаас 14-нь буюу 65.2 хувь бичгээр уг зөвшөөрлийг авдаг гэсэн бол бусад хариултын хувьд амаар авдаг, авдаггүй, шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах талаар мэдэгдэж гарын үсэг зуруулдаг, зөвшөөрөл бол авдаггүй гэсэн агуулгатай байлаа.

ШЕЗ-ийн 343-р тогтоолд шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэхдээ тухайн хүн, хуулийн этгээдийн нэрийг үсгээр тэмдэглэнэ. Жишээ нь: А, хуулийн этгээд бол "АВВ" хуулийн этгээд гэх мэт. Цахим санд холбогдогчийн мэдээлэл оруулахдаа уг журмыг мөрддөг эсэхийг шүүгчийн туслахуудаас асуухад 100 хувь тийм гэсэн байна.

Цахим хуудаст уг журмын 4.2-т зааснаас бусад шүүхийн шийдвэрийг байршуулна шүүхийн шийдвэр, гэр бүлийн маргаан, асран хамгаалагч тогтоох, хүүхэд үрчлэн авах, насанд хүрээгүй хүүхдийн эрх, хууль ёсны

ашиг сонирхлыг хөндсөн бусад хэрэгтэй холбоотой шүүхийн шийдвэр, бэлгийн халдашгүй байдал гэх мэт. Уг журамласан зохицуулалтын хэрэгжилт таны бодлоор хэр байдаг вэ гэсэн асуултад 22 шүүгчийн туслах оролцоноос 18 нь сайн хэрэгждэг гэсэн бол 4 нь дунд зэрэг гэсэн байна.

Шинэ админ, системийн бүрдүүлэгч, мэргэжилтэнд шүүхийн шийдвэрийг байршуулах сургалт явуулсны дараа нэвтрэх нэр, нууц үгийг шинээр нээж, эсхүл шилжүүлэн хүлээлгэн өгнө гэж заасан байдаг. Энэ сургалт хэр сайн явагддаг вэ? гэсэн асуултад 22 туслах оролцоноос 15 нь маш сайн хэрэгждэг буюу 7,8,9,10 оноо өгсөн бол 6 нь дунд 1 туслах маш муу гэж үнэлсэн байна.

Цахим санд байршуулбал зохих шүүхийн шийдвэрийг орхигдуулаагүй бүрэн байршуулсан эсэхэд админ шүүхийн шийдвэрийн дугаарын дарааллыг нягталж хяналт тавих бөгөөд энэ хяналтыг хэрэгжүүлэх тохиргоог цахим санд тусгана” гэжээ. Энэ журамласан зохицуулалтын хэрэгжилт ямар байна вэ гэсэн асуултад 22 шүүгчийн туслахын 16 туслах маш сайн хэрэгждэг гэж үнэлсэн бол 6 нь дунд зэрэг гэж хариулсан байна.

Хэргийн оролцогч цахим санд өөрийн хуулиар хамгаалагдсан нууцтай холбоотой мэдээллийг байршуулсан гэж өргөдөл, гомдол, санал гаргавал тухайн шүүхийн Тамгын газрын дарга шийдвэрт энэ журмын 7.2-т заасны дагуу тухай бүр засвар оруулна” гэжээ. Ийм тохиолдол гарч байсан уу? гэсэн асуултад шүүгчийн 22 туслахын 20 нь гарч байгаагүй гэсэн бол 2 шүүгчийн туслах нэг удаа гарч байсан болно тийм гэдэг хариулт өгсөн юм.

Таны бодлоор шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах журмын хэрэгжилтийг сайжруулах ямар ажил хийвэл үр дүнтэй байх вэ гэсэн асуултад дараах хариултыг өгчээ:

- Мэдээлэл байршуулах тусгай ажилтан байх шаардлагатай, шүүхийн туслахуудын ажлын ачаалал хэт их,

- Нэг зүйлээ хэт их давтахгүй ажлын ачаалал нэмэгдүүлэхгүйгээр shuukh.mn сайтыг илүү сайжруулах тал дээр анхаарвал зүгээр байна.
- Эрүүгийн хэргийн хяналт бүртгэлийн систем, шийдвэрийг цахим санд байршуулдаг систем хоёр хоорондоо уялдаа холбоотой байвал зүгээр нэг системээс нэг систем рүү хэргийн индекс, огноо, шийдвэрийн дугаар зэргийг заавал хуулж тавьдаг. Энэ мэт жижиг зүйлийг хялбарчлаад өгөх юм бол нэг ч гэсэн ажил бага болох байх гэж бодож байна,
- Ажлын 20 хоногт багтаан хийх, эрүүгийн бүртгэлийн системээс шийтгэх тогтоолыг татдаг болгох,
- Гарын авлага, видео хэлбэрээр сурталчлах гэх мэт,
- Тухайн шийдвэрийг оруулахад нууцлалыг автоматаар тохируулдаг байвал дээрх алдаа гарахгүй бөгөөд ажиллагаа орохгүй ямар нэг үр дагавар үүсэхгүй байх талтай гэж үзэж байна.
- Нууцлах үгийг илүү төвөг багатай оруулдаг болгох
- Программ гацалтаас зарим тохиолдолд нууцлал дутуу орж хадгалагдах, давхар хадгалагдаж байгаа.
- Тухайн цахим санд хэргийн дугаар хийхэд тухайн хэргийн мэдээлэл бүрэн татагдаж орж ирдэг болбол бас шүүгчийг туслахуудын ажлын ачаалал бас багасах юм болов уу.

Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах журамд шүүхийн шийдвэрийг нийтлэхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үл нөлөөлөх, байгууллага болон хувь хүний нууцыг хамгаалах зарчмыг баримтлах болон Монгол Улсын Үндсэн хууль, Шүүхийн тухай багц хууль, Төрийн нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрх чөлөөний тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид энэ журам нийцсэн байна гэж заасан байдаг.

Хүснэгт 11. Энэ журмын дагуу хийсэн мониторингийн тоон мэдээ
(4 аймгаар)

Аймаг	Хэргийн холбогдогч талууд		ЭХАШШ		ЭХДЗШШ		нийт
			2021	2022	2021	2022	
Дундговь	1	Хохирогч					
		Овог нэр	2	2	1	2	7
		Гэрийн хаяг	8	7	1		16
		Насанд хүрээгүй хүүхдийн нэр		1			
	2	Гэрч					
		нэр		3		5	8
	3	Шүүгдэгч					
		Овог,нэр	1	4	1		6
		РД	2	1	1		4
		Гэрийн хаяг	12	19	3		34
	Машины дугаар болон марк		1			1	
Нийт			2	16	7	7	66
Орхон	1	Хохирогч					
		Овог нэр	2	2			4
		Гэрийн хаяг	1				1
		Насанд хүрээгүй хүүхдийн нэр		4			4
	2	Гэрч					
		нэр	5	6			11
	3	Шүүгдэгч					
		Овог,нэр	1	1			2
		РД		2		1	3
		Гэрийн хаяг	6	5	3	8	22
	Машины дугаар болон марк						
Нийт			15	20	3	9	47
Өвөрхангай	1	Хохирогч					
		Овог нэр	4	1	2	1	8
		Гэрийн хаяг	4				4
		Насанд хүрээгүй хүүхдийн нэр					
	2	Гэрч					
		нэр	3	4	3		10
	3	Шүүгдэгч					
		Овог,нэр	14	27	8	5	54
		РД	4	8	2	2	16
		Гэрийн хаяг	17	31	5	4	56
	Машины дугаар болон марк	1	4			5	
Нийт			47	75	20	12	154

Аймаг	Хэргийн холбогдогч талууд		ЭХАШШ		ЭХДЗШШ		НИЙТ
			2021	2022	2021	2022	
Хөвсгөл		Хохирогч					
	1	Овог нэр	0	0	0	0	0
		Гэрийн хаяг	23	40	0	0	73
		Насанд хүрээгүй хүүхдийн нэр	0	0	0	0	0
	2	Гэрч					
		Нэр	0	0	0	0	0
	3	Шүүгдэгч					
	4	Овог, нэр	0	0	0	0	0
	5	Рд	3	1	0	0	4
	6	Гэрийн хаяг	0	0	0	0	0
7	Машины дугаар болон марк	4	0	0	0	0	
НИЙТ			30	40	0	0	77
НИЙТ ДҮН			94	151	30	28	303

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Орхон, Дундговь, Өвөрхангай, Хөвсгөл аймгийн анхан болон давж заалдах шатны шүүхээс эрүүгийн хуулийн 17-н зүйл заалтаар ирүүлсэн ГБХ-тэй холбоотой гэмт хэргийн тоон мэдээллийг, багийн гишүүдийн цахим санд хийсэн ажиглалтын тоон мэдээлэлтэй харьцуулж үзвэл 2021 онд шүүхийн шийдвэрийг www.shuukh.mn цахим санд дунджаар 64,25хувь, 2023 онд 78хувь-тай байршуулсан байна.

4 аймагт шүүхийн шийдвэрийн цахим сангийн журмын хэрэгжилтэд хийсэн мониторингийн дүн нь шүүхийн шийдвэр ил тод, хүртээмжтэй байдал янз бүрийн түвшинд байгааг харуулж байна. Зарим аймгуудын (Орхон, Хөвсгөл) цахим мэдээллийн санд байршуулсан хэргийн тоо маш өндөр хувьтай байсан бол бусад аймаг (Дундговь, Өвөрхангай) харьцангуй бага байсан ч жил ирэх тусам мэдэгдэхүйц сайжирч байгаа нь харагдаж байсан.

Орхон аймгийн хувьд шүүхийн тамгын газраас ирүүлсэн тоо нь 36 байсан бол цахим санд байршуулсан хэрэг нь 215 байсан. Уг асуудлаар шүүгчийн туслахуудаас тодруулж асуухад, системийн гацалт их байдаг, үүнээс болж хэргүүд маш их давхардаж ордог талаар ярьсан.

Цахим сангийн бүтэц журамд заасны дагуу байсан бөгөөд гагцхүү цахим санд хайлт хийх зааврыг орхигдуулсан байна. Журмын 3.4-т дурдсан цахим сан дахь хайлтын шалгуур үзүүлэлт болсон цогц өгөгдөл мэдээллээс шүүхийн шийдвэрийг богино хугацаанд оновчтой хайх зорилгод цахим сангийн бүтэц нийцсэн гэж бид дүгнэж байна. Журмын 5.2.1-д заасан шүүхийн шийдвэрт дурдсан хүн хуулийн этгээдийн нэр регистрийн дугаар гэх мэт нууцлал бүхий мэдээллийг тодорхойлох боломжгүй болгон нууцлах гэсэн зүйл заалт хамгийн их зөрчигдсөн байсан бөгөөд хайхрамжгүй байдал, ачаалал гэх хариулт их давтагдсан бол нууцлах үгийг оруулдаг боловч программын гацалтаас шалтгаалан нууцлагдахгүй байх тохиолдол гардаг, нууцлах хэсэгт нууцлах үгнүүдээ оруулсан боловч зарим нь нууцлагдаагүй, “тийн ялгал”-ын нөхцөлүүд залгасан тохиолдолд орхигдох магадлалтай байдаг зэрэг шалтгаан дурдаж байв. Иймд Хүний хувийн мэдээллийг нууцлах арга зүйг агуулсан нарийвчилсан зохицуулалт шаардлагатай байна.

Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах нөхцөл байдал ажиглагдлаа. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 3.2-т...Төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээллийг хамгаалах шаардлагатай, өсвөр насны яллагдагч, арван найман насанд хүрээгүй хохирогчтой холбогдох эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхээс бусад шүүхийн хэлэлцүүлэг, бүх шатны шүүх хуралдааныг нээлттэй явуулна...гэсэн нэмэлт өөрчлөлт эрүүгийн процессын хуульд 2021 оны 12-р сарын 17-нд орсон байдаг. Хэдий тийм боловч 2021 оны 12-р сарын 17-ны өдөр батлагдсан Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн 6.3-д мэдээллийн эзний мэдээллийг нээлттэй өгөгдөл болгохдоо Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан журмыг баримтлахаар байгаа ба уг 12 дугаар зүйлд хүн, хуулийн этгээдийг тодорхойлох боломжгүй болгосноор нээлттэй өгөгдөл болгоно гэж заасан ба уг хуулийн 12.10-т ... хүн хуулийн этгээдийг тодорхойлох боломжтой бол нээлттэй өгөгдөлд нийтлэхийг хориглосон байна.

Мөн түүнчлэн Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль батлагдсантай холбоотой хэргийн холбогдогчоос шийдвэрийг цахим санд байршуулах зөвшөөрөл авдаг эсэх асуултад 23 шүүгчийн туслахаас 14-нь буюу 65.2 хувь бичгээр уг зөвшөөрлийг авдаг гэсэн бол амаар авдаг, авдаггүй, Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах талаар мэдэгдэж гарын үсэг зуруулдаг, зөвшөөрөл бол авдаггүй, шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах талаар мэдэгддэг, Зөвшөөрөл авдаггүй, Шүүхийн шийдвэрийг зохих журмын дагуу нэгдсэн санд байршуулдаг талаар мэдэгдэж, тайлбарлан холбогдох баримтад гарын үсэг зуруулж хэрэгт хавсаргадаг гэх мэт хариулсан байгаа нь журамтай нарийн танилцаагүй нь харагдаж байна.

Хэдийгээр 2021 онд эрүүгийн процессын хуульд орсон өөрчлөлттэй холбоотой нээлттэй хэргийн оролцогчдоос тусгайлан зөвшөөрөл авах үүрэггүй ч нээлттэй өгөгдөл болгон цахим сан руу оруулахдаа хувь хүний мэдээлэл, регистрийн дугаар, орон гэрийн хаяг нууцлагдаагүй орж буйгаар дээр заасан үндэслэлээр холбогдох хуулиудыг ноцтой зөрчиж байна. Иймд энэ чиглэлээр тусгайлсан сургалт орж ач холбогдлыг шүүгчийн туслахад ойлгуулах, нууцлах ажиллагааг хөнгөвчлөх системийн шинэчлэл нэн даруй хэрэгтэй байна.

Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулахад хүний хувийн мэдээлэл, регистрийн дугаар, орон гэрийн хаяг нууцлагдаагүй байгаа 303 тохиолдол ажиглагдсан тул энэ чиглэлээр тусгайлан сургалт зохион байгуулж, хүний эрх, хүний нууцтай холбоотой зөрчил болохыг шүүгчийн туслахад ойлгуулах, яг яаж дээрх мэдээллийг нууцлах арга техникийг тогтох, нууцлах ажиллагааг хөнгөвчлөх системийн шинэчлэлийг нэн даруй хийх шаардлагатай гэж үзлээ.

ТАВ. ГАДААД УЛСЫН ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Шүүхийн ил тод байдлыг Европын холбооны гишүүн улсуудад “*transparency*”, “*visibility*” гэсэн нэр томъёогоор илэрхийлж байна. Үүний дотор шүүхийн шийдвэрийн ил тод байдал багтана. Энэ нь өөрөө хоёр талтай ойлголт юм. “*Access to court decisions*” нь нийтлэгдсэн шүүхийн шийдвэрийн эрх зүйн байдлын тухай асуудлыг илэрхийлэх бол “*accessibility*” нь тухайн шийдвэр дотор эсхүл шийдвэрийн сан дотор агуулагдаж буй мэдээллийг олж авахад хэр зэрэг төвөг бэрхшээлгүй амар, хялбар байгааг илэрхийлнэ.

Шүүхийн шийдвэрийг нийтэд ил болгох зорилго нь интернэт бий болохоос өмнө ч тодорхой хэлбэрээр хангагдаж байсан. Шүүхийн шийдвэрийг ил тод болгох нэн тэргүүний зорилго бол шүүгчийг олон нийтийн хяналтад байлгах явдал бөгөөд энэ нь шүүхийн шийдвэрийг уншиж, танилцуулснаар тодорхой хэмжээнд хэрэгжиж байжээ. Удаах зорилго нь эрх зүйн хөгжлийн талаар олон нийтийг мэдээллээр хангахад оршиж байсан ба чухал ач холбогдол бүхий шийдвэрүүдийг шүүхүүд өөрсдөө эсхүл хэвлэлийн газрууд сонгомол байдлаар хэвлэн нийтэлж байжээ. Интернэт ашиглан шүүхийн шийдвэрийг нийтлэх нь орчин үеийн гол чиг хандлага болж байна.

5.1. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ НИЙТЭЛЖ БҮЙ ПРАКТИК

Европын холбооны ихэнх улсуудад шүүхийн шийдвэрийг интернэт ашиглан нийтэлж байна. Гэвч хамрах хүрээ, арга, хэлбэрийн хувьд олон янз, улсууд хоорондоо ихээхэн ялгаатай байх бөгөөд нэг улсын дотор ч (шүүхийн төрлөөс хамааран) харилцан адилгүй олон янз байдал ажиглагдаж байна. Практикаас үзэхэд шүүхийн шийдвэрийг үндсэн хуулийн шүүх, дээд шүүх, давж заалдах шатны шүүх, анхан шатны шүүх, захиргааны дээд шатны шүүх, захиргааны анхан шатны шүүх гэсэн шүүхийн төрөл тус бүрээр нийтэлж байна.

Харин тухайн төрлийн шүүхийн шийдвэрүүдээс чухам аль хэсгийг нь сонгон нийтлэх вэ гэдгийг шийдэхэд Европын Холбооны Сайд нарын зөвлөлийн Сайд нарын хорооноос гаргасан Зөвлөмж R(95)11-д тодорхойлсон дараах хоёр ойлголтыг ашиглаж байна.

Хориглосноос бусдыг нийтлэх буюу сөрөг сонголтын зарчим (*negative selection*) энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг үндэслэн нэг маягаар шийдэгдсэн (жишээ нь: хэрэгсэхгүй болсон) эсхүл насанд хүрээгүй хүн, үндэсний аюулгүй байдал, мэдээллийн нууцлал зэрэг шалтгаанаар хэвлэж болохгүйгээс бусад бүх хэргийн шийдвэрийг нийтлэх зарчим;

Сонгож нийтлэх буюу эерэг сонголтын зарчим (*positive selection*) энэ нь шүүхийн шийдвэрийг зөвхөн урьдаас тогтоосон тодорхой шалгуураар сонгож нийтлэх зарчим. Энэ шалгуур нь об'ектив эсхүл суб'ектив, өргөн эсхүл явцуу, ойлгомжтой эсхүл бүрхэг, процессын эсхүл материаллаг байх нь бий.

Европын Холбооны гишүүн улсуудын хууль, журамд зааснаар үндсэн хуулийн шүүх, дээд шүүх, захиргааны дээд шүүхийн хувьд хориглосноос бусдыг нийтлэх зарчим үйлчилдэг. Доод шатны шүүхүүд буюу анхан шатны шүүх, давж заалдах шатны шүүх, захиргааны анхан шатны шүүхийн хувьд хориглосноос бусдыг нийтлэх зарчим тогтоосон улс 20 гаруйхан хувийг эзэлж байна (Болгар, Дани, Эстони, Латви, Литва, Польш, Румын, Словак).

Хүснэгт 12. Европын Холбооны гишүүн улсууд түүхийн шийдвэрийг нийтлэх журам болон түүний хэрэгжилт





	Үндсэн хуулийн шүүх		Дээд шүүх		Давж заалдах шатны шүүх		Анхан шатны шүүх		Захиргааны дээд шатны шүүх		Захиргааны шүүх		Бүх шүүх
	Хууль, журам	Бодит байдал	Хууль, журам	Бодит байдал	Хууль, журам	Бодит байдал	Хууль, журам	Бодит байдал	Хууль, журам	Бодит байдал	Хууль, журам	Бодит байдал	
Бельги	сөрөг		ээрэг		ээрэг		ээрэг		сөрөг		байхгүй		4
Болгар	байхгүй		сөрөг		сөрөг		сөрөг		сөрөг		сөрөг		4
Чех	сөрөг		ээрэг		ээрэг		ээрэг		сөрөг		ээрэг		3
Дани	---	---	сөрөг		сөрөг		сөрөг		---	---	---	---	2
Герман	сөрөг		сөрөг		байхгүй		байхгүй		сөрөг		байхгүй		>5
Эстони	---	---	сөрөг		сөрөг		сөрөг		---	---	сөрөг		2
Ирланд	---	---	байхгүй		байхгүй		байхгүй		---	---	байхгүй		3
Грек	байхгүй		байхгүй		байхгүй		байхгүй		байхгүй		байхгүй		1
Испани	сөрөг		ээрэг		ээрэг		ээрэг		ээрэг	---			2
Франц	сөрөг		сөрөг		ээрэг		ээрэг		сөрөг		ээрэг		5
Хорват	байхгүй		байхгүй		байхгүй		байхгүй		байхгүй		байхгүй		3
Итали	сөрөг		сөрөг		сөрөг		сөрөг		сөрөг		сөрөг		3
Кипр	---	---	байхгүй		---	---	байхгүй		---	---	---	---	2
Латви	сөрөг		сөрөг		сөрөг		сөрөг		сөрөг		сөрөг		3
Литва	сөрөг		сөрөг		сөрөг		сөрөг		сөрөг		сөрөг		3
Люксембург	сөрөг		байхгүй		байхгүй		байхгүй		байхгүй		байхгүй		1
Унгар	сөрөг		сөрөг		ээрэг		ээрэг		---	---	ээрэг		2
Мальт	байхгүй		байхгүй		байхгүй		байхгүй		байхгүй		---	---	2
Нидерланд	---	---	сөрөг		ээрэг		ээрэг		сөрөг		---	---	2
Австри	сөрөг		сөрөг		ээрэг		ээрэг		сөрөг		ээрэг		2
Польш	сөрөг		ээрэг		байхгүй		байхгүй		сөрөг		сөрөг		3
Португал	байхгүй		байхгүй		байхгүй		байхгүй		байхгүй		байхгүй		3
Румын	сөрөг		сөрөг		сөрөг		сөрөг		---	---	---	---	4
Словени	сөрөг		сөрөг		ээрэг		байхгүй		ээрэг		байхгүй		3
Словак	сөрөг		сөрөг		сөрөг		сөрөг		---	---	---	---	3
Финлянд	---	---	сөрөг		байхгүй		байхгүй		сөрөг		байхгүй		1
Швед	---	---	ээрэг		ээрэг		байхгүй		ээрэг		ээрэг		4
Их Британи	---	---	байхгүй		байхгүй		байхгүй		---	---	---	---	>5

Тайлбар: --- тухайн төрлийн шүүх байхгүй

Хууль, журам

- байхгүй хууль, журам гараагүй
- ээрэг эерэг сонголтын зарчим тогтоосон
- сөрөг сөрөг сонголтын зарчим тогтоосон

Бодит байдал

-  огт үгүй эсхүл маш цөөн
-  цөөвөр
-  нэлээд хэсэг нь
-  бүгд эсхүл сөрөг сонголтоор

Дээрх хүснэгтээс үзэхэд, захиргааны хэргийн бүх шатны шүүхийн шийдвэрийг бүрэн нийтэлдэг улсын тоонд Болгар, Герман, Грек, Латви, Литва, Польш улс орж байна.

Шүүхийн шийдвэрийг нийтлэхэд баримтлах дээрх хоёр зарчмыг хэрэгжүүлэхэд илүү нарийвчилсан заавар, зөвлөмж шаардлагатай байдаг. Гэвч Нидерландаас бусад улсад сонгож нийтлэх зарчмын дагуу шүүхийн шийдвэрүүдээс сонголт хийх шалгуурыг өнөөгийн байдлаар бий болгоогүй байна. Харин хориглосноос бусдыг нийтлэх зарчмын шалгуур үзүүлэлт зарим улсад үйлчилж байна.

Хууль, журмын зохицуулалтаас гадна бодит практикийг судлах шаардлагатай. Зохион байгуулалтын эсхүл техникийн шинжтэй саад бэрхшээлээс шалтгаалан хууль, журмын хэрэгжилт хангалтгүй байж болно. Нөгөө талаар, практик нь хангалттай өндөр түвшинд хүрсэн тохиолдолд хууль, журам гаргах шаардлага бас үүсэхгүй байж болно.

5.2. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ЦАХИМААР НИЙТЛЭХ БОДЛОГО

Европын Холбооны гишүүн улсуудад олон нийтэд зориулсан шүүхийн шийдвэрийн цахим сангууд байхаас гадна нийтэд хаалттай цахим сангууд байдаг болох нь судалгаагаар тогтоогдсон. Испани зэрэг улсад шүүхийн систем дотооддоо ашигладаг цахим сан байх бөгөөд тэр нь олон нийтэд зориулсан санд байдаггүй илүү олон нэмэлт метадата болон хайлт хийх сонголттой байна. Нидерланд зэрэг улсад шүүхийн дотоод мэдээллийн сан нь нэмэлт метадата байхгүйгээс гадна нууцлалгүй байдаг. Итали зэрэг зарим улсад төр, хувийн хэвшил хамтран ажиллуулдаг цахим сан байх бөгөөд үүнийг шүүхүүд үйл ажиллагаандаа ашиглахаас гадна мэргэжлийн хуульчид болон бусад хэрэглэгчид төлбөртэйгөөр ашиглаж байна.

Европын Холбооны гишүүн улсуудын дийлэнхэд нь нэгээс дээш тооны цахим сан ажиллаж байна. Үндсэн хуулийн шүүхүүд өөрсдийн цахим хуудастай байгаа бол дээд шүүхүүд, захиргааны хэргийн дээд шүүхүүд, тусгай шүүхүүд мөн адил байна. Харин анхан шатны, давж

заалдах шатны, захиргааны хэргийн анхан шатны шүүхүүд нь дундаа нэг цахим хуудастай улсууд олон байна. Зарим тохиолдолд буюу Мальт, Австри, Португал, Финляндад нэг портал сайтаас шүүхийн системийн бүх шийдвэрүүдийг олж авах боломжтой. Испани улсын хувьд үндсэн хуулийн шүүхээс бусад бүх шүүхийн шийдвэрийг нэг санд төвлөрүүлсэн. Ийм төвлөрсөн цахим хуудастай зэрэгцээд шүүхийн төрөл тус бүрээр цахим хуудас бий болгосон Франц, Герман зэрэг улс ч байна. Энэ тохиолдолд шүүхийн цахим хуудаснууд нь төвлөрсөн веб сайтаас өөр шийдвэрүүд сонгон байршуулсан байх ба мэдээлэл олж авахад хялбар байдлаар ялгагдаж, метадата, хайлтын сонголтууд нь өөр байна. Ерөнхийдөө 2-3 цахим хуудастай байх нь түгээмэл бөгөөд хэт олон веб сайт байгуулах нь мэргэжлийн хуульчид, иргэдэд төвөгтэй байдал үүсгэж болох юм.

Интернэт бий болохоос өмнө шүүхийн сонгомол шийдвэрүүдийг арилжааны зорилгоор эмхэтгэж хэвлэн нийтэлдэг байсан. Европын Холбооны гишүүн улсуудад олон нийтэд зориулсан цахим сан бий болсны дараа ийм арилжааны хэлбэр зонхилох үүрэг гүйцэтгэхээ больсон. Ганцхан Италид шүүхийн хамгийн чухал шийдвэрүүдийн цахим сан зөвхөн мэргэжлийн хуульчдад нээлттэй, төлбөртэй үйлчилгээ үзүүлж байна.

Харин бүх гишүүн улсад арилжааны хэвлэлийн газрууд нийтэд ил болсон шийдвэрүүдийг дахин ашиглах, дахин хэвлэн нийтлэх нь чөлөөтэй байдаг. Хэвлэлийн газрууд нийтэд зориулсан цахим санд ороогүй шийдвэрүүдийг олж хэвлэх гэсэн сонирхолтой байдаг. Гэвч жишээ нь: Литвад үүнийг зөвшөөрдөггүй байна. Зөвхөн нийтэд ил байгаа шийдвэрүүдийг дахин ашиглах боломжтой байдаг.

Ихэнх шийдвэрүүд бүрэн эхээрээ хэвлэгдэж байна. Австрид шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг тусад нь нийтэлдэг. Доод шатны шүүхийн шийдвэрийн хувьд тогтоох хэсгээр хязгаарлах нь түгээмэл байна. Дээд шатны шүүхүүд шийдвэрээ бүтнээр нь нийтэлдэг. Шийдвэрийг нэг л нийтэлсэн бол буцаах тохиолдол маш ховор байдаг. Тэр нь мэдээллийн нууцлалыг хамгаалах зорилготой байж болно. Зарим улс түүхэн ач холбогдолтой өмнөх үеийн түүхэнд холбогдох материалыг нэмж нийтэлж байна (жишээ нь, Бельги, Кипр).

Веб сайтад байршуулсан шүүхийн шийдвэрийг жинхэнэ эх хувь (*authentic*) гэж үзэх үү гэсэн асуултад улсуудын 50 хувь нь “тийм” гэж, мөн нөгөө хагас нь “үгүй” гэж хариулсан байна. Цахим хуудаст байршуулсан шүүхийн шийдвэрийг хатуу хууль зүйн агуулгаар авч үзвэл жинхэнэ эх хувь гэж тооцох боломжгүй. Энэ нь зарим мэдээллийг танигдахгүй болгон өөрчилдөг. Тэгж өөрчлөөгүй, мөн PDF форматаар нийтэлсэн байсан ч цахим гарын үсгээр баталгаажуулаагүй л бол жинхэнэ эх хувь гэж үзэхгүй гэсэн үзэл баримтлалтай холбоотой. Гэсэн хэдий ч шүүхийн веб сайтад байршуулсан шийдвэрийг практикт эрх бүхий байгууллагаас гарсан (*authoritative*) эх сурвалж гэж үзнэ. Хэдийгээр зарим мэдээллийг танигдахгүй болгон өөрчилж байгаа ч онлайн хувилбар нь хэргийн талуудад гардуулсан жинхэнэ эх хувьтай адил гэж тооцно.

Шүүхийн шийдвэрийг нийтлэх хугацаа улс бүрд өөр өөр байна. Шүүхийн төрлөөс хамааран хугацаа нь мөн ялгаатай. Онцлох ач холбогдол бүхий (*landmark*) шийдвэрүүдийг эхний ээлжид нийтэлдэг практик Нидерландад байна. Шүүхийн шийдвэрийг өмгөөлөгчид өөрсдийн гаргасан үндэслэл, байр сууриа дэмжих зорилгоор ашигладаг, шүүгч нар хууль зүйн гаргалгаа хийхдээ мөн эш үндэс болгодог учраас тухайн шийдвэр давж заалдах гомдол гаргах хугацаа өнгөрсөн үндэслэлээр эцсийнх (*irreversible*) болсон эсхүл тухайн шийдвэрт давж заалдах гомдол гарсан эсэх, хэрэв тийм бол дээд шатны шүүх түүнийг хүчингүй болгосон, хэвээр үлдээсэн, хараахан шийдвэрлээгүй байгаа эсэхийг мэдэх нь маш чухал байдаг. Гэтэл олон нийтэд зориулсан цахим хуудаснуудад энэ талаарх мэдээлэл бараг л байхгүй байна. Эстонид энэ асуудлыг шийдэхийн тулд зөвхөн хуулийн хүчин төгөлдөр болсон буюу эцэслэсэн шийдвэрийг нийтлэх журам тогтоосон. Нидерландад процессын хувьд хоорондоо холбоотой шийдвэрүүдийг цахим санд холболтоор харуулдаг. Харин шийдвэр гараагүй хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж буй хэргүүдийг харах боломжгүй байна. Эстони, Хорват, Словак улсад ийм холбоосыг харуулсан байна. Финляндын дээд шүүх шийдвэр нь эцэслэж хараахан гараагүй байгаа шийдвэрүүдийг байршуулсан тусгай цахим хуудастай байна.


Шийдвэрийн цахим сангаас мэдээлэл олж авах боломж (*accessibility*) гэдэгт баримт бичгийн формат, хайлтын систем, метадата, орчуулга зэрэг асуудал хамаарна. Орчин үед шүүхийн шийдвэр анхнаасаа цахим хэлбэрээр бичигдэж, Word, PDF, (X)HTML гурвын аль нэг хэлбэрээр нийтлэгдэж байна. Нийтлэх формат нь тухайн улсын шүүх бүр дээр өөр өөр, нэг ижил шийдвэрийг ч өөр өөр форматаар нийтлэх явдал байна. Зарим тохиолдолд хуучин шийдвэрүүд PDF-ээр, сүүлийн үеийн шийдвэрүүд HTML-ээр нийтлэгдсэн байдал ч харагдана. Ийм олон янз байдлаас болж яв цав дүр зураг гаргаж ирэх боломжгүй байдаг. Тоймлон хэлбэл, шүүхийн шийдвэрийн 20 хувь нь Word, 40 хувь нь PDF, 40 хувь нь HTML форматаар нийтлэгдэж байна.

Шүүхийн шийдвэрийг орчуулсан хувилбар нь ялангуяа Европын Холбооны эрх зүй, хүний эрх, худалдааны эрх зүй, оюуны өмчтэй холбоотой маргааныг шийдвэрлэсэн шийдвэр гадаад улсын хэрэглэгчдийн сонирхлыг татах боломжтой байдаг. Бүх шийдвэрээ эсхүл нэлээд хэсгийг нь өөр хэлээр тэгэхдээ голдуу англи хэлээр орчуулан нийтэлж байгаа цөөн тооны шүүх байна. Тухайлбал, үндсэн хуулийн шүүхүүдэд ийм практик зонхилж байна. Жишээ нь, Словени, Польш, Чех, Латви, Хорват.

Шүүхийн шийдвэрийн сангаас мэдээлэл олж авахад метадата чухал үүрэгтэй. Метадата нь хайлт хийхдээ хүссэн мэдээллээ тодорхойлох, илэрц дотроос дахин шүүж үзэх, тухайн шийдвэрийн утга, агуулгыг ойлгох, түүний эргэн тойрны нөхцөл байдлыг тодруулах зэрэгт зайлшгүй хэрэгтэй байдаг. Шүүхийн нэр, шийдвэрийн огноо, хэргийн дугаар зэрэг метадата ямагт байдаг бол шийдвэрийн төрөл, эрх зүйн салбар, шүүхийн дотоод нэгж зэргийг ихэнх тохиолдолд зааж өгч байна. Илүү тодорхой тайлбарласан агуулгатай метадата болох толгой үг (*headnotes*), хураангуй, мөн бусад төрлийн мэдээлэл тийм ч түгээмэл биш, голдуу дээд шатны шүүхүүд ийм мэдээлэл нийтэлдэг байна. Үүний нэг том шалтгаан бол ийм метадата үүсгэхэд цаг хугацаа орохоос гадна сайн бэлтгэгдсэн хүний нөөц шаардлагатай байдаг. Тиймээс энэ нь зөвхөн цөөн тооны шийдвэрийн сангийн хувьд боломжтой зүйл юм. Нийтлэгдсэн шүүхийн шийдвэр дотор хууль тогтоомж, бусад шүүхийн

шийдвэртэй цахим холбоос үүсгэсэн тохиолдол бараг байхгүй. Цөөхөн тохиолдолд ийм холбоос метадата дотор тааралдаж байна. Словак, Хорват улсын жишээг үзэж болно.


График 9. Цахим хуудаст байрлах мэдээллийн төрлүүд



5.3. ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ДУРДАГДСАН МЭДЭЭЛЛИЙН ЭЗНИЙГ ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖГҮЙ БОЛГОХ (ANONYMIZATION)

Эл асуудал Европын Холбооны гишүүн улсууд дараах графикт харуулсан эрх зүйн барим бичгийн хүрээнд зохицуулж байна.

График 10. Шүүхийн шийдвэр доторх мэдээллийн нууцлалтай холбоотой зохицуулалт



Тусгайлсан хууль (журам): Шүүхийн шийдвэрийн доторх мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгох эсэхийг тусгайлан зохицуулсан хуулийн хэм хэмжээ үйлчилдэг. Голдуу шүүхийн шийдвэрийг нийтлэх талаар зохицуулсан хуульд тус хэм хэмжээ агуулагдана. Зохицуулалт нь нарийвчилсан эсхүл ерөнхий байх ба хэрэв хуульд ерөнхий заасан бол түүнийг журмаар дэлгэрүүлэн зохицуулсан байдаг.

Журам: Шүүхийн шийдвэрийн доторх мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгох талаар зохицуулсан хуулийн хэм хэмжээ байхгүй. Харин шүүхийн ерөнхий зөвлөл эсхүл Дээд шүүхээс гаргасан журмаар заавар, чиглэл өгдөг.

Мэдээллийн нууцлалыг хамгаалах эрх зүйн ерөнхий зохицуулалт: Энэ ерөнхий зохицуулалт нь шүүхийн шийдвэрийг нийтлэхэд хамаарч үйлчилнэ гэж үздэг боловч хуулиар ч, журмаар ч тусгайлан зохицуулсан хэм хэмжээ байхгүй.


Эрх зүйн ямар ч зохицуулалт байхгүй: Тусгайлсан хэм хэмжээ байхгүйгээс гадна мэдээллийн нууцлалыг хамгаалах эрх зүйн зохицуулалт шүүхийн шийдвэрт хамааралгүй гэж үздэг.

Хамааралгүй. Тухайн төрлийн шүүх ерөөс байхгүй.

Монгол Улсад шүүхийн шийдвэртэй холбоотой мэдээллийн нууцлалыг хэрхэн хангах талаар тусгайлсан хууль тогтоомж гараагүй боловч ерөнхий эрх зүйн хэм хэмжээ тогтоосон “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” хууль, түүнд үндэслэсэн журам үйлчилж байна. Шүүхийн байгууллага нь уг хуульд зааснаар “мэдээлэл хариуцагч” бөгөөд мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгох талаар журам, зааварчилгаа баталж, мөрдүүлэх үүрэгтэй байна.

Шүүхийн шийдвэр доторх мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгохыг хуулиар шаардахгүй ч байж болох учраас бодит байдлыг тийм хууль үйлчилж байгаа эсэхээс үл хамааран судалж үзэх хэрэгтэй. Шийдвэрийн доторх хувь хүний мэдээллийг танигдахгүй болгох нь хэвшил болсон ажиллагаа юу эсхүл зөвхөн мэдээллийн эзний зөвшөөрлөөр, мөн шүүгч эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан шийдвэрээр уг ажиллагаа хийгддэг үү гэсэн асуултад хэрхэн хариулсныг дараах графикт үзүүлсэн.

График 11. Шүүхийн шийдвэрт тусгасан мэдээллийг нууцалж буй байдал



Шүүхийн шийдвэр доторх мэдээллийг нууцлах ажиллагаа хэвшил болоогүй улсын тоо харьцангуй цөөн байгааг графикаас харж болно.

Чухам ямар мэдээллийг танигдахгүй болгон өөрчлөх талаар маш олон янзын шийдэл бий болсон байгаа тул нэгдсэн ангилалд оруулах боломжгүй байв. Зарим улсад “хувь хүний мэдээлэл” гэж ерөнхий заагаад “хувь хүний мэдээлэл”-д чухам юуг хамааруулах вэ гэдгийг практик үйл ажиллагааны явцад тодорхойлж байна. Нөгөө нэг хэсэг улсад ямар мэдээллийг нууцлах талаар нэлээд чамбай тодорхойлж, заримдаа “мөн бусад” хэмээн мэдээллийн хүрээг нээлттэй орхиж байна.

Хүн, хуулийн этгээдийг ялгаатай авч үзэх нь нийтлэг байх бөгөөд хувь хүний мэдээллийг нууцалж, харин хуулийн этгээдийг нууцлахгүй журамтай байна. Мөн мэргэжлийн ажлаа хийх зорилгоор шүүх ажиллагаанд оролцож буй шүүгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шийдвэр гүйцэтгэгч, өмгөөлөгч, шүүх шинжээч, орчуулагч, асран хамгаалагч зэргийг нууцлахгүй гэсэн нийтлэг практик тогтжээ.

Судалгаанд оролцсон 10 улс зарим тодорхой төрлийн хэргийн доторх мэдээллийг өөрчлөхгүй гэсэн журамтай байх ба үүнд нийтийн албан тушаалтнууд оролцсон бөгөөд нийтийн албаны чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой хэргүүд хамаарна.

Практикт шүүхийн эх бичвэрт өөрчлөлт оруулах хэд хэдэн өөр арга хэрэглэгдэж байна:

- Тухайн мэдээллийг бүрмөсөн танигдахгүй болгох, тухайлбал, эх бичвэрээс арилгах, дарах, цэгээр эсхүл од тэмдэглэгээгээр орлуулах гэх мэт. Энэ аргын сул тал нь эх бичвэрийн утгыг ойлгоход төвөгтэй болдог. Тухайлбал, танигдахгүй болгосон хоёр тусдаа элементийн цаана нэг ижил зүйл байна уу эсхүл өөр, өөр зүйл байна уу гэдгийг мэдэх аргагүй болдог (жишээ нь, гэрч № 5 болон гэрч № 6-г хооронд нь ялгах аргагүй болно).
- Нэрийн эхний үсэг ашиглах, тодруулбал, нэрийг товчилж эхний үсгийг үлдээх юм уу эсхүл өөр дурын үсэг сонгож хэрэглэх. Жинхэнэ нэрийн эхний үсгийг ашиглах тохиолдолд хэрэв тухайн үсгүүдийн хослол нь ховор бол хэн болохыг нь тааварлахад хялбар болох талтай. Нэрийн үлдсэн үсгүүдийг зүгээр арилгахгүй, үсгийн

тоотой ижил тооны цэг, бусад тэмдэгтээр орлуулсан тохиолдолд мэдээллийн эзэн танигдах эрсдэл бүр ч нэмэгдэнэ.

- Жинхэнэ нэрийг хуурамч нэрээр солих, тоог мөн хуурамч нэрээр орлуулах. Энэ арга мөн л сул талтай. Мэдээллийн аль нь солигдсон, аль нь жинхэнэ болохыг ялгаж тодорхойлох боломжгүй болно. Гэвч бас нөгөө талдаа, “мэдээлэл сарниж” мэдээллийн эзнийг танихад илүү төвөгтэй байж болох юм.
- Хэргийн оролцогчдийг түүний гүйцэтгэж буй үүргийг илэрхийлсэн нэр томъёогоор тэмдэглэх. Энэ тохиолдолд уншиж ойлгоход хялбар болгох үүднээс тухайн үгийг эх бичвэрийн бусад хэсгээс ялгаж өгөх хэрэгтэй. Жишээ нь, дөрвөлжин хаалтад бичих зэргээр [Гэрч № 5].

Европын улсуудын практикаас үзэхэд хэргийн оролцогч болон бусад оролцогчийн эхний үсгээр товчилж солих арга түгээмэл хэрэглэгдэж байна.

Хангайн бүсийн аймгуудын шүүхийн шийдвэрийн ил тод байдалд мониторинг хийх нь” судалгааны үр дүнд тулгуурлан бид дараах дүгнэлтийг хийлээ.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2022 онд баталсан “Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах журам” нь Монгол улсын үндсэн хууль, шүүхийн тухай хуулийн үзэл баримтлал, шүүхийн ил тод байдлыг хангах зорилгод нийцэж буй бөгөөд цахим санд шүүхийн шийдвэрийг байршуулах, хяналт тавих гэсэн хоёр гол зохицуулалтыг агуулжээ. Тус журам нь шүүхийн захиргааны ажилтнуудад зориулсан дотогшоо чиглэсэн хэм хэмжээ мэт боловч түүгээр дамжуулан шүүхийн ил тод байдал, хувь хүний нууц, халдашгүй байдал, хүүхдийн эрх ашгийг хамгаалах зэрэг нийтийн эрх зүйн хүрээний зохицуулалтыг агуулсан байна.

Журамд хувь хүний нууц, халдашгүй байдлыг хамгаалах маш нарийн зохицуулалт байгааг 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгээс харж болно. Жишээ нь 4.2.3 гэр бүлийн маргаан, асран хамгаалагч тогтоох, хүүхэд үрчлэн авах, насанд хүрээгүй хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн бусад хэрэгтэй холбоотой шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулахгүй бөгөөд 5.2.1-д зааснаар шүүхийн шийдвэрт дурдсан хүн,

хуулийн этгээдийн нэр, регистрийн болон улсын бүртгэлийн дугаар, оршин суугаа болон үйл ажиллагаа явуулж байгаа газрын хаяг, эд хөрөнгийн бүртгэлийн дугаар зэрэг мэдээллийг тодорхойлох боломжгүй болгон нууцлах ёстой байна.

Журмаас үзвэл шүүхийн шийдвэрийг цахим санд оруулах үүрэгтэй албан хаагч нь “системийн бүрдүүлэгч” буюу шүүгчийн туслах бөгөөд түүний үйл ажиллагаанд тухайн шүүхийн Тамгын газрын мэдээлэл, технологийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа албан хаагч мэргэжилтэн, Тамгын газрын дарга хяналт тавих талаар зохицуулжээ.

Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах ёстой шүүгчийн туслахын албан тушаалын тодорхойлолт, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд shuukh.mn сайтад мэдээлэл оруулах талаар тухайлсан зохицуулалтыг оруулж, нэг мөр болгох, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2020 оны 4 дүгээр сард баталсан шүүгчийн туслахын албан тушаалын тодорхойлолтод shuukh.mn сайтад шүүхийн шийдвэр оруулах зохицуулалт байхгүй байх тул даруй шийдвэрлэх шаардлагатай.

Судалгааны ажил эхлэх үе буюу 2023 оны 4 дүгээр сард түүвэрт сонгогдсон аймгуудын цахим санд байршуулсан шийдвэрийн нийт тоо 603 байсан бол судалгааны ажлын явцад 637 болж нэмэгдэж байсан. Энэ нь журамд зааснаар “шүүхийн шийдвэрийг шүүгч гарын үсэг зурж албажуулснаас хойш ажлын арван өдрийн дотор цахим хуудаст байршуулах” зохицуулалт үйлчлэхгүй байх бөгөөд шүүгчийн туслахуудтай уулзалт хийх явцад шийдвэрээ дараа нөхөж оруулдаг талаар ярьсан юм. Цаашид хугацааны зохицуулалтыг журмаас хасах, эсвэл сайтад шийдвэр оруулах хугацааны тохируулга нэмэх хэрэгтэй.

2011 оноос хойш шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулж, олон нийтэд нээлттэй мэдээлэлдэг болсноос хойш одоогийн байдлаар 162,000 орчим шийдвэр нийтлэгдэж судалгаа шинжилгээний зорилгоор ашиглах бүрэн хэмжээний дата базз бүрэлдэж, шүүхийн шийдвэр нээлттэй ил тод байх, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг бэхжүүлэх гэх мэт олон ач холбогдлыг бий болгосоор байна. Хэдий шүүхийн шийдвэр ил тод байх зорилгодоо хүрч байгаа ч цахим санд шийдвэр байршуулахад техникийн, журмын алдаа гаргаж байгаа нь ач холбогдлыг багасгах,

шүүхийн үйл ажиллагааны ачааллыг нэмэх, хэрэгтэй шаардлагатай хэргээ хайж олох зэрэгт хүндрэл гарсаар байгаа. Шүүхийн шийдвэрийг хэдий хугацаанд цахим санд байршуулах талаар зохицуулалт байхгүй, цаашид ч шүүхээр маргаанаа шийдвэрлүүлсэн иргэдийн мэдээлэл нээлттэй байх тул дахин нууцлалыг хангуулж байршуулах хэрэгтэй.

Жишээ нь: Өвөрхангай аймаг дахь сум дундын ИХАШШ-ийн 2017 оны 09 сарын 21 өдрийн 145/2017/00114/И индекстэй хэрэгт “...2009 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр төрсөн хүү Сарантуяагийн Билгүүний төрсөн эцэг нь хариуцагч Баатар овгийн Нэргүйн Балжиннямын мөн болохыг тогтоосугай.” гэж ил тод харагдсаар байна. Хэдий “Цахим санд шийдвэр байршуулах журам” боловсронгуй болж, өмнөх шийдвэрүүдийн мэдээлэл энэ мэт харагдсаар байгаа нь илэрхий алдаа бөгөөд өмнөхөө засаж өөрчлөөгүй байж, шинээр хэдий сайхан журам баталж мөрдөөд ч ач холбогдолгүй.

Журмын хэрэгжилтийг хангах, цахим санд шийдвэр байршуулахын ач холбогдлыг нэмэхийн тулд хариуцлагын зохицуулалтыг шинээр оруулах шаардлагатай. Одоогийн мөрдөгдөж байгаа Цахим санд шийдвэр байршуулах журмын 10.1-д хариуцлагын заалтыг ерөнхий байдлаар оруулсан байна.

Цахим сайтад яг нэг төрлийн маргааныг бүгдийг байршуулж байгаа нь шүүхийн зохиомол ачааллыг нэмэгдүүлэх, хэргийн оролцогчийн нууцлалыг алдагдуулах эрсдэл гарч байгаа тул ижил төрлийн маргааныг зохицуулсан шүүхийн шийдвэрээс зөвхөн жишиг болохуйц нэг шийдвэрийг байршуулах нь зүйтэй байна. (Жишээ нь: Архангай аймгийн ИХАШШ-ээс Хөдөө аж ахуйг дэмжих сангийн ажлын албаны нэхэмжлэлтэй 32 маргааныг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 115 дугаар зүйлийн 115.2.3-д зааснаар шийдвэрлэсэн бөгөөд бүх шийдвэрээ цахим санд нийтэлжээ.)

Хэргийн оролцогчийн биеийн байцаалтад дурдсан овог, нэр, ам бүл, хөдөлмөр эрхлэлтийн байдал, нас, хүйс, гэр бүлийн байдал зэргийг хэрхэн нууцлах талаар нэгдсэн загвар гаргаж, бүх шүүхэд нэг стандартаар мөрдүүлж хэвшүүлэх журам гаргах шаардлагатай байх бөгөөд шүүхийн шийдвэрт хэргийн оролцогчийн мэдээллийн нууцлалыг

хангасан нь шийдвэрт дурдагдсан гэр бүлийн гишүүдийн мэдээллийг нууцлаагүй тохиолдол их байв.

Цахим сайтад шийдвэр байршуулдаг албан хаагчдыг дараах нөхцөл боломжоор хангах нь зүйтэй.

1. Сургалт зохион байгуулах, нэмэлт урамшуулал олгох, ажлын ачааллыг хөнгөвчлөх, ажлын байрны тодорхойлолтод сайт хариуцах ажлыг тусгах, эсхүл сайтад мэдээлэл байршуулах тусгайлсан орон тоо бий болгох,
2. Систем бүрдүүлж буй албан хаагч үг, үсэг, дүрмийн алдаагүй байх шаардлага, мэдээлэл оруулахад тавигдах хэлбэрийн шаардлага болон агуулгын алдаа гаргах, нууцлалын талаар тавигдах шаардлагыг зөрчихөөс сэргийлсэн санамж, зааварчилгаа гаргаж өгөх,

Цахим систем хөгжүүлэгч программ хангамжийг дараах байдлаар сайжруулах шаардлагатай.

1. Цахим санд маргааны төрлийг нэмэх, олон сонголттой болгох,
2. Сайт гацдаг, шийдвэр байршуулахад хадгалаагүй байдаг хэд хэдэн тохиолдлыг систем бүрдүүлэгчид хэлсэн тул сайтыг шинэчлэх,
3. Нууцлах шаардлагатай мэдээллийг ямар форматаар тэмдэглэх талаар нэгдсэн тэмдэглэгээ бий болгох,
4. Нэг шийдвэрийг олон удаа байршуулах боломжгүй тохиргоо хийх,

Одоо мөрдөн буй журмыг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.8 дахь хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.1.5 дахь заалт, 75 дугаар зүйлийн 75.2.2 дахь заалтыг үндэслэн баталсан бөгөөд хүчин төгөлдөр үйлчилж буй хувь хүний мэдээллийн нууцлалыг хамгаалах арга, хэлбэрийг цогцоор зохицуулсан нарийвчилсан хуулийн зохицуулалтыг үндэслэн батлаагүй нь учир дутагдалтай тул Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцүүлэн шинэчлэн батлах шаардлагатай.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Шүүхийн шийдвэрүүд 2013 онд олон нийтэд нээлттэй мэдээлэл болсноор шүүх эрх мэдлийн хүрээнд мэдээллийн нээлттэй ил тод байдлыг хангахад чухал алхам болсон билээ. 2024 оны байдлаар эрүү, иргэн, захиргааны анхан, давах, хяналтын шатны шүүхээс гарсан нийт 475 000 орчим шийдвэр цахим санд нийтлэгдэн өгөгдлийн санг бүрдүүлж байна. Нээлттэй Нийгэм Форум энэхүү нүсэр сангийн үйл ажиллагаанд хөндлөнгийн мониторинг хийх замаар шүүх эрх мэдлийн хүрээнд мэдээллийн ил тод байдлыг хангахад хувь нэмэр оруулах зорилгоор энэ удаагийн мониторингийг хийж гүйцэтгэлээ.

Мониторингийн бие даасан төсөл хэрэгжүүлсэн багийнхан тус тусын тайланд холбогдох дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулан танилцуулсан байгаа нийтлэг байдлаар дараах дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

1. Хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн мэдлийн боловсруулах, хэлэлцэх, батлах, хууль тогтоомжийн гүйцэтгэл, хэрэгжилтийг хангах зэрэг үйл ажиллагааны бүх ил тод, нээлттэй байдлыг хангах шаардлагатай байдгийн адил шүүх эрх мэдлийн үйл ажиллагаа (процесс)-г ил тод, нээлттэй болгох зарчим ч үйлчилдэг. Монгол Улсын хувьд шүүхийн шийдвэрийг ил тод болгохдоо нь зайлшгүй бөгөөд хориглосноос бусдыг нийтлэх (negative selection) аргыг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалттай.
2. Шүүхийн ерөнхий зөвлөл 2014 онд Шүүхийн шийдвэрийг нийтлэх журам баталж, түүнийг одоо үйлчилж байгаа 2022 онд шинэчилсэн болно. Шинэ журам нь агуулгын хувьд илүү тодорхой болж, зарим нэг харилцаанд тухайлбал, хувийн мэдээллийн хамгаалах, нууцлах шаардлагын үүднээс цахим санд нийтлэхгүй байх шүүхийн шийдвэрийн төрлийг тодорхойлохын зэрэгцээ цахим сан (www.shuukh.mn)-д байршуулах техникийн шаардлагыг нарийвчлан зохицуулсан байна. Шүүхийн шийдвэрийг интернэт орчинд ил тод болгох буюу нийтлэхдээ шүүхийн шийдвэрийн цахим санг нийтлэг

ашиглах болсон байх ба шүүх хуралдааны оролцогчдын аюулгүй байдал, төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах үүднээс зарим мэдээллийг хасаж, өөрчилж, товчлох болсон байна. Монгол Улсын хувьд мөн шүүхийн шийдвэрийн цахим сан (shuukh.mn)-г түгээмэл ашиглаж байгаагийн зэрэгцээ тойм байдлаар нийтлэх аргыг хэрэглэж байна.

3. Монгол Улсын хувьд шүүхийн шийдвэрийн цахим сан (shuukh.mn)-д хориглосноос бусдыг нийтлэх (negative selection) зарчмын дагуу шүүхийн шийдвэрүүдийг нийтэлсэн боловч мэдээлэл олж авахад чухал үүрэг гүйцэтгэдэг метадата буюу хайлт хийж хүссэн мэдээллээ тодорхойлох, илэрц дотроос дахин нарийвчилж хайх, тухайн шийдвэрийн утга, агуулгыг ойлгох, түүнтэй холбоотой бусад мэдээллийг тодруулах зэрэгт зайлшгүй хэрэгтэй байдаг талбар цөөн, мөн тухайн шүүхийн шийдвэрийг хайж олох түлхүүр үгийн талбар ажиллахгүй байгаатай холбоотой бэрхшээл үүсэж, энэ нь шүүхийн шийдвэрийг ил тод болгох зорилгыг гажуудуулахад хүргэж байна.
4. Шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдал, төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах үүднээс зарим мэдээллийг өөрчилж танигдахгүй болгохтой холбогдон үүсэх харилцааг хууль тогтоомжоор зохицуулаагүй харин журамд зарим “мэдээллийг тодорхойлох боломжгүй болгон нууцлах” талаар тусгасан ба практикт “од” (“**”) тэмдэглээг хэрэглэж журмын заалтын хэрэгжилтийг хангаж байгаа нь шүүхийн шийдвэрийг хэрэглэгчдэд ойлгомжгүй, ашиглахад бэрхшээлтэй болгож байна.
5. Журмын 5.2.1-д заасан шүүхийн шийдвэрт дурдсан хүн хуулийн этгээдийн нэр регистрийн дугаар гэх мэт нууцлал бүхий мэдээллийг тодорхойлох боломжгүй болгон нууцлах гэсэн зүйл заалт хамгийн их зөрчигдсөн байсан бөгөөд хайхрамжгүй байдал, ачаалал гэх хариулт их давтагдсан бол нууцлах үгийг оруулдаг боловч программын гацалтаас шалтгаалан нууцлагдахгүй байх тохиолдол гардаг, нууцлах хэсэгт нууцлах үгнүүдээ оруулсан боловч зарим нь нууцлагдаагүй, “тийн ялгал”-ын нөхцөлүүд залгасан тохиолдолд орхигдох магадлалтай байдаг зэрэг шалтгаан дурдаж байв. Иймд Хүний хувийн мэдээллийг нууцлах арга зүйг агуулсан нарийвчилсан зохицуулалт шаардлагатай байна.

6. Монгол Улсын хувьд шүүхийн шийдвэрийн цахим сан (www.shuukh.mn) нийтэлсэн шүүхийн шийдвэрүүдийг шүүхийн харьяаллаар ангилахын зэрэгцээ захиргааны хэргийн хувьд маргааны төрлийг баримжаа болгож ангилсан нь нийтлэг жишигт нийцэж байх боловч хэт ерөнхий, маргааны цөм төрлийг илэрхийлж чадахгүй байна.
7. Шүүхийн шийдвэрийг шүүгч албажуулснаас хойш 14 хоногийн дотор цахим санд нийтэлдэг журмын зохицуулалтыг 3 хоногийн дотор нийтэлдэг байхаар өөрчлөх, тодруулбал шүүхийн практикийг харгалзан үзэх тухай хуулийн заалт үйлчилж эхэлсэн тул шүүхийн практиктай даруй танилцах боломжийг иргэн, хуулийн этгээдэд олгох ёстой;
8. Монгол Улсын хувьд шүүхийн шийдвэрийн цахим сан (www.shuukh.mn) нийтэлсэн шүүхийн шийдвэрүүдийг маргааны төрлөөр ангилахын зэрэгцээ илүү нарийвчлах зорилгоор дэд төрөл үүсгэх (тухайлбал, маргааны төрөл: газар. Дэд төрөл: газрын төлбөр, газар эзэмших эрхийн хугацаа гэх зэрэг).
9. Орхон аймгийн хувьд шүүхийн тамгын газраас ирүүлсэн тоо нь 36 байсан бол цахим санд байршуулсан хэрэг нь 215 байсан. Уг асуудлаар шүүгчийн туслахуудаас тодруулж асуухад, системийн гацалт их байдаг, үүнээс болж хэргүүд маш их давхардаж ордог талаар ярьсан.
10. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль батлагдсантай холбоотой хэргийн холбогдогчдод шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах талаар мэдэгдэж гарын үсэг зуруулж, зөвшөөрөл бол авах зохицуулалт тэр бүр хэрэгждэггүй нь харагдлаа.
11. Гадаад улс орнуудын туршлагаас үзэхэд шүүхийн шийдвэрүүдийг ил тод болгохтой холбоотойгоор (1) шүүхийн шийдвэрийн цахим санд байршуулсан шийдвэрийг ашиглахад ямар нэгэн хязгаарлалт байхгүй, (2) шүүхийн шийдвэрийн цахим санд байршуулсан шийдвэрийг ашиглахад тодорхой хязгаарлалттай, өөрөөр хэлбэл лиценз буюу зөвшөөрөл авахыг шаарддаг, (3) шүүхийн шийдвэрийн цахим санд байршуулсан шийдвэрийг арилжааны зорилгоор ашиглахыг хориглож байна. Монгол Улсын хувьд шүүхийн шийдвэрийн цахим сан (shuukh.mn)-д нийтэлсэн шүүхийн шийдвэрийг ашиглахад ямар нэгэн хязгаарлалт байхгүй байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Мониторингийн багууд өөрийн хийсэн судалгааны цар хүрээнд үндэслэн дараах санал, зөвлөмж дэвшүүлжээ. Үүнд:

1. Шүүхийн шийдвэрийг ил тод болгохтой холбогдон үүсэх харилцаа нь аюулгүй байдал, төр, байгууллага, хувь хүний нууцтай шууд холбоотой тул эл харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай бөгөөд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуульд нийцүүлэх;
2. Шүүхийн шийдвэрийн ил тод байдал нь түүний ил тод байдлыг хангаж буй цахим хуудастай салшгүй холбоотой тул шүүхийн шийдвэрээс мэдээлэл олж авахад чухал үүрэг гүйцэтгэдэг мета датаг боловсронгуй болгох, мөн тухайн шүүхийн шийдвэрийг хайж олох түлхүүр үгийн тохиргоог бий болгож хэрэглэнд оруулах;
3. Шүүхийн шийдвэрийн цахим сан (shuukh.mn)-д нийтэлж байгаа шийдвэрүүдийн хураангуй хувилбар буюу тоймыг нийтлэх;
4. Шүүхийн шийдвэрийг шүүгч албажуулснаас хойш 14 хоногийн дотор цахим санд нийтэлдэг журмын зохицуулалтыг 3 хоногийн дотор нийтэлдэг байхаар өөрчлөх, тодруулбал шүүхийн практикийг харгалзан үзэх тухай хуулийн заалт үйлчилж эхэлсэн тул шүүхийн практиктай даруй танилцах боломжийг иргэн, хуулийн этгээдэд олгох;
5. Шүүхийн шийдвэрийг хэрэглэж, ашиглахад ойлгомжтой хялбар болохын тулд цахим санд нийтлэхдээ хэргийн оролцогч болон бусад оролцогчийн овог, нэрийн эхний үсгээр товчилсон байдлаар нийтлэх;
6. Монгол Улсын хувьд шүүхийн шийдвэрийн цахим сан (www.shuukh.mn) нийтэлсэн шүүхийн шийдвэрүүдийг маргааны төрлөөр ангилахын зэрэгцээ илүү нарийвчлах зорилгоор дэд төрөл үүсгэх (тухайлбал, маргааны төрөл: газар. Дэд төрөл: газрын төлбөр, газар эзэмших эрхийн хугацаа гэх зэрэг);
7. Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах ёстой шүүгчийн туслахын албан тушаалын тодорхойлолт, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд shuukh.mn сайтад мэдээлэл оруулах талаар тухайлсан зохицуулалтыг оруулж, нэг мөр болгох, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс

2020 оны 4 дүгээр сард баталсан шүүгчийн туслахын албан тушаалын тодорхойлолтод shuukh.mn сайтад шүүхийн шийдвэр оруулах зохицуулалт байхгүй байх тул даруй шийдвэрлэх;

8. Мониторингийн эхлэх үед цахим санд байршуулсан өнгөрсөн оны шийдвэрийн нийт тоо ажлын явцад нэмэгдэж байсан нь журамд зааснаар “шүүхийн шийдвэрийг шүүгч гарын үсэг зурж албажуулснаас хойш ажлын арван өдрийн дотор цахим хуудаст байршуулах” зохицуулалт тэр бүр үйлчлэхгүй байгааг харуулж буй тул энэхүү хугацааны зохицуулалтыг эргэн харах;
9. Журмын хэрэгжилтийг хангах, цахим санд шийдвэр байршуулахын ач холбогдлыг нэмэхийн тулд хариуцлагын зохицуулалтыг шинээр оруулах;
10. Хэргийн оролцогчийн биеийн байцаалтад дурдсан овог, нэр, ам бүл, хөдөлмөр эрхлэлтийн байдал, нас, хүйс, гэр бүлийн байдал зэргийг хэрхэн нууцлах талаар нэгдсэн загвар гаргаж, бүх шүүхэд нэг стандартаар мөрдүүлж хэвшүүлэх журам гаргах;
11. Цахим сайтад шийдвэр байршуулдаг албан хаагчдыг сургах, техник алдаа гаргах, нууцлалын талаар тавигдах шаардлагыг зөрчихөөс сэргийлсэн санамж, зааварчилгаа гаргаж өгөх, нэмэлт урамшуулал олгох, ажлын ачааллыг хөнгөвчлөх, ажлын байрны тодорхойлолтод сайт хариуцах ажлыг тусгах, эсхүл сайтад мэдээлэл байршуулах тусгайлсан орон тоо бий болгох
12. Цахим систем, программ хангамжийн хувьд маргааны төрлийг нэмэгдүүлэх, сайтыг гацалт, хадгалах функцийг алдааг засах, нууцлалын формат, тэмдэглэгээг бий болгох, нэг шийдвэр дахин нийтлэгдэхээс сэргийлэх тохиргоо бий болгох зэрэг шинэтгэлийг яаралтай хийх шаардлагатай.

Түүнчлэн мониторингийн гурван төслийн үр дүнд үндэслэн дараах ерөнхий санал, зөвлөмжийг танилцуулж байна. Үүнд:

1. Шүүхийн шийдвэрийн цахим сангийн өгөгдөлд бүрэн хэмжээний мониторинг хийх нь ажлын цар хүрээний хувьд хэт өргөн, тухайн өгөгдлийг хөндлөнгөөс олж авахад амаргүй байна. Тиймээс шүүхийн захиргааны хувьд нэгдсэн статистикийн мэдээлэл болон цахим

сангийн мэдээллийг харьцуулан харах боломжтой мета түвшинд нэгтгэх;

2. Цахим сангийн үйл ажиллагааг тогтмол сайжруулж, техникийн алдааг засаж байх үүднээс хөндлөнгийн коммент санал авах суваг нээж, алдаа мэддгийг цаг алдалгүй засаж сайжруулдаг практик бий болгох;
3. Шүүхийн шийдвэрийн нийтлэлийн хувь бага байгаад шүүх тус бүрээр дүн шинжилгээ хийж, зохих зохион байгуулалт, хүний нөөцийн дэмжлэг чиглэл үзүүлэх;
4. Шүүхийн шийдвэрийн хайлтын системийг тогтмол сайжруулах буюу системийн хөгжүүлэлтийг тогтмолжуулах;
5. Шүүхийн шийдвэрийн нууцлалын журмыг нарийвчилж, арга зүйн нэгдсэн удирдамжаар хангах шаардлагатай.
6. Шүүхийн шийдвэрийн цахим сангийн үйл ажиллагааг бодлого, удирдамжаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих, холбогдох сургалт хийж хүний нөөцийн дэмжлэг үзүүлэх чиглэлээр бүтэц бий болгон ажиллах нь зүйтэй гэсэн саналтай байна.